

2

АНАТОЛЬ ФРАНС



Ундаассан
Бурхад

Улаанбаатар

2

АНАТОЛЬ ФРАНС



Ундаассан
Бурхад

Улаанбаатар

АНАТОЛЬ ФРАНС

УНДААССАН БУРХАД - 2
(12-29)

“УЛСЫН ХЭВЛЭЛИЙН ГАЗАР” Улаанбаатар хотноо 1969 онд эрхлэн
хэвлүүлсэн номоос

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар Цагаан бамбарууш хэвлэлийн
газарт 2022 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: www.e-nom.mn

-

*

**

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.

Б
БОЛОР ДУРАН 2.0
АЛДАА ШАЛГУУР

**“БОЛОР ДУРАН”
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР
БОЛОР

УНДААССАН БУРХАД

Les dieux ont soif

XII

Нэгэн орой өвгөн Бротто, Хуулийн гудамж дахь мухлагийн эзэн иргэн Кайюд зуун дөчин дөрвөн цаасан бүжигчдээ авчирч өгөхөд ихэвчлэн эелдэг найрсаг байдаг байсан тоглоомын наймаач маань хүүхэлдэй, нааданхайнуудынхаа дунд зогсчихсон түүнийг нэлээд төдгүй угтав.

— Болгоомжил, иргэн Бротто болгоомжил! Үргэлж наадам тохуу хийх цаг биш, хошигнол бүр зохистой биш. Манай секцийн нийгмийг аюулаас хамгаалах хорооны гишүүн өчигдөр үүгээр ороод гарахдаа таны бүжигчдийг үзээд хувьсгалд харшилж байна гэсэн хэмээн түүнийг ам нээхэд Бротто

— Тэр тоглосон байлгүй гэж хариулав.

— Ээ дээ тийм биш дэг, та минь, ээ дээ тийм биш дэг. Тэр тоглоом наргианд дургүй хүн. Энэ дүрснүүдээрээ үндэстний төлөөлөгчдийг шууд доромжилж үүний заримаар нь Кутен, Сен - Жюст, Робеспьер нарыг шоолжээ гэдэг нь тодорхой танигдаж байна гээд тэр хураагаад авчихсан. Энэ нь надаас цэвэр гарз гарч байгаа хэрэг, за тэгээд надад учирч мэдэх аюулыг ярихын хэрэг үгүй л дээ.



— Юу? Хагас зууны өмнө Бушегийн зурж байсанчлан миний зурж байгаа Арлекин, Жила, Скарамуш, Колен, Колетт маань Кутон, Сен - Жюст нартай адилхан байна гэнээ. Үүнд эрүүл ухаантай ганц ч хүн итгэхгүй.

— Та хорон санаа агуулаагүй байж болно л доо, гэхдээ таны мэтийн хурц ухаантай хүмүүст болгоомжтой хандахад хэзээ ч илүүдэхгүй. Энэ бол галаар наадаж байна гэсэн үг. Энүүхнээсээ жишээ аваад л хэлэхэд уржигдар Елисейн тал дахь театрын эзэн Нутуаляг,

Полшинелээрээ Конвентыг шоолж байна гэж ял тулган итгэлгүй хүн хэмээн баривчилсан шүү дээ гэж татгалзваас

— Энэ баг, энэ нүүрийг ахиад нэг хараач гээд Бротто бүжигчин хүүхэлдэйнүүдээ бүтээсэн даавууг сөхөн эд чинь инээдмийн жүжиг, малчны амьдралыг харуулсан жүжгийн баатрууд биш гэж үү? Иргэн Кайю намайг Үндэсний Конвентыг элэглэж байна гэж яаж үнэмшээв? гэв.

Бротто мэл гайхжээ. Хүний тэнэгт хязгаар байдаггүй гэж мэдэх боловч тэрээр Скарамуш Коленетт нь хэн нэгэн хүнд сэжиг төрүүлнэ гэж ер санасангүй. Тэгээд тэр буруугүй гэдгээ батлан хүүхэлдэйгээ хамгаалав. Гэсэн ч иргэн Кайю тэр тухай сонсохыг ч хүссэнгүй.

— Хүүхэлдэйнүүдээ аваад явж үз, иргэн Бротто. Би таныг хүндэлдэг их үнэлдэг билээ. Хэдий тийм боловч танаас болж хараалган, амгалан байдлаа алдахыг хүсэхгүй байна. Би хуулийг хүндэлдэг. Би бүрэн итгэлт иргэн байхыг, тэгж тооцогдож явахыг хүснэ. Иргэн Бротто, баяртай! Бүжигчдээ ав!

Өвгөн Бротто савааны үзүүрт хүний оронцгуудаа өлгөн мөрөн дээрээ тавиад гэр лүүгээ явах замд нь хүүхдүүд түүнийг үхэр хулганын хор худалдагч гэж санан даажин хийж байлаа. Сэтгэл нь нэг л тавгүй. Дан ганц хүүхэлдэй хийж ч амь зуудаггүй л дээ. Дааман хаалган дор, зах зээлийн зооринд тэрээр «нэхмэлчдийг» тойруулан хорин сүгээр нэг хөрөг зурдаг бөгөөд зүрхнийхээ амрагт зургаа үлдээх гэсэн цэрэгт явж буй залуус л голдуу захиалга өгнө. Энэ яльгүй ажил түүний ойг гутаахын дээр бас хөргөө цаасан хүүхэлдэй шиг аятайхан болгохын тул ихээхэн мэрийж зурах хэрэг гарна. Заримдаа захын наймаач авгай нарт юм бичиж өгөх боловч энэ нь рояльчуудын хуйвалдаанд урхидуулж мэдэх ихээхэн амь дүйсэн ажил байлаа. Вандомын талбайгаас холгүй орших Невде -Пити - Шан гудамжинд өөр нэг тоглоомын наймаачин иргэн Жоли суудгийг санаад маргааш л Кайюгийн авч зүрхлээгүй барааг өгөхөөр шийдэв.

Бороо шивэрч эхэллээ. Бүжигчдээ норгочих вий хэмээн эмээсэн Бротто шуурхайлан алхав. Хүн амьтангүй баргар Шинэ гүүрээр гараад Тионвиллийн талбай руу эргэх гэтлээ тэрээр, жижиг ширмэн дээр сууж байгаа туранхай өвгөнийг дэнлүүний гэрэлд үзэв. Өлсөж ядраад, эцэж турсан тамтаг болсон цув өмссөн толгой нүцгэн тэр хүн ямар ч гэсэн нэрэлхүү төрх намбаа алдсангүй агаад харахад жар орчим настай болов уу гэмээр. Хувь зохиолгүй тэр хүнд дөхөж очсон Бротто, хагас

жилийн өмнө Иерусалимын гудамж дахь талхны мухлагт «сүүлэнд» зогсож байхдаа амийн нь аварсан эцэг Лонгмар мөнийг танив. Тэгэхэд гэлэнд нэг удаа тус болсон нь одоо Броттог Лонгмар лүү очин, өлсгөлөнгийн үед талх өгөхийг хүлээсэн олны дунд хамт зогсож байсан нөгөө зэд хураагч чинь би байна гэж сануулан. ямар нэг туслалцааны хэрэг бий юу хэмээн асуухад хүргэв.

— Эцэгтэн минь, та их алжаасан бололтой. Жаахан тэнхэрвэл зохино.

Тэгээд Лукрецийн ботитой хамт авч явсан бяцхан шилэн савтай архийг хүрэн сюртукнийхээ хармаанаас гаргаж ирлээ.

— Балгачих. Гэртээ харихад тань тусалъя.

Лонгмар, шилэн савыг түлхээд босох гэж оролдсон боловч тэр дороо шон дээр эргэж суув.

— Ноёнтон минь, Пикпюст суудаг болсоор гурван сар өнгөрлөө. Өчигдөр үдээс хойш таван цагт намайг баривчлахаар ирж гэдгийг мэдээд би гэртээ харьсангүй. Надад толгой хавчуулах газар алга учир гудамжаар хэрсээр жаал ядарчээ гэж дорой атлаа итгэлтэй хоолойгоор өгүүлбэл Бротто

— Тэгвэл, эцэг минь, манайд дээврийн хонгилд минь очиж болгоох сон болов уу гэж гуйя гэлээ.

— Ноёнтон минь, ойлго, би хараанд орчихсон хүн шүү дээ гэж Варнавчийг татгалзсанд Бротто

— Би ч гэсэн, бас миний хүүхэлдэйнүүд ч гэсэн түүнээс чинь бүр долоон дороо. Энэ бороонд норон бид хоёрыг чичирч байхад энэ муу даавуун дор бүжигчид маань хэвтэж байна. Эцэг минь, зэд хураагч байсныхаа дараа тоглоом хийж талхаа олж идэж байгаа гэдгээ танд хэлэх хэрэгтэй гэж хариулав.

Хуучин санхүүчийн ийнхүү гар сунган зочирхгоор урин залж байгааг эцэг Лонгмар хүлээн авлаа. Ямбалж сурсан хүн болохоор Бротто дээврийнхээ хөндийд очоод түүнийг бяслаг, талх, хөргөх гэж усны хоолойд хадгалсан архиараа дайлав.

— Ноёнтон минь гээд гол орсон Лонгмар ярьсан нь, — Миний зугтах болсон, шон дээр сууж байхдаа тантай дайралдсан тэр гунигт байдалд хүргэсэн шалтгааныг би танд ярих ёстой. Сүмээс хөөгдсөнийхөө дараа би зохион байгуулах хурлын олгож байсан өчүүхэн тэтгэврээр өл залгаж байлаа. Би латин хэл, тооны хичээл зааж, францад сүм хийдийг хэрхэн мөрдөн хавчиж байгаа тухай товхимол

бичиж байлаа. Лам нарын үндсэн хуульд тангараг өргөсөн нь сүмийн шагшаабадад таарахгүй байна гэдгийг батлах зорилгоор нэлээд зузаан ном бичсэн. Хувьсгалын амжилт надаас бүх шавь нарыг минь салгасан, гэтэл бас хуулиас шаардаж байгаа иргэний итгэмжлэх бичиггүй учир тэтгэмж өгөхөө болив. Тэгээд энэ үнэмлэхийг авах ёстой хүн гэж гүнээ итгэн захиргаа руу очлоо. Ромын иргэн гэдэгтээ бахархдаг гэгээн Павелын байгуулсан холбооны гишүүн болохоороо би бурхны хууль ёсонд харшилдаггүй хүн төрөлхтний бүхий л хуулийг хүндэтгэн үздэг францын сайн иргэний жишээгээр яваа гэдэг найдлагаар сэтгэлээ тэжээж байж билээ. Иймэрхүү үнэмлэх олгох явдлыг эрхэлдэг, хотын захиргааны түшмэд хиам худалдагч ноён Коленд эрэлт хүсэлтээ толилуулсан. Тэр миний мяндаг тушаалыг асуухад би лам хүн гэдгээ хэлсэн. Тэгэхэд тэр миний эхнэртэй эсэхийг лавлаж, үгүй гэдэг хариу сонсмогцоо энэ чинь маш муу даа гэлээ. Тэгээд надаас өдий төдий юм шалгаасны эцэст найман сарын арван, есөн сарын хоёрон, таван сарын гучин нэгний өдрүүдэд эх оронч үзэлтэй гэдгээрээ шалгарсан уу гэж асуув. «Иргэний итгэмжлэх бичгийг тэр өдрүүдэд эх оронч үзэлтэйгээ харуулсан хүмүүст л олгож байгаа юм» гэж тэр нэмж хэллээ. Миний өгсөн хариу сэтгэлийг нь хангасангүй ээ. Түүгээр ч үл барам нэр усыг минь хаягтай хамт тэмдэглэж аваад ойрын үед зохих магадалгаа хийнэ гэж тэр хэлсэн юм. Тэгээд ч хэлсэн үгэндээ хүрч магадалж үзсэний эцэст тэр Нийгмийг аюулаас хамгаалах пикпюссийн хорооны хоёр комиссар, зэвсэгт хүмүүс дагуулан намайг шоронд хийхээр эзгүйд минь манайд иржээ. Ямар хэрэг хийлээ гэж намайг яллах гэж байгааг бүү мэд. Хэрвээ ноён Колен, шашны төлөөлөгчийг найман сарын арван, есөн сарын хоёрон, таван сарын гучин нэгний өдрүүдэд эх оронч үзэлтэй гэдгээ харуулж чадаагүй гэж буруушааж байгаа бол тун ухвар мөчид хүн байна. Тэгэхлээр түүнийг өрөвдөлгүй болохгүй гэдгийг зөвшөөр. Тиймэрхүүгээр бодож сэтгэдэг хүмүүс үнэхээрийн өрөвдмөөр гэхэд нь

— Надад ч гэсэн үнэмлэх байхгүй. Та бид хоёр хоёулаа сэжиглэгдэж байна. Гэвч эцэг минь та чилээрхжээ. Унтаж амар. Таныг яаж найдвартайхан төвхнүүлэх талаар маргааш ярилцамз гэж хариулав.

Бротто, гийчиндээ гудсаа тавьж өгөөд өөрөө сүрлэн дэвсгэр дээрээ хэвтэхээр завдан байтал гэлэн сүрлэн дэвсгэрээ өгөөч гэж шаргуу шалсанд Бротто гуйснаар нь болгохоос өөр замгүй болсон агаад тэгэхгүй бол Лонгмар нүцгэн шалан дээр хэвтээд өгөх байлаа.

Ороо засаж дуусаад Бротто лаагаа гамнан мөнхүү болгоомжлон үлээв.

— Ноёнтон минь миний тулд хийж байгаа бүхнийг чинь ухамсарлаж байна. Гэвч юугаар ч ачийг тань хариулж чадахгүй минь харамсалтай. Бурхан таныг үргэлж ивээх болтугай. Энэ нь таны хувьд арай бүтэмжтэй байх биз. Гэвч бурхан өөрийн нь алдар нэрийн тулд хийгээгүй, зөвхөн буян үйлдэх төрөлх чанарын илрэл болсон зүйлийг гавьяа гэж үздэггүй юм. Иймээс ноёнтон минь миний төлөө хийх гэж санасан юмаа түүний тулд хийнэ үү гэж гуйя хэмээн гэлэнгийн хэлбээс

— Эцэг минь ачийг бодох гэж биеэ бүү чилээ, надад тал өгөх хэрэггүй. Таны хэт үнэлж байгаа энэ бүх зүйлийг би танд хайртайдаа хийж байгаа юм биш. Тэгээд ч хэдийгээр та сэтгэлд дулаахан санагдах боловч хайрлая гэхэд би таныг мэдэхгүй шахуу шүү дээ. Дон - Жуан шиг хүн төрөлхтөн ямар нэг эрхтэй байна гэж санах тийм гэнэн хүн бишээ би. Тэр ч байтугай тийм эрдэм номтой хүн мухар заншилтай байна гэдэг урмыг минь хугалж байгаа юм. Тэгэхлээр хүн төрөлхтөнд хайртайдаа ч ингэж байгаа юм биш. Сайхан баатарлаг үйл бүтээхийг хүнд сургамжлан алив гай гамшиг дунд биеэ таньдаг, бусдын зовлонгоос өөрийнхийгөө хардаг өөртэй нь хувь зохиол төрөлх чанараараа эгээ адилхан дотно хүндээ тус дэмжлэг үзүүлдэг, үүгээрээ агтын хариу жилдээ, аяганы хариу өдөртөө гэдгийг мэддэг болгогч хар амиа бодохын үүднээс л үүнийг хийж байгаа юм. Амьдрал маань өнгө жавхаагаа бүрэн алдсан болохоор ямар ч үнээр хамаагүй үүнийг мартагнах хэрэгтэй, мөн өглөгч байна гэдэг өөр хийчихмээр аятайхан юм олдохоо больсон үед л эрхлэх тун базаахгүй зугаа билээ. Иймээс би хийх юм олж ядсандаа ингэж байгаа юм. Би бардам зантайдаа мөн танаас давуу байхын тул ингэж байгаа юм. Эцэст нь дэглэм журамд дуртайдаа мөн бурхангүй хүн юу чаддагийг танд үзүүлэхийг хүссэндээ би ингэж байгаа юм гэсэнд эцэг Лонгмар

— Ноёнтон минь биеэ бүү гүжирд. Би бурхан тэнгэрээс энэ өдөр түүний танд хайрласнаас нь ч их хишгийг хүртсэн. Гэвч би тантай мөр зэрэгцэхгүй танаас аль ч талаараа дутуу. Хэдий тийм боловч танаас давуутай нэг тал надад байна гэдгийг хэлэхийг минь зөвшөөрнө үү. Намайг мэдэхгүйгээр та намайг хайрлаж чадахгүй байж. Тэгвэл би ноёнтон минь таныг мэдэхгүй мөртөө танд өөрөөсөө илүү хайртай. Ингэ гэж тэнгэр бурхан лүндэн буулгаж байна гэж хариулав.

Ийнхүү ярингаа эцэг Лонгмар сөхрөн сууж уншлагаа уншсанаа
сүрлэн дэвсгэр дээрээ хэвтээд тайван гэгч нойрслоо.

XIII

Эварист Гамлен хоёр дахь удаагаа Онц шүүхийн хуралд оролцлоо. Хуралдаан эхлэхийн өмнө тэрээр шүүхийнхээ нөхөдтэй өглөө авсан сонин мэдээний тухай ярилцав. Эдэн дотор эндүү ташуу юм байвч эргэлзээгүй үнэн мэдээ нь аймшигтай байлаа. Холбоотны арми, Парисын бүх замыг эзлэхээр нэгэн зэрэг довтолж байв. Вандей дийлж, Лион босож арван дөрвөн мянган хүнтэйгээ бүслэгдсэн Тулон Англичуудын гарт оржээ.



Энэ нь төлөөлөгчдийн хувьд дэлхий нийтийн ажиглаж байсан хэрэг явдлаар зогсохгүй тэдэнд өөрсдөд нь шууд хамаарах баримт сэлт байлаа. Эх орон сөнөвөл өөрснөө үхнэ гэдгийг сайн мэддэг тэр төлөөлөгчид улсын хэргийг аминых лугаа адил үзэж байв. Хувийнхтай хослуулсан үндэстний ашиг сонирхол нь үнэн сэтгэлээсээ шуналтай ажиллахыг тэднээс шаардаж байлаа.

Гамлен суудалдаа суусан хойноо цэргийг шүү, дариар хангах секцийн комиссараар түүнийг томилсон тухай мэдэгдсэн захиаг Батлан хамгаалах хорооны нарийн бичгийн дарга Трюберээс авав.

«Чи дарь бэлтгэхэд зайлшгүй хэрэгтэй бүх бодисыг гаргаж авахын тул секцийнхээ хүрээний бүх зоорийг нэгжиж үз. Дайсан маргааш Парисын хаяанд тулан ирж болзошгүй. Иймээс эх орны маань хөрс шороо хүртэл дайсныг ниргэх аянга бий болгог. Мөн шүү найруулах багажийн зохион байгуулалтын тухай Конвентын зааврыг явууллаа. Ах дүүгийн мэнд хүргэе» гэжээ.

Энэ үед хэрэгтнийг оруулж ирлээ. Энэ бол Конвентоос шүүхэд шилжүүлсэн, дайсанд бут цохигдсон сүүлчийн генералуудын нэг

бөгөөд тэдний хамгийн өчүүхэн нь ч байж мэднэ. Түүнийг хармагцаа Гамлен цочив. Гурван долоо хоногийн өмнө Гамленийг үзэгчдийн суудалд сууж байхад шүүн, цаазын газар илгээсэн нөгөө нэг цэргийн хүн шиг санагджээ. Энэ бол яг л тиймэрхүү зөрүүд богино ухаантай хүн байлаа. Энэ бол яг л тиймэрхүү шүүхийн ажиллагаа байлаа. Ялтан өөртөө хамгийн хожоотой өчгөө ч гэсэн баллачихаар зөрүүд догшин хариулах ажээ. Өө эрэх, үгээрээ залилах, хийсэн буруугаа доод тушаалынхан руугаа түлхэх зэрэг нь түүний нэр төр, амь насныхаа төлөө биелүүлж байсан хүндэт зорилгыг нь халхалж байлаа. Тэр хэргийн бүх юм нь бүрхэг маргаантай бөгөөд армийн байрлал, цэргийн тоо, байлдааны сэлбэг хэрэгслийн хэмжээ, авсан тушаал, өгсөн тушаал. ангиудын шилжих байрлал зэрэгт тодорхой юм нэг ч үгүй ажээ. Будилаантай, бодлого зорилгогүй сүйрэлд хүргэсэн дайны энэ ажиллагаанаас хэн ч юу ч үл ойлгоно. Өмгөөлөгч хэрэгтэн хүртэл өөрсдөө үүнийг ухаарах талаар яллагч, шүүгч ардын төлөөлөгч нараас дээрчлэх юмгүй атлаа эдний хэн ч үүнийг ойлгохгүй байгаагаа бусдад ч, өөрөө ч ил эс хэлэх нь жигтэйхэн. Шүүгч нар илтэд хангалуун байртай төлөвлөгөөг онгичин тактик стратегийн асуудлыг хэлэлцэх бөгөөд ялтан нь төрөлхийн өө сэв хайх авьяасаа гаргаж байв.

Эцэс төгсгөлгүй зөрөлдөх ажээ. Гэтэл ийнхүү цэц булаалдан байх үед умардын энхэл донхол замаар хайрцагтай сум шаварт шигдэн суваг шуудуу уруу их буунууд онхолдон бут цохигдсон цуваанууд амь зулбан дөрвөн зүг зугтан онгойсон зам болгоноор дайсны морьт цэрэг цутган орж ирэх мэт Гамлены сэтгэлд ургав. Жанжид нь урвасан армийн аймшигтайяа бархиралдах, энэ генералыг зэмлэн орилох дуун чихэнд нь сонстох шиг болов. Маргаан зөрөөн шувтрах үед танхимд хэдийнээ харанхуй болж даргын толгой дээрх Маратын цайрах баримал чөтгөрийн гал шиг цайвалзан байлаа. Төлөөлөгчдийн санал зөрлөө. Гамлен бөглүү бачуу авч шийдвэр төгс дуугаар ялтан, бүгд найрамдах улсаас урвасан хэрэг хийжээ гэж мэдэгдэхэд цуглагсад сайшаан шивэр авир хийсэн нь залуу эрийн энэ зүтгэлийг үнэлсэн хэрэг.

Бамбарын гэрэлд ялын тогтоолыг уншиж сонсгоход түүний хөлс чийхарсан хавчиг чамархайд нь багир улаан туяа тусан бүжиглэнэ. Үүдний дэргэдэх шатны гишгүүр дээр бужигнах оройвч малгайдаа тэмдэг хадсан биеэ оторлогч хов жив хөөцөлдөгч хүүхнүүдийн амнаас нэр нь гарахыг Гамлен дуулав. Түүний нэр Онц шүүхэд ирэгсдэд

хэдийнээ танил болжээ. Бөөн «нэхмэлчид» түүний замыг хаан австри хүүхнийг цаазал гэж нударга занган шаардав.

Маргааш нь Гамлен Мейрон гэдэг талх тушаагч нэгэн ядуу бэлэвсэн эмэгтэйн зэмтэй эсэх талаар саналаа хэлэв. Тэрээр бараагаа түрдэг тэргээр зөөн бүсэндээ зүүсэн модон самбар дээр хэрчлээс тавин зарсан талхныхаа тоог тэмдэглэдэг байжээ. Тэгээд тэр өдөрт найман су олно. «Ван мандтугай!» гэж нэг бус удаа хашхирсан өдөр бүр талх хүргэж өгдөг байшингууддаа хувьсгалын эсэргүү утгатай яриа хийж, Капетын эхнэрийг оргон босоход туслах зорилготой хуйвалдаанд оролцсон бололтой энэ ядуу эмэгтэйд олон нийтийн яллагчийн туслах хачин ширүүн хандав. Шүүгчийн байцаахад тэрээр энгийн л нэг юм уу эсвэл мухар сүсэгтэйгээс тэр юм уу өөртөө тулгаж буй хэргийг хүлээж роялчуудад талтай гэдгээ хэлээд толгой руугаа ус хийчих нь тэр.

Хувьсгалт шүүх нь ачаа ачигчид, зарц хүүхнүүдийг язгууртнууд санхүүчдийн адил хатуу залхаан цээрлүүлж, эрх тэгш ёсны үзэл санааг ялуулахыг эрмэлзэнэ. Ардчилсан дэглэмийн үед энэ нь үүнээс өөр байж үл болно хэмээн Гамлен санадаг билээ. Хэрвээ ард түмнийг шийтгэхгүй бол тэднийг гутамшигтайгаар басамжилж байгаа хэрэг гэж тэр тооцох байсан. Энэ нь ард түмнийг шийтгэлд тэнцэшгүй гэж үзсэн хэрэг болно. Гагцхан язгууртнуудад зориулж гильотиныг байлгах нь шударга бус онцгой ямба тогтоосонтой ижилхэн гэж тэр санадаг билээ. Гамлены нүдэнд гэсгээх үзэл санаа нь шашны далдыг шүтсэн өнгийг олж энэ нь ямар нэг ашигтай ямар нэг сайн талтай юм шиг бодогдоно. Залхаан цээрлүүлнэ гэдэг бол гэмт этгээдүүдийн хувьд байвал зохих зүйл бөгөөд үүнээс нь салгана гэдэг тэдний эрхийг хассан хэрэг болно гэж Гамлен үзэж байв. Бэлэвсэн авгай Мейрон буруутай, цаазлуулах ёстой хүн гэж тэрээр мэдэгдсэн боловч хөөрхийн толгойг цусадсан түүнээс ч их гэмтэй мухар сүжигтнүүд чөлөөтэй үлдэж лай ланчгийг нь хуваалцахгүй байгаад өрөвдөх сэтгэл төрж билээ.

Орой болгон шахуу Эварист, Оноре гудамж дахь хар ярианд «якобины» гэж нэршсэн доминиканы хуучин сүмд болдог якобинчуудын хуралд очдог байв. Эрх чөлөөний мод гэгддэг, навчис нь үргэлж сэрчигнэн чичирч байдаг улиангар ургасан хашаанаа нүцгэн нуруутай хүнд вааран дээвэртэй үзэмжгүй дүнсгэр тэр сүм оршино. Нүүрэн тал нь олон жижиг гэгээвчтэй агаад нуман тотготой хаалган дээр нь Эрх чөлөөний малгайгаар чимсэн гурван өнгөт далбаа

намирна. Якобинчууд кордельер¹, фельянуудын адил лам нарыг хөөж байрыг нь булаагаад зогсоогүй нэрийг нь хүртэл зээлдэж авчээ.

Тухайн үед кордельеруудын нэг ч хуралдааныг таслаагүй Гамлен якобинчуудын чархи шаахай болон карманьол өмссөн байхыг юм уу дантончууд шиг хашхиралдахыг ер үзсэнгүй. Робеспьерын клубт түшмэдийн биеэ барьсан, язгууртны төлөв байдал ноёрхоно. Ардын нөхрийн таалал болсноос хойш Эварист үзэл санааныхаа нэр хүндээр якобинчуудын клубийг гартаа атган эндээсээ өчнөөн төчнөөн мянган орон нутгийн клубээр дамжуулан нөлөөгөө Франц даяар дэлгэрүүлэгч Максимилианы сургаалыг анхаарах болжээ. Тогтоол уншиж байх хооронд тэрээр, урьд тэрс номтнуудтай хайр найргүй тэмцэж агсан шашны хөвгүүдийн орон болж байсан, одоо тэднээс дутуугүй зүтгэлтэйгээр эх орны эсрэг гарсан гэмт хэрэгтэй тэмцэл явуулж буй бүлгийнхний гэрч болсон уйтгар төрөм нүцгэн ханыг гүйлгэн харав.

Энд тус орны хамгийн хүчирхэг засаг төдийлөн сүр бадруулалгүй, ам хэлээрээ л тогтнон байгаагаа харуулан оршин байдаг билээ. Энэ нь Парис болон төрийг жолоодож коневентэд хуулиа тулган хүлээлгэж байлаа. Варенны дараа² ч гэсэн Үндсэн хуулийг муйхраар даган, 1791 онд ч роялч чигээрээ үлдсэн хуулийг тэгж хүндэлдэг, энэ шинэ байгууллын үндсийг тавигч, Марсын талбайд болсон хядааны дараа ч урваагүй, хувьсгалын эсрэг хэзээ ч босоогүй, ардын хөдөлгөөнөөс хөндий, тогтсон дэглэмийг талархагч эдгээр хүмүүс гунигт, их сэтгэлээсээ эх орноо хайрладаг ба энэ хайр нь арван дөрвөн арми байгуулж, гильотин босгож чадсан билээ. Эварист тэдний сонор сэрэмжтэй, холын хараатай сэтгэхүйн тогтонги байдалтай, эмх журамд дуртай, улсыг цэцэн мэргэнээр удирдаж чаддагт нь бахархана.

Танхим дүүрэн цугларсан улс хаалганы дэргэдэх Эрх чөлөөний модны навч аятай үе үе нэгэн зэрэг давхийнэ.

Тэр өдөр вандемьерын арван нэгэнд хянган хамартай, цоохор нүүртэй, хавчиг духтай, урт эрүүтэй хэнэггүй байрын царайтай залуу эр индэр дээр гарч ирэв. Тэр үл мэдэг оодсон хиймэл үстэй агаад биеийг нь барьсан хөх фрак өмсжээ. Зарим улсад бүжгийн багш гэж шоолон нотлох, нөгөөдүүлд нь «Франц Орфей» гэж хүндэтгэн нэрлэх шижим өгсөн хянамгай хөдөлгөөнтэй няхуур байдалтай хүн байлаа. Робеспьер бүгд найрамдах улсын дайснуудын эсрэг аянга мэт үгээ чанга дуугаар хэлэн няцаашгүй метафизик баримт дурдан Бриссо болон түүний хамсаатнуудыг дайрав. Тэрээр удтал зугуухан чамин

ярилаа. Гүн ухааны огторгуйн мандалд халин гарч тэрээр тэндээс газарт шигдэгч хуйвалдагсдын дээр аянга цахилгаан буулгаж байлаа.

Эварист сонсоод ухаарав. Одоо болтол тэр орлеанчуудын баяр болон хаант засгийг дахин сэргээхээр бэлдэж Францыг чөлөөлсөн, даян дэлхийг чөлөөлөх баатарлаг хотыг сөнөөхөөр санаархаж байна гэж Жирондыг буруутгаж байсан билээ. Одоо мэргэний хэлэхийг сонсоод Эварист нэн ариун чин үнэнийг сэнхэрч мэдрэхүйн төөрөгдлөөс зайлуулан туйлын үнэний салбарт аваачигч бүдүүлэг бодит байдлын хувьсах үзэгдлийн дээд талд сэтгэл санааг нь тавигч хувьсгалт метафизик үзлийн учрыг оллоо. Бүх юмс хувь хувьдаа бүрхэг, ээдрээтэй, хэрэг явдал самуурч болохоор төвөгтэй байдаг. Робеспьер түүнд хялбар ойлгуулж, энгийн бөгөөд тодорхой томъёоллоор сайн, муу гэдэг юу болохыг гаргав. Федерализм ба үл хуваагдах чанарыг авч үзвэл нягтрал болон үл хуваагдах чанарт аврал, федерализмд мөнхийн зовлон байдаг гэнэ. Яавал аврагдах яавал мөхөхийг мэддэг болсон сүсэгтний хязгааргүй баяр хөөрийг Гамлен амсаж байлаа. Одоогоос хувьсгалт онц шүүх урьдын сүмийн шүүхийн адил ам хэлээр хийсэн гэмт хэрэг, үнэмлэхүй гэмт хэрэг хоёрыг таслан шүүх болно. Эварист шашны үзэлтэйг дээрээс энэ нээлтийг уйтгартай боловч урамтай хүлээн авч зүрх нь баяр хөөрөөр бялхан булгилав. Одоогоос эхлэн тэр гэмтэй гэмгүй хоёрыг ялган таних боллоо. Ээ, эрдэнэ мэт сүсэг, та хүнд юм бүгдийг орлож чадна.

Хогшил хөрөнгийг тэгшитгэн газрыг хувааж баян хоосныг устгаад бултыг дунд зэргийн аж төрдөг болгохыг хүсэгчдийн хорон санааг Максимилиан тайлбарлав. Эдний дэвшүүлсэн онолыг шохоорхсон Эварист эхлээд энэ санаа нь жинхэнэ бүгд найрамдагч хүний зарчимд бүрэн зохицож байна гэж тооцож байсан тул үүнийг сайшааж байлаа. Гэвч Робеспьер якобинчуудын клубт хэлсэн үгэндээ тэдний явуулгыг илрүүлэн, аятайхан шалтаг гарган бүгд найрамдах улсыг түлхэн унагаахыг эрмэлзэн баячуулыг, хууль ёсны засгийн хүчирхэг эвлэршгүй дайсан болгохын тулд хатгагч хүмүүсийн мөсийг таниуллаа. Үнэн хэрэг дээрээ хувийн өмчтөнийг заналхийлж эхлэнгүүт л хөрөнгө нь хэчнээн ялимгүй байх тусам түүндээ улам шунах бүх хүн ам бүгд найрамдах улсын эсрэг нэгэн хүн шиг босох байлаа. Эдийн сонирхлыг хөндөнө гэдэг хуйвалдааныг олшруулна гэсэн үг билээ. Бүх нийтийн аз жаргал болон шударга ёсыг тогтоох гэж эрхээ тэгш,

хөрөнгөө нэг болгохыг иргэдэд зөвлөгсөд үнэн чанартаа өөрсдөө федералчуудаас ч аюултай урвагч олиггүй этгээдүүд ажээ.

Гэвч мэргэн Робеспьерээс Гамлены нүдийг нээсэн гол зүйл бол шашингүйн үзлийн гэмт шившигт шинжийг таниулсанд оршино. Гамлен шүтлэгтэй хүн болохоороо бурхан бийг хэзээ ч үгүйсгээгүй ба хүмүүсийг толилон харж байдаг далдын хүч байдаг гэдэгт итгэдэг юм. Далдын хүчний мөн чанарыг муухан ухаарч байгаагаа өөрөө ухамсарлан шүтлэг бол хүний хувийн хэрэг гэдгийн талд багтай зогсогч тэрээр шударга хүмүүс нь Ламетри, Буланже барон Гольбах, Лаланда, Гелваций, иргэн Дюпюи нарын адилаар бурхан байдгийг үгүйсгээд үүний зэрэгцээ үнэн цагаан амьдралын зарчим болон шударга ёсны эх сурвалжийг өөрсдөөсөө олон, төрөлхийн ёс суртахууны үндсийг тавина гэж бодож байлаа. Бурхангүйчүүдийг харааж зүхэн мөрдөн хавчиж байгааг үзээд түүнд өрөвдөх сэтгэл төрж билээ. Максимилиан түүний ухаан санааг саруул болгож нүдийг нь тайлжээ. Эрхэмсэг уран үгээрээ энэ агуу хүн бурхангүйн үзлийн жинхэнэ мөн чанар, утга учир, чиглэл хандлага үр уршгийг түүнд нээн өгч язгууртны зочид, гийчид хүлээн авах өрөөнөө үүссэн энэ номлол тиймэрхүү замаар ард түмнийг завхруулан боолчлохыг эрмэлзэгч дайснуудын хорон санаа мөнийг, золгүй хүмүүсийг зүтгэлээр нь ивээдэг далдын хүчинд найдах найдлагаас салгах, хүнийг басамжлан түүнийг шившигт боолоо болгогч шунал хүслийн эрхшээлд удирдлага ч үгүй, тулах тулгуур ч үгүй орхих зэрэг нь гэмт хэрэг гэдгийг, ямар нэг Гельвенийн харгис эпикуреизм³ нь ёс суртахуунгүй хэрцгий догшин байдал болон гэм болгоныг үйлдэхэд хүргэдэг гэдгийг нотлов. Агуу иргэний өгсөн сургамж түүнийг сэнхрүүлснээс хойш Гамлен бурхангүйчүүлийг ялангуяа Бротто өвгөн шиг баясгалантай хөгжилтэй зан ааштай бол бүр их үзэн яддаг болжээ.

Дараа өдрүүдэд ард түмнийг өлсгөх зорилгоор үр тариаг устгах гэж байгаад баригдсан тайж, гадаадад зугтаж гарснаа иргэний дайны галыг шатаахаар Францад эргэж ирсэн гурван хүн, Пале - Эгалитийн хоёр бүсгүй болон өвгөд, хүүхэн, залуус эзэн зарц нийлсэн бретоны арван дөрвөн хуйвалдагсдын хэргийг хойно хойноос нь цувуулан таслав. Хийсэн хэрэг нотлогдсон, шийтгэх хууль тодорхой. Хэргээ таслуулагчдын дотор цэцэглэж буй цэл залуу хорин настай гол шиг бүсгүй байх агаад гарцаагүй үхэл ойртон байгаа нь түүнийг гоц дур

татам болгосон ажээ. Алтан шаргал үсэндээ хөх тууз зангидаж нимгэн цагаан даавуу алчуур гунхсан цагаан хүзүүн дээрээ тохжээ.

Эварист алах ял заахаар саналаа тууштай гарган, нэг цэцэрлэгч өвгөнөөс бусад ялтанг цаазын газар илгээв.

Дараагийн долоо хоногийн туршид Эварист ба түүний нөхөд дөчин таван эрэгтэй, арван найман хүүхний амийг бүрэлгэв.

Хувьсгалт онц шүүхийн шүүгчид хууль зүйгээс ч дутуугүй эртний зарчмыг удирдлага болгон эр эм гэж ялгахгүй байлаа. Хэрвээ Шарлотта Кордагийн эрэлхэг зориг, гоо үзэсгэлэнд сэтгэл хайлсан дарга Монтане заль хэрэглэн түүнийг аврах гээд тушаалаасаа огцорсон бол одоо ихэнх тохиолдолд эмэгтэйчүүдийг хэрэг таслах ерөнхий дүрмийг харгалзан ямар ч уучлалт үзүүлэлгүй байцааж байлаа. Ардын төлөөлөгчид эмэгтэйчүүдээс эмээж, ов заль хуурмаг зан, гоо үзэсгэлэнгээс болгоомжилно. Эрчүүлээс дордохгүй эршүүд тэд, Онц шүүхийнхэнд өөрсөдтэйгөө эрчүүлийн адил хандах боломж олгож байлаа. Тэднийг шүүж буй хүмүүсийн зонхилох олонх нь өрөвдөх сэтгэлийг умартсан буюу эсвэл тодорхой цагт үүнийгээ илрүүлдэг тул тэд өчүүхэн ч сэтгэл үл зовно. Тэд нэр төр, мухар заншил, хүсэл эрмэлзэл, бүгд найрамдах улсаа хайрлах хайрыг удирдлага болгон эмэгтэйчүүдийн яллах буюу цагаатгаж байв. Бараг бүх эмэгтэйчүүд хэдийгээр гунигт байдалд байлаа ч гэсэн чадлынхаа хэрээр биеэ тордож үсээ нямбай самначхаад шүүхэд ирцгээнэ. Гэвч тэдний дотор залуус цөөн, өөдтэйхөн хүүхэн бүр ч ховор үзэгдэнэ. Шорон, сэтгэлийн түгшүүр тэднийг турааж танхим дахь хурц гэрэлд сульдсан, айсан нь мэдэгдэх агаад шаналгаат ягаан хацар, улайсан зовхи, шазайтал жимийсэн зэвхий уруул нь тодхон харагдана. Гэвч цонхийн цайсан ч үзэсгэлэнтэй хэвээрээ уйтгарын сүүдэр туссан боловч усгал зөөлөн нүдтэй залуу бүсгүй гайт сандал дээр суухыг нэг бус удаа харж болно. Үүнийг үзсэн хэчнээн олон төлөөлөгчийн сэтгэл уярч сэрэл нь хөдөлсөн гээч! Үхсэн амьд хоёр нь хослон төсөөлөгдөх энэ цогцсын эрдэнэ мэт нууцад нэвтрэх сэн гэж хэчнээн нь шалиг сэтгэлийнхээ гүнд санаашраа болоо! Шунал тачаалын ажил, цус урсгасан цаазлалт хоёрыг дүрслэн бодсоор хохьдоо гарсан, хурьцал бадраагч биеийг зандалчны гарт өгөхдөө хэчнээн тийм шүүгчийн бах тав нь ханаа болоо! Энэ бүгдийн тухай дуугүй байвал зохих боловч эрчүүлийг мэдсээр байгаад үүнийг үгүйсгэж яагаад ч болохгүй ээ. Хүйтэн сэтгэлтэй, туршлагатай зураач Гамлен зөвхөн өнө эртний гоо сайхныг

л зөвшөөрөн хүлээх бөгөөд гоо үзэсгэлэн нь хүндэтгэх сэтгэлийг түүнд төрүүлдэг шигээ зүрхийг нь үл догдлуулна. Түүний сонгомол дур сонирхол нь их чанд учир хүүхнүүд түүнд таалагдах нь ховор, тэрээр Франгонерын будгийн өнгө, Бушегийн хэлбэрийг тоодоггүй шигээ нүд булаам хөөрхөн царайд сэтгэл үл хөдлөх билээ.

Шүүхийн нөхдийнхөө нэгэн ижил Гамлен хүүхнүүдийг эрчүүлээс осолтой гэж тооцно. Урьдын гүнж нар нь Елизавета ба австри хүүхэнтэй хамт эх орончдыг устгах сум хийж байна гэж Гамлен хар даран зүүдлэх учир тэднийг үзэж чаддаггүй бөгөөд замбараагүй үед тачаал, оюуны цэнгэлд автан амьдарч байснаараа гэмтэй санхүүчид, гүн ухаантан болон зохиолчдын явдаг хүүхнүүдийг жигшинэ. Тэрээр тийнхүү үзэн ядаж байгаагаа өөрөө мэдэхгүй, тэднийг үзэн ядах хийгээд зүрхэндээ дүрэлзсэн хилэнгээ дуранд нь тавин тиймэрхүү хүүхнийг хороох ял заахдаа нийтийн тусын тулд шударга үйл хийж байна гэдэгт итгэл төгс байдаг билээ. Голч зантай хүүхэнд төдийлөн хавьтаж үзээгүй, нэн няхуур, улсдаа үнэнч журамт сэтгэлтэйн улмаас Эварист өрөвдөм толгойг хойно хойноос нь цувуулан алман сүхний ирэнд өгсөөр байлаа.

Гэвч юу болов, энэ гайхамшиг ямар учиртай гарч ирэв ээ? Сав саяхан гэмтнийг эрэн хайж хорогдсон газарт нь барьж авахын тул хүч чармайлтаа гаргаж, хийсэн хэргийг нь хэл амыг нь сугалах шахан байж албаар улайлгаж байсан биш билүү... Одоо энэ нь эрүүлч ноход дагуулсан ав хоморго хийн үргэмтгий зэрлэг шувууг гөрөөлж яваа хэрэг биш болж үйл нь ирэгсэд өөрөө өөрийгөө барьж өгч байлаа. Тайж нар, бүсгүйчүүд, цэрэг эрс, янхан хүүхнүүд бөөн бөөнөөрөө Онц шүүх рүү цутган ирж хэрэг таслахаа алгуурлан буй шүүгчдийг шавдуулан, эдлэх сэн гэхээс тэсэж ядан байгаа эрх лүгээ адил л алах ял заахыг шаардана. Зүтгэлтэй ховч нарын шорон гянданг дүүргэсэн өчнөөн төчнөөн хүнийг олон нийтийн яллагч, туслагч нарынхаа хамт онц шүүхээр чүү чамай оруулж амжиж байгаа нь хангалтгүй мэт, бас ээлжээ хүлээхийг үл хүсэгчдийг бас цаазлах талаар санаа тавих хэрэгтэй. Эл хүндэтгэлийг шүүгч алуурч нарт найр тавьж өгөхгүйн тул амиа хорлож буй омог бардам зүрхтэй зоригтой улс алийг тэр гэх вэ! Үхэх хүслэн, алах эрмэлзэл хоёр тэнцэж байлаа. Консьержерд байгаа эрүүл саруул сайхан залуу «Миний төлөө амьд бай!» гэж хэлсэн зүрх булаам амраг бүсгүйгээ шоронд орхисон ажээ. Гэтэл тэрээр бүсгүйн төлөө ч, хайр сэтгэлийнхээ төлөө ч, алдар нэрийнхээ төлөө ч амьд

явахыг хүсэхгүй байлаа. Залуу гаансаар тамхи татлаа гэж хэрэгт татагджээ. Эрх чөлөөнд туйлгүй дуртай яс махны бүгд найрамдах үзэлтэй тэр хүн үхэхийн тулд л өөрийгөө роялч гэж мэдэгджээ. Түүнийг цагаатгахыг шүүх чадах чинээгээрээ мэрийсэн боловч хэрэгтэн дийлж шүүгчид төлөөлөгчид бууж өгөхөөс өөр аргагүй болов.

Угийн сэтгэл зовж явдаг шударга Эварист, якобинчуудын сургаал, орчны амьдралын нөлөөгөөр зовуурьтай, хардамтгай болжээ. Шөнөд гэрэл гэгээ муутай гудамжаар Элоди руугаа явж байхад нь зооринд байгаа хуурамч цаасан тэмдэгт хэвлэх ялтас уурын нүхээр харагдах шиг болон талхчны буюу идэш уушнаас худалдаачны хоосорсон мухлагийн ард дамлахаар нуусан хүнсний нөөцийг багтаж ядтал чихсэн бүхэл бүтэн агуулах нүдэнд нь үзэгдэн, рестораны хурц гэрэлт цонхны цаадтай бонны дарс нэг лонх буюу сархад өмнөө тавьчхаад тус орныг яаж сөнөөх тухай хэлэлцэн буй биржийнхэн байх мэт бодогдон, өмхий нарийн гудамжнаа хээнцэр залуусын алга таших аялгуунд үндэсний сүлдийг шаварт дэвсэхдээ бэлхэн хөгжилтэй бүсгүйчүүд явах шиг санагдан, ер нь Эваристэд алхам бүрд нь хуйвалдагсад, урвагчид тааралдах мэт болно. Тэгээд тэр «Бүгд найрамдах улс минь! Ил, далд ийм олон дайсны эсрэг хэрэглэх ганц хэрэгсэл чамд байна. Ариун гильотина минь, эх орноо авар!» гэж бодно.

«Амур - зураачийн» дээрх унтлагынхаа хөх өрөөнөө Элоди түүнийг хүлээж байдаг байлаа. Орж болно гэдгийг түүнд мэдэгдэхийн тул лиш цэцэгтэй ваарын хажууд ногоон шүршүүр тавина. Одоо Эварист түүний айдсыг хүргэн ямар нэгэн мангас аятай санагддаг болсон хийгээд Элоди айхын зэрэгцээ түүнийг хайрлана. Шөнөжингөө цусанд шунаг амраг, тачаангуй сэтгэлт бүсгүй хоёр салж хагацалгүй тас тэврэлдэн учир начиргүй үнсэлддэг байв.

XIV

Үүрээр дээшилсэн эцэг Лонгмар өрөөгөө шүүрдээд Тамын гудамжнаа орших үндсэн хуульд тангараг өргөхөөс татгалзсан нэгэн ламын мөргөл үйлддэг жижиг сүмд очив. Дуулгаваргүй шашныхны, лам нарыг цөөн цөөнөөр нь сэм цуглуулдаг тийм нууц газар Парист зөндөө байсан билээ. Хэдийгээр сонор сэрэмжтэй боловч секцийн цагдаагийн газрынхан, шүтлэгтэн олны дургүйцлийг төрүүлэхээс болгоомжлон, мөнхүү өөрсдөө бурханд бишрэх бишрэлээ бүрэн тавиагүйгээс шүтлэгийн эдгээр нууц газрын хажуугаар нүдэн балай, чихэн дүлий өнгөрдөг байв. Өөрийг нь ирэхгүй бол хоол минь ямар ч амт шимтгүй болно гэж байж үдийн хоолноор буцаж ирнэ гэдэг амыг нь варнавчаас арайхийн авсан гэрийн эзэн түүнтэй салах ёс хийв.



Бротто ганцаар үлдээд жижиг зуухаа галлаж эпикурын сурталч буюу өөртөө, мөн гэлэнд хоол бэлдэнгээ Лукрецийгээ уншиж хүний хувь тавилангийн тухай бодлогоширч байв.

Байгалийн хүчний өөдгүй наадам болсон өчүүхэн амьтас л хөөрхийлөлтэй, хүнд хүчир байдалд ордогт энэ цэцэн хүн нэгээхэн ч гайхдаггүй боловч хувьсгалчид, бусад хүнээс тэнэг, хэрцгий гэж боддог нь түүний сул тал, энэ нь түүний үзэл бодол байлаа. Гэхдээ тэрээр муугаар үзэгч биш, амьдралаа олиггүй байна гэж үл санана. Сайх өвгөн, байгалийн зарим үзэгдэл, ялангуяа огторгуйн механик, бие махбодын дурлалыг бахархдаг бөгөөд айх хүсэх аюулгүй болох зайлшгүй ирэх тэр өдрийг хүлээсээр хүнд хүчир амьдралдаа тэгс ингэсхийгээд дасаж байлаа.

Тэрээр хэдэн бүжигчийг нямбайлан будаж, Роза Тевенентэй төстэй Церлиныг хийв. Энэ эмэгтэй түүнд таалагддаг ба эпикурейц хүний хувьд тэрээр бүсгүйн биеийг бүрэлдүүлэгч атомын найрлагыг бүрнээ сайшааж байлаа.

Варнавчийг иртэл Бротто энэ ажлаа хийж цаг нөхцөөв.

— Эцэг минь! Хоол минь хомсхон л болно байх гэж би танд сануулсан билээ. Бидэнд туулайн бөөрнөөс өөр юм юу ч алга. Бас тэгээд хольцгүй шахууг яана гэж Бротто ламд хаалга онгойлгож өгөх зуураа хэлбэл Лонгмар инээмсэглэн дуу алдаж

— Туулайн бөөр гэнэ ээ? Түүнээс сайхан хоол хаа байх вэ. Ноёнтон минь, миний эцэг Лимузины хохь тайж байсан юм. Манай хөрөнгө зөөр гэвэл ердөө л тагтааны нурсан хонуур, зөнд нь хаясан жимсний цэцэрлэг, туулайн бөөр модны багахан төгөл л байсан билээ. Тэр, эхнэр арван хоёр хүүхэдтэйгээ хамт гэр бүлээрээ том ногоон туулайн бөөр иддэг байсан боловч бид цөмөөрөө л эрүүл чийрэг хүч чадалтай болж өссөн юм даа. Би хамгийн отгон нь, хамгийн тархигүй нь байсан юм сан, аав маань намайг Америк орж далайн дээрэм хийвэл зохих юм гэж тоглоом хийдэг байж билээ... Ай ноёнтон минь таны туулайн бөөрний шөл ямар сайхан үнэртэж байна вэ! Ширээ тойрон ярайтал суусан хүүхдээ харан ээж минь инээмсэглэдэг байсныг санаанд оруулчихлаа гэв.

Бротто хоолоо идчихээд Нев - де - Пти - Шан гудамжны тоглоомын наймаач Жолийнх руу явлаа. Тэр, Кайюгийн голсон хүүхэлдэйг аваад түүн шиг зуун дөчин дөрвийг биш хоёр зуун наян наймыг нэг амиар захисан юм санж.

Вангийн гудамжнаа хүрээд Бротто, Хувьсгалын талбайд хоёр дүнзний хооронд гурвалжин гялалзсан болд төмөр байхыг үзэв. Энэ бол гильотина байлаа. Хийх юмаа олж ядсан хөгжилтэй залуус хэрэгтнийг авчрах тэргийг хүлээн цаазын ванданг тойрон бөөгнөрч шахалдан байв. Өмнө талдаа үүргэвчээ дүүжилсэн эмэгтэй, нантер боов аваарай гэж дуудна. Эмийн хандны худалдаачид хонх цохин, Эрх чөлөөний хөшөөний ёроолд нэг өвгөн дүүжинд суусан сармагчин бүхий хөдөлгөөнт зураг үзүүлж байх ажээ. Цаазын индрийн дор нохос, очигдөр тунасан цус нөжийг долооно. Бротто, Оноре гудамж руу эргэв.

Лонгмарыг судар уншин сууж байхад нь дээврийн хөндийд эргэж ирээд Бротто ширээгээ хичээнгүйлэн арчсанаа хайрцагтай будаг болон бас бус хэрэгтэй зүйл багаж хэрэгслээ гаргаж тавив.

— Эцэгтэн минь, хэрвээ та, өөрийн хүртсэн ариун санваартаа нийцэхгүй гэж үзэхгүй байвал хүүхэлдэй урлахад минь туслаач. Өнөө өглөө ноён Жолигоос ихээс их захиалга авлаа. Хэрвээ та энэ үлгэрээр, толгой, гар хөл, их биеийг нь хайчлаад өгвөл их нэмэр болох сон, би бэлэн болсон дүрсийг будья. Үүнээс илүү үлгэр хаанаас ч олохгүй биз ээ, эднийг Ватто Буше нарын зургаас хуулбарласан юм гэж Бротто хэлэхэд Лонгмар

— Ватто, Буше нар ийм дэмий юм хийхдээ үнэхээр уран байсан юм гэж би боддог. Хэрвээ тэд энэ гэм хоргүй дүрснүүд хийгээд зогссон бол алдар нэрт нь хожоотой байх байсан гэдэгт би эргэлздэггүй юм. Би танд туслахдаа баяртай байх сан, гэвч төдийлөн сайн туслагч болж чадах болов уу гэж зовном хэмээн хариулав.

Өөрийнхөө чадлыг чамласан нь Лонгмарын зөв байжээ. Урагш муутай хэдэнтээ оролдож үзсэнээ нимгэн хатуу цаасыг тонгоргоор ухах авьяас огт алга гэж хүлээхээс өөр аргагүй болов. Харин хүссэнээр нь олс, мохоо тэвнэ түүнд өгвөл тэрээр хийж чадаагүй өчүүхэн зүйлээ хөдөлгөн бүжиглүүлж ёстой урлагаа гаргав. Цөмөөр нь хэдэн удаа пагавота⁴ хийлгэн шалгаж үзээд оролдлого нь талаар болсонгүйд ширүүн маягийн уруулд нь үл мэдэг инээвхийлэл тодров.

— Ноёнтон минь гээд тэрээр Скарамушийн оосроос жигдхэн татах завсраа

— Энэ дүрсүүдийг хараад нэг паян сэтгэлд минь орлоо. 1746 онд юм даг. Насан өндөр болсон, их эрдэмтэй номтой, үлэмж яхир зантай хүн Мажито эцэгтэнд анхлан шавь ороод дүүргэж байсан цаг. Та санаж байвал тэр үед хүүхдийн тоглож наадахад зориулсан хүүхэлдэй нь эмс, түүгээр үл барам эрчүүл өвгөд, залуусын сонирхлыг ер бусын их татаж Парист ёстой шагшаан шуугиан дэгдэж байсан шүү дээ. Тэр үеийг овсгоотой ашиглаж байсан худалдаачдын мухлаг дэлгүүрт нааданхай л пиг чихээстэй байдаг сан. Нэлээд дээгүүр улс хүртэл хийж авдаг байж билээ. Нааданхайныхаа олсноос татанхан сэлгүүцэн яваа ихэмсэг хатагтайг бишгүй л нэг үзэж болох байлаа... Эцэг Мажитогийн нас нь ч, зан нь ч, мэргэжил нь ч нийтийн халдвараас түүнийг хамгаалж чадсангүй. Эргэн тойрон хүмүүсийн гарт цаасан хүүхэлдэй бүжиглэн байхыг үзсэн Мажитогийн гар хуруу нь загатнан тэсэж байхын аргагүй болов. Бүхий л холбоог хамаарах чухал ажлаар Парламентын дэргэдэх өмгөөлөгч ноён Шовелинд нэгэн удаа очоод зууханд өлгөсөн нааданхайг үзэж олсноос нь татаад авах юм сан гэхээс байж яджээ.

Тэгээд гозгоносон хорхойгоо арай чамай дийлсэн гэдэг. Гэвч гоомой хүсэл нь түүнийг тарчилгаж амар заяа үзүүлэхээ больжээ. Эрдэм шинжилгээний ажил хийж байхад нь ч санаашрал ба мөргөлийн цагт ч, сүмд ч, хурал номын газарт ч, нүгэл наманчлах өрөөнд ч, тэнхимд ч энэ хүсэл түүнийг мөшгөх болов. Хэдэн өдрийг айхавтар сэтгэл үймрэн өнгөрөөгөөд азаар, энэ үед Парист заларч байсан нийгэмлэгийн тэргүүнд энэ ер бишийн явдлын тухай айлтгажээ. Тэр бол эрдэмт эр, Миланы сүмийн нэгэн ноён байсан юм. Уг чанартаа гэм хоргүй боловч хэрвээ дарахгүй бол хямарсан сэтгэлд нь тамыг нь цайлгасан самууны үр тарьж магадгүй маш ёозгүй уршиг чирч мэдэх энэ хүслээ ханга гэж тэр эцэг Мажитод айлдсан юм. Түүний зөвлөснөөр ч гэх юм уу, зарлигаар ч гэх юм уу Мажито эцэгтэн ноён Шовелинд очиход тэр түүнийг аанай л кабинетдаа хүлээн авчээ. Зууханд өлгөсөн нааданхайг үзмэгцээ эцэгтэн тийш хурдхан дөхөж гэрийн эзнээс оосроос нь татах зөвшөөрөл эрэв. Өмгөөлөгч дуртайяа зөвшөөрөөд шүүх дээр хэлэх үгээ эргэцүүлэн бодож байх зарим үед Скарамушийг (нааданхайг тэгж нэрлэдэг байв) бүжиглүүлж гардаг, өчигдөр түүний хөдлөх аясаар нөхрөө хорлосон гэж хилс хэрэгт унасан эмэгтэйг өмгөөлөх үгээ зохиосон гэж үг алдав. Мажито эцэгтэн салганасаар уяаг шүүрэн аваад түүний дураар Скарамуш чөтгөрийг хөөж байгаа дийлсэн баатар шиг цовхчин дэвхцэхийг үзсэн гэдэг. Ингэж ингээ дарж, шүглэсэн донгоосоо ангижирсан билээ гэхэд нь

— Эцэгтэн минь, таны ярьсан зүйлийг би гайхахгүй байна. Хүний амьдралд дон нөхцөх явдал гардаг. Гэхдээ зөвхөн хүүхэлдэй л дон шүглүүлдэг юм биш гэж Бротто дуугарав.

Эцэг Лонгмар хэдийгээр гэлэн хүн боловч шашны тухай огтхон ч үл дурсана. Гэтэл Бротто тэр тухай үргэлж яриа үүсгэнэ. Өвгөн варнавчийг ихэд хайрлан үздэг болохоор түүнийг зовоон христосын шашны сургуулийн янз бүрийн зүйлийг үгүйсгэн мухардуулах нь Броттод таатай санагдана.

Нэгэн удаа Лонгмартай хамт Церлин ба Скарамуш урлан суух зуураа Броттог

— Манийг иймэрхүү байдалд хүргэсэн хэрэг явдлыг тунгаан бодохдоо би, бүгдийг хамран халдварласан солиот байдалд чухам ямар нам нь бүр ухаан мунхаг гэдгээ харуулаа бол гэдгийг хэлж чадахгүй, энэ талаар тэргүүн байрыг ордны нам л эзлэх байх гэж үе үе санадаг юм гэвэл

— Ноёнтон минь, булт хүмүүсийг Навуходоносорын адил бурхан нь хаявал ухаан бодлоо алдана. Манай үеийнхнээс нэг нь ч ширээт лам Фоше шиг бүдүүлэг байдал, төөрөгдлийн балчигт ингэж гүн шигдээгүй, хэн ч вант улсад тэгж гай тотгор тариагүй билээ. Эзэн тэнгэр, Фошег нааш илгээсэн болохоор Францад үнэхээр их хилэгнэжээ хэмээн гэлэн хариулав.

— Золгүй Фошегоос аль ч талаараа дордохгүй хорлогчид байгааг бид үзсэн юм шиг надад санагднам.

— Ширээт Грегуар ч багагүй муу үйл хийсэндээ.

— Тэгвэл Бриссо, Дантон, Марат мэтийн хэдэн зуун улс? Тэдний тухай, эцэг минь та юу хэлэх сэн бол?

— Ноёнтон минь, тэд чинь төрийн хар улс аа, хар улс нь, санваартнууд шиг хариуцлага хүлээдэггүй. Тэд өндөрт өргөмжлөгдөөгүй болохоор тарьсан муу үйл нь нийтэд хүртээлгүй.

— Эцэг минь, таны бурхан? Бидний лайгаа эдэлж байгаа энэ хувьсгалын үед тэр бээр ямар ая зантай байгаа бол та юу хэлэх сэн бол?

— Ноёнтон минь ойлгохгүй байна.

— Бурхан муу үйлэнд саад хийх гэж хүсэвч чаддаггүй, эсвэл чаддаг боловч хүсдэггүй, эсвэл чаддаг ч үгүй, хүсдэг ч үгүй, үгүй бол хүсдэг чаддаг байх ёстой гэж Эпикур хэлсэн билээ. Хэрвээ тэр хүссэн мөртөө хийж чадахгүй бол хүчгүйнх, хэрвээ хийж чаддаг байгаад хүсэхгүй бол харгисынх, хэрвээ чадах ч үгүй, хүсэх ч үгүй байвал хүчгүй атлаа харгисынх, хэрвээ чаддаг байгаад хүсдэг юм бол яагаад саад хийхгүй байгаа юм, эцэг минь гээд Бротто түүнийг додигорхон харваас гэлэн

Ноёнтон минь, таны дурдаж байгаа баримт шиг өчүүхэн юм алга. Шүтлэггүй улсын баримталж байгаа нотолгоог авч үзэхэд уулнаас буух үерийн усны замыг өвсний хэдхэн ишээр хаах гэж оролдогч шоргоолж нүдэнд харагдах шиг болдог юм. Тантай маргалдахгүй байхыг минь болгоож хайрла. Бид нотолгоо олныг гаргаж чадах боловч суу залиар мөхөс билээ. Нөгөөтээгүүр та ширээт лам Геней болон шашны хорин зохиолчийн бичиг туурвилд өөрийн чинь шүүмжийг няцаасан байхыг олж үзэж болно. Харин таны иш татсан Эпикурийн үг бол усан тэнэг зүйл, таны тэр мэргэн бурхныг хүний ёс суртахууны хуульд захирагдсан жирийн хүн шиг үзэж байна гэдгийг л зөвхөн хэлье. Яах вэ? Цельсээс аваад Бейль, Вольтерыг дуусталх бурхангүй улс гаж

буруу номлолоороо тэнэгүүдийг үргэлж мунхруулж байсан юм гэж хариулахад

— Тээр, эцэг минь шүтлэг тань таныг юу руу оруулах гэж байгааг харахгүй юу. Та, бүх үнэн бурхан судлалд л байна гэдэг тань бага хэрэг, танаас өөрөөр сэтгэдэг олон суутны зохиол туурвилаас та үнэн юм огт олохгүй нь гэж Бротто татгалзав.

— Ноёнтон минь, та тун их эндүүрч байна даа. Эцсээ хүртэл худлаа ташаа бодол гэж байдаггүй гэдэгт би итгэдэг. Шашингүйн үзэлтнүүд, ертөнцийг танин мэдэхүйн хамгийн доод шатан дээр байна. Гэвч ухаарсны тэмдэг, үнэний хувь өчүүхэн байгааг үзэж болно. Харанхуй мунхгийн намагт хүн тэр чигээрээ шигдлээ ч эзэн тэнгэрээс оюун ухааны гэрэл гэгээ заяасан магнайгаа дээш өргөдөг юм. Люциферийн хувь тавилан тийм байсан гэж Лонгмарын өчсөнд

— Ээ, ноёнтон минь, би тэгж ууч сэтгэл гаргахаа байя, шашны номлогчдын зохиолд учир утгатай юм хумсхан төдий ч алга гэдгийг хэлэх хэрэгтэй гэж Бротто өгүүлэв.

Гэсэн хэдий боловч шашин нь ард түмэнд хэрэгтэй гэж үзэх учраас Бротто түүнийг дайрч давшилсандаа биеэ цагаатгах ба түүнд зүтгэгчид нь шүтлэгийн тухай маргагсад биш гүн ухаантан нар байгаасай хэмээн хүснэ. Якобинчууд нь түүнийг арай залуу, арай хортой шашин болох эрх чөлөө, тэгш эрх, бүгд найрамдах улс, эх орны шашнаар солих гэж байгаа явдалд тэрээр хар бууна. Шашин нь мандан цэцэглэж байгаа эхнийхээ үед юунаас ч хэрцгий догшин байдаг бол насанд дарагдаад ирэхлээрээ зэгсэн зөөлөрдөг гэдэгт Бротто итгэнэ. Ийм учраас тэрээр, цэцэглэн байсан цагтаа цөөнгүй хүний толгойг залгисан, одоо он жил улираhad хөл нь хүндэрч зуун жилд л дөрөв таван буруу номтныг шатаасандаа сэтгэл ханан идэх дур нь багассан католик шашныг байлгах талд зогсож байв.

— Би бурханд сүжиглэгч, христосыг бишрэгчидтэй онцгой нийцдэг билээ. Дез - Илеттдээ би ламтай байсан, ням гараг бүхэнд зочдыг маань байхад тэр мөргөл үйлддэг байсан юм. Тэдний дундаас гүн ухаанчид хамгийн анхааралтай нь, дуурийн дуучид хамгийн зүтгэлтэй нь байлаа. Тэгэхэд би жаргалтай ч найз нөхөд олонтой ч байж дээ гэж Броттог хэлэхэд

— Нөхөд гэнэ ээ! Нөхөд гэнэ ээ! Ээ чааваас, ноёнтон минь, бурхан тэнгэрийн алдар нэрийнхээ төлөөнөө орд болгон босгосон таны сэтгэлийг түүнд танигдахгүй болтол нь завхруулсан тэр гүн ухаанчид,

завхай хатагтай нарыг та өөртөө хайртай байсан гэж санаж байна уу? хэмээн Лонгмар дуун алдав.

Броттогийн бүтэн долоо хоног байх хугацаанд нь Лонгмарыг хэн ч сандраасангүй. Болохын нь хирээр Лонгмар нийгэмлэгийн ёсыг баримтлан, шөнийн уншлагаа хийх гэж тогтмол цагт хэвтрээсээ өндийнө. Тэр хоёр хэдийгээр тун мөчиг тачиг хооллож байсан авч гэлэн мацаг барьж, юм идэхийг тэвчинэ. Биеэ ийнхүү тарчилгаж буйг гунигтайяа инээмсэглэн харж байсан гүн ухаанч нэгэн удаа

— Өлсөж, даарч байгааг тань бурхан харвал аятайхан гэж та үнэхээр бодож байна гэж үү? хэмээн асуухад

— Эзэн тэнгэр, биеэрээ зовлон эдэлж бидэнд дуурайл үзүүлсэн билээ гэж гэлэн хариулав.

Варнавчийг дээврийн хөндийд ирснээс хойших ес дэх өдөр Бротто, харуй бүрий болсон хойно Невде - Пти - Шан гудамжны тоглоомын худалдаачин Жолид хүүхэлдэйнүүдээ аваачиж өгөв. Хийсэн арилжаандаа сэтгэл хангалуун буцаж явтал нь урьд нь Эргэлдүүрийн гэгдэж байсан талбайд үенгийн арьсан хажтай хөх пүүсүү дээлтэй залуухан бүсгүй өөдөөс нь догонцсоор гүйж ирэв. Тэр үеийн өмгөөлөл хамгаалал эрэгч хүн бүрийн адил тэрээр Броттогийн цээжинд наалдан тас тэвэрчэв.

Тэрээр чичрэн зүрх нь түг түг цохилно. Бүсгүйн эрээ цээргүй сэтгэл татам аашлахад нь гайхан шагшсан театрын эзэн өвгөн Бротто, мадемуазель Рокур энэ байдлыг харвал өөртөө аар саар ч гэсэн хэрэгтэй зүйл олж авах биз гэж бодов.

Бүсгүй тасалданги хоолойгоор зорчигчдыг сонсчих буй гэж болгоомжлон шивнэхдээ

— Иргэн, намайг аваачаач, нуугаач, танаас гуйя! Тэднүүс Фромантогийн гудамж дахь унтлагын минь өрөөнд ороод байна. Би тэднийг шатаар өгсөж явахад нь айлынхаа Флора хүүхнийд нуугдаж байгаад цонхоор үсрэн буухдаа хөлөө бэртээчихлээ. Тэд шоронд хаяж алахаар намайг хөөж явна... Өнгөрсөн долоо хоногт тэд нар Виржинийг алсан гэлээ.

Секцийн хувьсгалт хорооны төлөөлөгчид юм уу эсвэл нийгмийг аюулаас хамгаалах хорооны комиссаруудын тухай ярьж байгааг Бротто гадарлав. Тэр үед хөлсний хүүхнүүдийг бүгд найрамдах улсын хамгийн аюултай дайсны нэг хэмээн мөрдөн мөшгөж байсан прокурор

иргэн Шомет Коммунд байсан билээ. Тэр хэв суртахууныг цэвэрлэхийг хүсэж байжээ.

Үнэнийг хэлэхэд Пале - Эгалитын бүсгүйчүүл тийм ч айхтар эх орончид биш байлаа. Тэд хуучин дэглэмд хар бууж үүнийгээ нууж хаадаггүй байв. Тэдний заримыг нь хуйвалдагсад гэж цаазалсан агаад харин эмгэнэлт хувь заяа нь тэдний ижлийг тэр жишээг дагахад хүргэсэн юм.

Иргэн Бротто яагаад баригдах болсны нь учрыг охиноос асуухад тэрээр юу ч мэдэхгүй, хийсэн хэрэг байхгүй гэж ам шүд алдав.

— Тэгвэл, хүүхээ, чамайг юунд сэжиглэх билээ, айх явдалгүй. Явж унт, намайг тайван орхи гэж Броттог хэлбээс бүсгүй

— Би тэмдгээ авч чулуудаад «Ван мандтугай» гэж хашхирсан юм гэж байдгаа улайв.

Бротто тэр хоёр мөрний буйд эргээр явцгаалаа. Бүсгүй түүний гараас зүүгдэн

— Би вантанд тийм ч хайртай биш ээ. Миний, түүнийг ер үзээгүйг та лав тааварлаж байгаа байх, тэгээд ч тэр бусдаас ялгарах юмаар бага биз. Гэвч эднүүс харгис юм. Буурай бүсгүйчүүлд тэд хэрцгий авирлаж байна. Тэд намайг зовоож, хавчиж. аль байдгаараа доромжилж байна. Тэд намайг аж төрлөө эрхлэхэд минь саад хийхийг хүсжээ. Гэтэл өөр хийчих ажил надад алга шүү дээ. Хэрвээ өөр ажил байсан сан бол яалаа гэж ийм юм хийх билээ... Тэд юу хүснэ вэ? Тэд ядуу дорой, өмөг түшиггүй сүүний худалдагч, нүүрсчин, усчин, угаалгачин хүүхнүүдийг хүний үнэргүй мөрдөж байна. Бүх харц ядуусыг өөрсдийнхөө эсрэг босгож байж л тэдний санаа амрах байх гэж ярив.

Бүсгүйг харахад бүр хүүхдээрээ юм шиг Броттод санагдав. Бүсгүй айхаа хэдийн больжээ. Тэрээр инээмсэглэн, доголсхийсээр өвгөнтэй зэрэгцэн алхана. Броттогийн хэн гэдэг вэ гэж асуухад тэр нэрээ Атенайс гэдэг, арван зургаан настай гэж хариулав.

Бротто, түүнийг хүссэн газар нь хүргэж өгье гэлээ. Парист таних айл бүсгүйд байхгүй харин Палезод зарц нагац эгч нь байдаг тэр л түүнийг толгой хоргодуулж магад ажээ.

Бротто шулуудан

— Хүүхээ, явъя гэв.

Тэгээд түүнийг сугадан гэр лүүгээ явав.

Эцэг Лонгмарыг жаягийн номоо уншин сууж байхад нь таарч очлоо.

Бротто, Атенайсын гараас барин зааж

— Эцэг минь, энэ бүсгүй Фроманто гудамжинд суудаг байжээ.

Энэ «Ван мандтугай!» гэж хашхирсан юм гэнэ. Хувьсгалт цагдаа нар түүнийг гэзэг даран хөөж явна. Толгой хоргодчихмоор газар нэг ч үгүй юм байна. Үүнийг энд хоновол та зөвшөөрөх үү? гэсэнд эцэг Лонгмар номоо хаан

— Хэрвээ миний ойлгож байгаагаар бол, ноёнтон минь, над шиг баривчлагдах аюулд учраад байгаа энэ залуу бүсгүй түр зуур ч атугай амиа аврахын тулд надтай нэг тасалгаанд өнөө шөнийг өнгөрөөж болох уу гэж асууж байх шив дээ? гэв.

— Тийм ээ, эцэг минь.

— Надад цааргалах юм юу байх вэ? Энэ бүсгүйгээс дээрдэх юм надад бий гэж үү? Үүнтэй хамт байхыг доромжлол гэж үзэх юм надад юу байх билээ.

Тэрээр хугархай хөлтэй хуучин сандал дээр сайхан унтаж чадна гэж зүтгэсээр тэндээ тухалж авав. Атенайс гудсан дээр, Бротто сүрлэн дэвсгэр дээр тус тус хэвтэн лаагаа үлээлээ.

Гонхон дээрх цаг шөнө дунд цохин хангинаж байв. Бротто унталгүй, хүүхэн лам хоёрын амьсгалахыг чагнана. Түүний урьд цагийн сэтгэлийн зугаа цэнгэлийн бодит гэрч саран гийж мөнгөлөг туяа нь хонгилд нэвтрэн гараа атган нойрсогч Атенайсын бумбагар улаан уруул, цайвар үс, алтан шаргал сормуус, шулуун хамрыг гэрэлтүүлнэ.

— Бүгд найрамдах улсын заналт дайсан нь энэ шүү дээ гэж Бротто бодов.

Атенайсыг сэрэхэд үүр хэдийн цайчихсан байлаа. Гэлэн явж, Бротто цонхон дээрээ суун Лукрецийгээ уншиж латины урлагийн бурхнаас, яаж айх юмгүй хүсэх зүйлгүй аж төрөхийг суралцан байлаа. Гэсэн ч түүнийг харамсал түгшүүр эзэмдэх ажээ. Атенайс нүдээ нээн толгой дээрх нүцгэн дүнзийг хачирхсан байртай ажигласнаа юу болсныг санаад аврагчаа харан инээмсэглэж түүн тийш хөөрхөн бөгөөд хиртэй гараа эрхлэнгүй сунгав.

Хэвтрээсээ өндийн гэлэнгийн хоносон хуучин сандлыг зааж бүсгүйг

— Тэр хүн явчихаа юу? Намайг ховлохгүй байгаа, та юу гэж санаж байна? гэвэл Бротто

— Үгүй ээ хүүхээ. Энэ ухаан мулгуу өвгөнөөс өөр шударга хүн олоход хэцүү шүү хэмээн хариу өчив.

Атенайс, өвгөний ухаан муутай нь яаж мэдэгдсэн юм гэж асуулаа.

Өвгөн шашны сурталд автсан хүн гэж Броттог хэлбэл харин бүсгүй ийм юм юунд ярьж байгаа юм гэж нухацтай маягаар түүнийг зэмлэн, шашингүй бол хүмүүс адгууснаас ч дор болно гэв. Тэр өөрөө бол нүгэл хилэнцийг нь хэлтрүүлэн хүрээндээ авч их хайр хишиг хүртээнэ байх гэж горилон үргэлж бурханд мөргөдөг гэнэ.

Броттогийн гар дахь номыг ажигласан Атенайс жаягийн ном байх гэж таав.

— Хараач та ч бас бурханд мөргөдөг юм байна шүү дээ. Надад тус болсны тань хариуд тэнгэр бурхан таныг ивээг гэж тэр дуу алдлаа.

Энэ бол жаягийн ном биш, энэ нь ямар ч шашны ёслол үүсээгүй байх үед бичигдсэн ном гэж Броттог хариулахад нь бүсгүй, зүүдний ном юм байлгүй гэж санаад урьд шөнийн нь хачин зүүдийг тайлсан зүйл наана чинь байхгүй биз хэмээн асуув. Тэрээр бичиг үсэг мэдэхгүй, ийм хоёр төрлийн ном байдаг гэж дам сонссон ажээ.

Бротто, энэ бол амьдралын зүүдийг л тайлдаг ном гэж хариулав. Үүнийг ойлгоогүй гоо бүсгүй маань учрыг нь олох гэж оролдохоо байж. Броттогийн урьд хэрэглэж байсан мөнгөн төмпөнг орлосон шавар хувин руу тонгойв. Дараа нь эзнийхээ сахлаа хусдаг толинд харан үс гэзгээ нямбай бөгөөд хичээнгүй нь аргагүй янзалж гарав. Цагаан шараараа үсээ янзлах зуураа тэрээр хааяа нэг дуугарна.

— Та, лав дээр үед баян байсан байхаа даа.

— Хаанаас чи мэд ээ вэ?

— Өөрөө ч мэдэхгүй юм. Гэвч та баян байсан, та сурвалжит хүн, үүнд би итгэж байна.

Тэгээд тэрээр зааны ясан дугариг гуутай эх дагинын дүртэй мөнгөн бурхан, ётонгийн хэлтэрхий, утас, хайч, хэт, хоёр гурван зүүний хайрцаг хармаанаасаа гаргаж хэрэгтэй зүйлээ аваад хэд хэдэн газар урагдсан банзлаа оёж эхлэв.

— Биеэ аюулд учруулахгүйн тул энэ тэмдгийг оройвчиндоо хадчих, хүүхээ гээд Бротто гурван өнгийн тэмдэг түүнд сарвайвал

— Дуртайяа хадъя, ноёнтон минь, гэхдээ үндэстэнд хайртайгаас тэр биш, харин танд хайртайдаа тэр юм шүү гэж Атенайс хариу өгүүлэв.

Хувцаслаж, нямбай нь аргагүй засаж янзалснаа банзлынхаа хоёр ташаанаас барин тосгонд сурсан заншлаараа Броттод мэхэхийн — Ноёнтон минь, дуулгавартай зарц чинь гэлээ.

Бүсгүй буянт хүнийхээ ачийг юугаар ч хамаагүй хариулахад бэлхэн байсан боловч өөрөөс нь юу ч үл шаардсан, өөрөө ч тэгье ингэе гэсэнгүйгээ маш зохистой гэж үзэхийн дээр ёс зүйг сахин ингээд л салбал нэн аятайхан мэт түүнд бодогдоно.

Бүсгүйг шуудангийн сүйхээр Палезо орог гэж Бротто хэдэн цаасан тэмдэгт гарт нь атгуулав. Энэ нь түүний гарын бэлний тэн хагас нь байсан ба хэдийгээр хүүхнүүдийн гар цайлгах дуртай гэж нэрд гарсан боловч тэрээр нэгэнд нь ч тэгж нөхөрсөг байдлаар байдаг юмаа өгч байгаагүй билээ.

Бүсгүй түүнээс нэрийг нь асуусанд тэр — Намайг Морис гэдэг гэв.

Бротто, хонгилынхоо хаалгыг харамссан янзтай нээж өгөөд — Баяртай, Атенайс гэлээ.

Бүсгүй түүнийг үнслээ.

— Ноён Морис, хэзээ нэг цагт би сэтгэлд тань орвол намайг Марта гэдгийг санаарай. Энэ нэрээр намайг адисалсан, энэ нэрээр тосгоныхон намайг дууддаг байсан... Баяртай... Танд гялайлаа... Ноён Морис, таны дуулгавартай зарц чинь!

XV

Пиг дүүрсэн шоронг зайчлах хэрэгтэй байлаа. Амрах амсхийхийг умартан шүүх, шүүх хэрэгтэй байлаа. Урьдын шүүгчид алтаргана цэцгүүдийн дунд хуралддаг байсан шиг бараа бологчийн тууз, улаан малгайгаар чимэглэсэн ханын дагуу сууцгаах ‘Хувьсгалт онц шүүхийн гишүүд, вангийн шүүгчдийн ихэмсэг зан, туйлын амарлингуй байдлыг хадгална. Архидаж, нойргүй хонон үйлээ эдэлж ядарч зүдрэн тамаа цайсан олон нийтийн яллагч, түүний туслагчид, хамаг хүчээ шавхан биеийнхээ чилээг хөөж байсан бөгөөд тэгж тэгж эрүүл мэндээ дордуулан эмгэнэлтэйгээр эцэслэж байлаа.



Зарим нь боловсролтой, нөгөөдүүл нь бүдүүлэг, өөдгүй буюу талбиун сэтгэлтэй, дөлгөөн буюу догшин, хоёр нүүртэй буюу үнэнч зэрэг зан чанар, удам судраараа ондоо ондоо ардын төлөөлөгчид, цөмөөрөө эх орныг заналхийлэн буй аюул тулгарахад сэтгэл түгших юм уу, нэгэн хүсэл эрмэлзлээр буцлан буй дүр үзүүлж байлаа. Буян үйлдлээ гэсэндээ буюу эсвэл айсандаа харгис болсон тэд, цугаараа нэг дүлий дүмбэ оргиж хилэгнэсэн толгойтой нэгэн сэтгэлтэй нэгэн амьтан, төрөлхийн үүргээ гүйцэтгэн орчин тойрондоо үхлийн үрийг сацагч апокалипсийн⁵ нэгэн араатан шиг аашилж байлаа. Алахдаа ч тэр, аврахдаа ч тэр сэтгэлийн хөдөлгөөн ихтэй тэд, заримдаа гэнэт оргилсон өрөвч сэтгэлийн нөлөөгөөр, цагийн өмнө бол элэг доог хийгээд цаазын индэр лүү явуулах байсан ялтнаа, нүдэндээ нулимс мэлмэрүүлэн цагаатгадаг байв. Зорилгоо биелүүлэх талаар урагшаа

ахих тусмаа эдгээр хүн сэтгэлийнхээ зөн бэлгэт улам захирагдах болжээ.

Хэт ядран элий балай болсон тэд нар, гаднаас хатгуулан, дээрээс ирсэн тушаалд захирагдан, үзэгчдийн суудалд бөөгнөрөх санкюлот, «нэхмэлчдийн» сүрдүүлгээр албаар гаргасан мэдүүлэг, тунгаан эргэцүүлээгүй баримт дээр үндэслэн тархи мансууруулам, чих дөжрөм, чамархай лугшим, нүдэнд цусан манан хуралдуулагч бүгчим халуунд шүүсээр л байлаа. Ардын төлөөлөгчдийг ялтангууд нь хахуульдсан юм гэнэ гэдэг бүрхэгдүү яриа олны дотор гарчээ. Гэвч шүүх бүхий л бүрэлдэхүүнээрээ зэвүүцэн эсэргүүцэж, хайр гамгүй яллаж эл цуу үгэнд хариу цохилт өгч байв. Эцсийн эцэст эдгээр нь бусдаас дордох ч юмгүй, дээрдэх ч юмгүй хүмүүс билээ. Буян үйлдэхийн төлөө биш, жаргахын төлөө хүн нэрээ хиргүй байлгахыг боддог. Тэдний оронд очихыг зөвшөөрсөн хүн болгон яг л тэдэн лүгээ адил ажиллан, тэдэнд ноогдсон аймшигт үүргийг, нүглийг нь тэн хуваалцан биелүүлэх сэн биз ээ.

Өнө удаан хүлээлгэсэн, өвч хар хувцастай Антуанетта тэгж тэгж гайт суудалд суулаа. Олны жигшиж зэвүүцэж байгааг тийм гэхийн аргагүй агаад зөвхөн хэрэг чухам юугаар шувтрахыг нийтээр мэдэж байсан нь л зохих ёс журмыг сахих бололцоо олгож байв. Тавьсан аюултай асуудлуудад тэрээр амиа авч гарах гэсэн сэтгэлээсээ, эсвэл ердийн ихэмсэг зангаараа өчиг мэдүүлэх бөгөөд тэр ч атугай нэгэн яллагч шившигтэйгээр доромжлоход эх хүний сүрлэг байдлаар хариулт өгөв. Зөвхөн доромжлон гөрдөхийг л гэрч нарт зөвшөөрсөн хийгээд өмгөөлөгчид айсандаа хөшөө мэт болжээ. Австри хүүхний толгойг Европынхны нүүр өөд шалавхан шидэх гэж Онц шүүх нь, шүүх ажиллагааны бүхий л дүрэм горимд арга буюу захирагдан энэ бүхэн хэдийд дуусахыг хүлээж байлаа.

Мария - Антуанеттыг цаазалснаас хойш гурван өдрийн дараа үхлээ хүлээж буй Фортюне Трюбер лүү Гамленыг дуудав. Тэр, цэргийн хорооны албан тасалгаанд суусаар байгаад өвчнөө бүрмөсөн үгдрээсэн агаад тэндээс гучин алхам зайтай орших нэгэн хөөгдсөн варнавчийн жижиг өрөөнөө эвхмэл орон дээр хэвтэж байлаа. Түүний цонхигор толгой дэрэндээ шигдэн оржээ. Шил шиг болчихсон нүднийхээ манарсан харцаар тэр Эваристийг харан хатангир гараараа найзынхаа гарыг шүүрэн авч санаанд оромгүй чанга атгав. Сүүлийн хоёр өдөр

цээжнээс нь гурван удаа цус гарчээ. Тэрээр ярих гэж оролдсонд хоолой нь бөглүү бөгөөд сулхан хяхтнаснаа сүүлдээ арай тамиржин чангарав.

— Ватиньи! Ватиньи! Журдан дайсныг хуаранд нь бут цохижээ... Мобеж бүслэлтээ зогсоохоос өөр замгүй болсоон... Бид дахиад Маршьеныг эзэлсэн Ga ira Ga ira...

Трюбер инээмсэглэв.

Энэ бол өвчтөний дэмийрэл биш байлаа. Мөнхийн харанхуйн нөмөрч байгаа ухаан нь саруулхнаараа бодит байдлыг ухсаар ажээ. Сүрдсэн генералууд ялахаас өөр ямар ч зам алга гэдэгт итгэж, одоогоос дайсны дайралтыг няцаасан бололтой. Сайн дурынхныг элсүүлэх замаар байгуулж болоогүй хүчирхэг сахилга баттай армийг албан шахалтаар байгууллаа. Одоо жаахан л хүч гаргавал бүгд найрамдах улс аврагдах нь тэр.

Нүүрийг нь үхлийн сүүдэр хэдийнээ дайрсан Фортюне Трюбер цаг хагас мэдээгүй хэвтсэнээ сэргэн гараа өргөв.

Тэрээр тус тасалгаанд байгаа цорын ганц хогшил болох хуш модон бичгийн ширээг хуруугаараа заан

— Найз минь, Евдамид шиг би чамд өрөө гэрээсэлж үлдээе. Гурван зуун хорин ливр шүү... Нэрс нь тэнд... улаан дэвтэрт бий... Хагацья. Гамлен. Сонор соргог бай. Бүгд найрамдах улсынхаа харуулд зогс. Ga ira гэж хэдийгээр сулхан давчидсан дуугаар хэлсэн ч ухаан нь саруулхнаараа байлаа.

Үдэш болж, тасалгаанаа гэгээ тасрав. Амь нь гарагчийн хүндээр амьсгаадах, хумсаараа хөнжлөө маажих нь сонсогдоно.

Шөнө дунд тэрээр хэдэн холбоогүй үгс дуугарав.

— Ахиад шүү... Зэвсгийг нь хураа... Биеийн байдал уу? Маш сайн... Энэ хонхнуудыг буулга...

Өглөөний таван цагт тэр амьсгал хураалаа.

Секцийн захирамжаар варнавчуудын хуучин сүмд эх орны шүтээний дор, аяны орон дээр өөд болоочийн шарилыг тавьж гурван өнгийн тугаар ороон талийгаачийн тэргүүнд нь царсан титэм өмсүүлэв. Ромын орхимжтой дал модны мөчир барьсан арван хоёр өвгөн, урт нөмрөгтэй, цэцгийн хэлхээ барьсан арван хоёр охин шарилыг тойров. Талийгаачийн бойвын дэргэд хоёр хүүхэд, тус бүр уруу нь харуулсан бамбар барин зогсоно. Нэг нь хүүхдийн хэвлүүхэн байдал хайр хүрэм хөөрхнөөрөө ромынхны бунхан дээрээ барьдаг

дурлал, үхлийн тэнгэрийг санагдуулах, хаалгачийн охин Жозефина байхыг Эварист танив.

Марсельез ба «Ga ira»-гийн аялгуу дор нутаглуулах зорчлого Сент - Андре - дез - Ар оршуулгын газар тийш хөдөллөө.

Фортюне Трюберийн магнай дээр эцсийн удаа үнсээд Эварист уйлчлав. Үүргээ биелүүлээд мөнхийн нойроор нойрсогчид атаархан Гамлен өөртөө гашуудан уйлж билээ.

Гэртээ хариад тэр, коммуны Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилогдсон мэдээг авав. Дөрвөн сар орлогч байсан Гамлен, одоо хэдэн удаагийн санал хураалтын дараа гучхан хүний өгсөн саналаар өрсөлдөгч ч үгүй амар сонгогдох нь энэ ажээ. Секц эзгүйрсэн учир сонгоод байх хүн ч үгүй болсон бөгөөд баячуул, ядуус нийгмийн албанаас зугтаахыг аль болохоор хичээнэ. Хамшийн том үйл явдал ч хүмүүсийн урам зоригийг сэргээхээ байж, сонирхлыг нь татахаа өнгөрч, сонин уншдаг хүн алга болжээ. Нийслэлийн долоон зуун мянган оршин суугчдын дундаас гурав дөрвөн мянган эх орончид олдох болов уу, үгүй болов уу гэдэгт Эварист эргэлзэн байлаа.

Яг энэ өдөр Конвентын хорин нэгэн жирондчийг шүүн таслах хурал эхлэв.

Буруугүй буюу бүгд найрамдах улсын хийсэн гэмт хэрэгт гай тотгорт хувиа оруулсан буруутай, ихэрхүү, болгоомжгүй, биеэ тоосон, хөнгөн хоомой үүний зэрэгцээ хэр тааруу, улангассан, алан хядахдаа ч, өршөөл үзүүлэхдээ ч хулгамтгай, дайн зарлахдаа яаруу, түүнийг явуулахдаа назгай, өөрсдийн үзүүлсэн жишээгээр шүүхэд шилжсэн эдгээр хүн өчигдөр бол хувьсгалын өнгө жавхаа сүр хүчин нь байсан бөгөөд одоо ч гэсэн түүний орь залуугийн гал дөлийг хадгалсаар байх ажээ. Одоо тэднийг тун няхуур бөгөөд шунаг байцаах энэ шүүгч, ширээнийхээ дэргэд эдэнд гутамшигт үхлийг зэхэгч цусгүй цагаан царайтай энэ яллагч, өмгөөлөх үгийг ч сонсохыг хүсэхгүй байгаа энэ төлөөлөгчид, харааж, шүгэлдэж угтсан энэ олон түмэн — шүүгч төлөөлөгч, ард түмэн бултаараа сав саяхан тэдний уран цэцэн үгийг алга ташин угтаж, авьяас билиг, ач буяныг нь магтан шагшин байсан билээ. Гэтэл одоо тэд үүнийгээ санахгүй байна.

Нэг үе Верньо нь Эваристэд бурхан Бриссо нь зөнч мэргэн мэт бодогдож байсан. Гэтэл одоо тэрээр үүнийгээ ор тас мартсан агаад хэрвээ урьдын бишрэлээс нь ой тойнд нь өчүүхэн ч гэсэн ул мөр

үлдсэн ахул тэр нь эдгээр шилдэг иргэдийг уруу татсан мангас адилд үзэхийн төдий л байх.

Хуралдааны дараа Гамлен гэртээ хариад зүрх ширхийм уйлах дуу хадахыг сонсов. Труберийг хөдөөлүүлэх ёслолд оролцоход өмссөн сайхан цагаан даашинзаа талбай дээр хүүхэдтэй эрхлэн тоглож байж бохиртууллаа гэж эжийдээ зодуулж буй бяцхан Жозефина бархирсан нь тэр ажээ.

XVI

Эварист, хэрэгтний нэгийг өмчлөн авч өөртөө хамаатай тэр ялтанг биеэр шүүх хүртлээ гурван сарын турш өдөр болгон нэртэй нэргүй хүмүүсээр эх орондоо тахил өргөсөөр байв.

Гамлен онц шүүхэд ажилладаг болсноос хойш шүүхэд татагдан өмнүүр нь өнгөрөгчдийн дотроос Элодийн толгойг эргүүлсэн хүнийг цөхрөлтгүй бэдэрсээр байжээ. Ямагт юмыг дүрслэн сэтгэж явдаг тэрээр нөгөө хүний дүрийг төсөөлөн бодоход зарим нэг төрх байдал нь нүдэнд нь тов тодорхой бууна. Гамлен, түүнийг үзэсгэлэнтэй, омголон, залуу эр байх гэж төсөөлөн, яагаад ч юм Англи руу зугтсан байх гэдэгт итгэж байлаа. Гадаадаас Францад буцаж ирээд зочид буудлын эзний ховлосноор Пассид баригдсан, хэрэг нь нэгэн ижил өчнөөн төчнөөн зуун хэргийн хамт Фукье Тенвилийн гарт байгаа залуу Мобель л нөгөө хүн нь мөн мэт түүнд санагджээ. Баригдсан хүнээс гарсан захиаг, Мобелиас Питтын тагнуулуудтай хийсэн хуйвалдааны нотолгоо мөн гэж мөрдөн байцаалт үзжээ. Үнэндээ ч энэ нь Лондоны банкны эздийн захидал байсан ба Мобель үүнийг мөнгөтэйгөө хамт авч явжээ. Үзэсгэлэнтэй залуу эр Мобель юу юунаас ч илүү хайр сэтгэлд оосорлогдсон нь илэрхий. Энэ үед Францтай дайн хийж байсан Испанитай харьцаатай юм гэдгийг нь нотолсон тэмдэглэл өврийн нь дэвтэрт байсан бөгөөд энэ нь чухамдаа цэвэр янаг амрагийн шинжтэй аж. Гэвч хэрвээ шүүх батлах баримтгүй байхад ч Мобелийн хэргийг мөрдөхөө зогсоогоогүй бол тэр нь баривчлагдсан хүнийг суллахаа хэзээ ч яарах явдалгүй гэдэг зарчмыг баримталснаас тэр биз ээ.



Мобелийг анхлан байцаасан байцаалттай нарийвчлан танилцсан Гамлен, Элодийн итгэлийг хортойгоор ашигласан хүн нь тийм л төрхтэй гэж бодож байсантай нь залуу язгууртны байдал яв цав тохирсонд ихэд гайхжээ. Түүнээс хойш Эварист, Шүүхийн нарийн бичгийн даргын өрөөг хэдэн цагаар цоожлон сууж хавтаст хэргийг шунаг гэгч нь судалж гарав. Ялангуяа гадаадад дүрвэгчийн хуучин тэмдэглэлийн дэвтэрт «Амур - зураачийн» хаяг байхыг үзээд хэдийгээр хаяг нь «Ногоон сармагчин», «Дофины (агсны) хөрөг» болон бас бус хэв, зураг худалддаг мухлагуудын нэртэй цуг байсан боловч түүний сэжиг нь үлэмж ихсэв. Тэрхүү тэмдэглэлийн дэвтрийн завсраас торгомсог цаасанд нямбайлан хавчсан улаан лиш цэцгийн хэдэн илтэс гарсан гэдгийг мэдээд улаан лиш цэцэг бол Элодийн, цонхон дээрээ ургуулж үсэндээ хатгаж явдаг, бас хайр дурлалын тэмдэг болгон бэлэглэдэг (үүнийг өөрөө мэдэж байв) дуртай цэцэг нь мөн болохыг санан Эварист ер тээнэгэлзэхээ болив.

Түүний тааварлаж байсан зүйл нь үнэн болохтой хамт тэрээр гэмт хэрэгтнийг илрүүлэхэд тусалсан нөхцөл байдлыг нуун Элодийг байцааж үзэхээр шийдэв.

Өрөө рүүгээ шатаар өгсөж явахад нь бүр доод талын шатан дээрээс л жимсний согтоом үнэр ханхлав. Гэртээ орвол Элоди, Гамлен авгайд гадир жимс чанахад нь тусалж байлаа. Хөгшин эзэгтэй, зуухаа галлангаа жимснийхээ чанарыг муудуулахгүйгээр элсэн чихрээ яаж ариглаж хийдэг, нүүрсээ хэрхэн гамнаж түлдэг билээ гэж ухаан зарж байхад Блез бүсгүй сүрлэн сандал дээр суугаад бор маалинга хормогч зүүж, өвөр дээрээ овоолсон алтан шар гадир жимснээс арилган дөрөв хуваан зүсээд гуулин төмпөнд чулуудаж байлаа. Тэрээр, оройвч малгайныхаа чихийг ар тийш нь болгосон хийгээд хар үс нь хөлөрсөн дух руу нь мушгиран унжжээ. Тэрээр, дур хөдөлгөхгүй боловч энхэрхэн сэтгэл төрүүлэм уян налархай, чөлөөтэй талбиун, гэрийг тохь оруулсан, тансаг хөдөлгөөнөөр хөдлөх ажээ.

Байрнаасаа хөдлөлгүй, хүүхэн, янаг залуугаа хайлсан алт мэт сайхан нүдээрээ харж

— Хараа, Эварист, бид танд ажил хийж өгч байна. Өвөлжингөө та гадир жимсний царцмал идэж ходоодоо сайжруулан сэтгэлээ засна гэж хэлэв.

Гэтэл Гамлен түүнд ойртон чихэнд нь

— Жак Мобель... гэж шивнэв.

Энэ агшинд хагас нээсэн хаалганы завсраар гуталчин Комбалын улаан хамар цухуйлаа. Тэрээр шинэ өсгий хадсан шаахайны хамт урьд тахалсан гутлынхаа тооцоог авчирчээ.

Тэрээр муу иргэн гэдэг нэр авчихгүйн тул шинэ хуанли ашиглаж байв. Тооцоо тодорхой байхад дуртай Гамлен авгай, фруктидор, вандемьерын тоололд бүр будилчхав.

Авгай санаа алдан

— Есүс тэнгэр минь! Тэд, өдөр сар, улирал, нар, сарыг хүртэл өөрчлөх гэх юм. Бурхан минь, ноён Комбало, вандемьерын найманд юуны хос галош байдаг бил ээ?

— Өөрийнхөө хуанлийг харвал цөм тодорхой болно, авгай минь гэв.

Тэгэхэд нь авгай хананаас хуанлиа авч үзээд түүн рүү эргэн

— Наадах чинь христосынхоос тэс ондоо юм гэж айн дуу алдав.

— Тэр ч гайгүй, авгай, дөрвөн ням гарагийн оронд гуравтай болсон. Ингээд зогсохгүй ээ, мэд манай тооцооны системийг өөрчилнө. Сохор зоос ч байхгүй болж тооллын үндэс нь нэрсэн ус болох юм гэж гуталчин тосон авч өгүүлэв.

Энэ үгийг дуулаад Гамлен авгайн уруул нь татваганав. Тэрээр тайз ширтэн санаа алдсанаа

— Энэ ч бүр дэндэх нь ээ гэв.

Хөдөөгийн тэлүүрийн дэргэд дүрсэлдэг ариун эхнэрүүдийн дүрийг санагдуулам гашуудан байх хооронд цогшсон нүүрс дээрх тогоо улайсан өрөөгөөр л нэг хэншүү хярвас болон, гадирын бөөлжис хутгам үнэртэй холилдон агаарыг тэсвэрлэшгүй муухай болгов.

Элоди, хоолой загатнаад байна гэж гоморхон цонх нээхийг гуйлаа. Гэвч гуталчин явангуут Гамлен авгай зуух руугаа ирж, Эварист Блез бүсгүйн чихэнд

— Жак Мобель! гэж дахин шивнэлээ.

Бүсгүй, түүнийг нэлээд гайхсан янзтай харснаа, тайван гэгч нь гадираа дөрөв хуваан зүсэх зуураа

— Тэгээд яагаа вэ? Жак Мобель гэнэ ээ? гэж асуув.

— Нөгөөх чинь!

— Юун нөгөөх?

— Чиний улаан лиш бэлэглэсэн хүн.

Бүсгүй, юу ч ойлгохоо байлаа гээд учрыг нь тайлбарлахыг шаардав.

— Өнөөх язгууртан! Өнөөх гадаадад зугтагч! Өнөө өөдгүй солиг!
Элоди мөрөө хавчисхийлгэсэнээ, ямар ч Жак Мобелийг танихгүй
гэдэг чин үнэнээ хэллээ.

Үнэхээр ч тэр хүнийг ер мэдэхгүй байжээ.

Тэр хүүхний үгээр бол Эваристаас өөр хүнд улаан лиш цэцэг өгч
байгаагүй гэнэ. Гэвч тэр энэ талаар нэг л будилсан бололтой.

Эварист, бүсгүйчүүлийг сайн мэддэггүй, Элодийн зан араншныг
төдийлөн судлаагүй боловч цаадхыгаа үл мэдэгч болон байж чадах ба
түүнээс ч хашир догь хүнийг л араар нь тавьж дөнгөнө гэж үзэж
байлаа.

— Мэлзээд яах юм? Би мэдэж байна гэж Гамлен өгүүлэв.

Бүсгүй ямар ч Мобелийг огт танихгүй гэдгээ үнэмшүүлэх гэж ахин
оролдлоо.

Тэгээд гадираа цэвэрлэж дуусаад тэр, хуруу нь хоорондоо
наалдчихсан учир ус өгөөч гэж гуйлаа.

Гамлен, төмпөнтэй ус авчрав.

Гараа угаангаа, бүсгүй тэр хүнийг танихгүй гэдгээ дахин хэлэв.

Эваристыг, бүгдийг мэдэж байна гэж давтан хэлэхэд бүсгүй энэ
удаа юу ч дуугарсангүй.

Амрагийн нь ийн шалгаагаад байгаагийн учир хаашаа хэлбийж
буйг Элоди тааварласангүй, ер дуулаагүй тэр Мобель гэдэг хүнийг
Хувьсгалт шүүхэд татагдах юм гэж огтхон ч санасангүй. Эваристын,
залхтал юунд сэрдээд байгааг ойлгосонгүй боловч үүний огт оргүй
болохыг л мэдэж байв. Иймээс түүний сэжгийг арилгах горь тасрахад
хүүхэн ч ойлгуулах гэж улайрсангүй. Хартай хар хүүг өчүүхэн
санаандгүй тохиолдол ч зөв замд оруулчхаж магад тул түүнийг буруу
мөрөөр чулуу хөөлгөхийг эрхэмлэсэндээ Элоди, Мобельтай танил
гэдгээ ахин үгүйсгэсэнгүй. Түрүүчийн зүрхийг нь булаагч, эх оронч
дайчин болсон өчүүхэн бичээч залуу нь сурвалжит амрагтайгаа
хэрэлдсэн байлаа. Элодитой гудамжинд дайралдаад тэрээр «За, за
голшиг бүсгүй минь! Би чамаас больсондоо харамсан уучлал удахгүй
гуйна, өнөө биш ч гэсэн маргааш танд хайр сэтгэлээ буцааж өгнө» гэж
хэлэх мэт нэг жоготой харсан билээ. Иймээс бүсгүй, амраг залуугаа
жигтэйхэн бодлыг нь бүрэн ангижруулахыг оролдсонгүй. Гамлен ч,
Жак Мобель бол Элодийн толгойг эргүүлсэн хүн гэж итгэсээр үлдсэн
болно.

Дараа өдрүүдэд Онц шүүх, эрх чөлөөг, хөндий хэвэлтэн мэт залгихаар заналхийлж байсан федерализмыг дарахаар ааг амьсгаагүй ажиллаж байв. Энэ хүнд өдрүүдэд төлөөлөгчид ядран туйлдаж, бристончуудын гэмт хэрэгт оролцсон, тэднийг зоригжуулагч Ролан хүүхнийг цаазын бандан руу илгээхийн мөн болов.

Энэ завсар Гамлен, Мобелийн хэргийг түргэвчлэн нягталж үзэхийг шаардан өглөө бүр шүүхэд ирнэ. Чухал баримт сэлтийг Бордод хадгалж байсан учир Гамлен тэднийг авахуулахаар нэг комиссарыг шуудангаар зарж чадав. Тэгж тэгж баримт бичиг ч хүрэлцэн ирлээ.

Олон нийтийн яллагчийн туслах үүнтэй танилцаад Эваристэд ярвайн хэлсэн нь:

— Чухал юм юу ч үгүй цаас юм. Гоц гойд юм огт алга. Шал дэмий зүйл байна! Энэ гүн агсан Мобелийг гадаадад дүрвэсэн гэдэг итгэл ч атугай бидэнд байдаг сан бол!

Эцэстээ Гамлен санасандаа хүрэв. Залуу Мобель ялын төлөвлөгөө авч брюмерийн арван есөнд Хувьсгалт онц шүүхэд шилжин ирлээ.

Хурлын эхнээс аваад дарга, царайгаа баргар догшин дүртэй болгохыг оролдох бөгөөд тэрээр хэрэг тодорхойгүй байх болгонд ингэдэг билээ. Олон нийтийн яллагчийн нөхөр ичих нүүрээ илгээр хаагаагүй хүний байртай байхыг аль болохоор хичээн үзгээрээ эрүүгээ маажна. Нарийн бичгийн даргын уншсан ялын төлөвлөгөө нь ор үндэсгүйг үзээд бүгдийн гайхаш төрөв.

Даргыг, гадаадад дүрвэгсдийн эсрэг гарсан хуулийг мэддэг байсан уу гэж асуухад яллагдагч

— Тийм ээ, би мэддэг, дагаж мөрддөг байсан. Намайг Францаас явахад паспорт минь ямар ч зөрчилгүй байсан гэж өчив.

Англиар зорчин, нутаг буцаж ирэх болсон шалтгааныхаа талаар маш хангалттай тайлбарлалаа. Царай нь нүдэнд дулаахан бөгөөд түүний илэн далангүй ярьж, биеэ нэр төртэй авч байгаа нь хэргийг түүнд ашигтайгаар эргүүлэв. Тэндээс салдаггүй эмэгтэйчүүл хүртэл түүнийг найртай харцаар ширтэнэ. Францтай дайтаж байхад нь Испанид сууж байсан гэдэг ял тохоход тэрээр, тэр үед Байонноос ер гараагүй гэж батлав. Зөвхөн ганц зүйл л бүрхэг үлдлээ. Баригдахдаа зууханд хийснээс зөвхөн тасархай нь л үлдсэн цаасан дээр испани үг, мөн «Ниебес» гэдэг нэр бичсэнийг гарган уншиж болох байлаа.

Жак Мобель энэ талаар алив тайлбар өгөхийг эрс татгалзав. Үүнийг танилцуулах нь хэрэгтэнд тустай гэж даргыг хэлэхэд тэрээр

тус болох бүхэнд үргэлж захирагдах ёсгүй хэмээн мэдүүлэв.

Гамлен, Мобелийн өдүүлсэн ганцхан хэргийг л илрүүлэхийг чармайж хатсан цоморлогийг нь тэгж нямбай хадгалж байсан тэр лиш цэцгийн учрыг тайлбарлаж чадах эсэхийг даргаар гурвантаа асуулгав. Энэ цэцгэн дотор нуусан захиа байгаагүй болохоор шүүхэд ямар ч хамаагүй энэ асуудалд хариулах албагүй гэж үзэж байна хэмээн Мобель хариулжээ. Эдрээтэй хэргийн голыг үзтэл, хайр дурлалын нууц эзэлж байгаа аж гэж залуу эрд нааштайгаар сэтгэсээр төлөөлөгчид зөвлөлдөх тасалгаа руу орлоо. Энэ удаа хамгийн түргэн зантайнууд нь ч, хамгийн тууштай эх орончид ч түүний хэргийг цагаатгахаар саналаа дуртайяа өгөх байжээ. Тэдний нэг, хувьсгалд үнэнч гэдгээ харуулсан тайж байсан хүнийг

— Удам судраар нь түүнд зэм тохож болно гэж үү? Жишээлбэл би, язгууртан болж төрсөн завшаангүй хүн байгаа юм гэж хэлэхэд

— Тийм ээ, гэвч чи энэ орчноосоо холбоогоо тасалсан. Тэгвэл тэр түүнийхээ дотор одоо хүртэл байсаар байгаа шүү дээ гэж Гамлен татгалзав.

Тэгээд тэрээр, энэ хуйвалдагч, Питтийн нууц даалгавартан, эрх чөлөөний эсрэг дайсны нь босгохын тул ертөнцийн хязгаар луу эгээ л яваагүй, Кобургийн энэ хамсаатныг хилэгнэн дайрч, эх орончдын хатуу сэтгэлд төрж яддаггүй түгшүүрийг төрүүлэхүйц цогтой ярьж урвагчийг шийтгүүлэхээр болж билээ.

Тэдний нэг нь Гамленд

— Нөхөртөө үзүүлэхгүй байж болохгүй тус гэж бий хэмээн ичих ч үгүй хэлэв.

Олонхын саналаар алах ял заалаа.

Хэргээ таслуулагч хэнэггүйхэн инээмсэглэсээр тогтоолыг сонсов. Танхимыг тайван гэгч нь тойруулан харснаа харц нь Гамленыхтай тулгарахдаа өгүүлшгүй жигшлээр дүүрлээ.

Ноогдуулсан ялыг танхим таг чимээгүй сонсов.

Жак Мобелийг Консьержерт аваачлаа. Мөн оройгоо цаазлагдах байсан тул тэр мөчийг хүлээнгээ бамбарын гэрэлд нэг захиа ноороглов. «Хайрт эгч минь ээ, Онц шүүх намайг цаазаар авах ял зааж, хонгор хайртай Ниевесын минь насан өөд болсноос хойш амсаж болох цорын ганц баяр хөөрийг надад олголоо. Тэд, түүнээс минь хоцорсон зүйл болох анар цэцгийг, яагаадыг бүү мэд, лиш цэцэг гээд хурааж авсаан.

Би урлагт дуртай, аз жаргалтай байх цагтаа би Парист зураг, барын цуглуулга хийдэг байсан юм. Тэдгээрийг найдвартай газар нуусан, боломж дөнгөж гармагц танд дамжуулах байх. Хайрт эгч минь, түүнийг миний дурсгал болгон хадгалаарай би гуйя» гэжээ.

Туг үс хайчлан захиандаа хийж дугтуйгаа битүүмжлэн «Ла - Реоль, Мобель овогтой байсан Клеманс Дезеймерид» гэж хаяглав.

Тэрээр, байгаа бүх мөнгөө, захиаг хаягаар нь хүргэж өгнө үү гэж харгалзагчдаа өгөөд шил архи гуйж аван үхлээ хүлээх зуураа бага багаар балган очиж эхэллээ.

Оройн хоолны дараа Гамлен «Амур - зураач» тийш яаравчлан явж, Элодийн өөрийг нь шөнө болгон хүлээж байдаг хөх тасалгаанаа нисэх мэт гүйн орлоо.

— Чиний өсийг авсан! Жак Мобелийг хэдийнээ тонилгосон! Түүнийг цаазын газар луу авч явсан тэрэг бамбар барьсан цэргээр хүрээлүүлэн цонхон доогуур чинь гарсан гэж Эваристын хэлбээс бүсгүй учрыг ойлгон,

— Бузар амьтан! Чи л түүнийг алж, тэр чинь миний амраг биш байсан юм. Би түүнийг танихгүй... Тэр хүнийг би огт нүүр үзээгүй... Ямархуу хүн байв? Лав, залуу сайхан эр биз? Тэр чинь ямар ч гэм зэмгүй хүн! Гэтэл чи түүнийг алжээ, бузар амьтан! Бузар амьтан! гэв.

Тэрээр муужирч унав. Гэвч үхсэн мэт муурч унахдаа ч гэсэн тэр, айхын зэрэгцээ шунал тачаал нь бадрахыг мэдэрч байлаа. Ухаан дөнгөж оров уу үгүй, буусан аньсаганы нь цаанаас цагаан нүд нь үзэгдэн, цээж нь түрж тамиргүй унжсан гар нь амрагаа эрж байв. Бүсгүй, залууг элгэндээ наан, биед нь хумсаа шигтгэн амаа татвалзуулан ангайж уруулыг нь хамгаас чимээгүй, хамгаас битүүгээр, хамгаас удаанаар, хамгаас эмгэнэлтэйгээр, хамгаас сайхнаар шимж таалав.

Элоди, хар хүү рүү бүхий л бие цогцсоороо тэмүүлнэ. Цаадах нь хэчнээн хайр найргүй, догшин ширүүн санагдах тутам, хэчнээн хэлмэгсдийн цусанд гараа будах тусам нь хүүхэн төчнөөн их түүнийг мөрөөсөх ажээ.

XVII

Хорин дөрөвний өдрийн наран огторгуйд улбар ягаан туяагаа сацруулан мандаж шөнийн хүйтнийг үлдэн хөөж эхэлсэн өглөөний арван цагт варнавчуудын хуучин сүмд Аюулаас хамгаалах хорооны гишүүд иргэн Гено, Делурмель хоёр орж ирэн секцийн Ажиглах хорооны нийтийн хурлын танхимд оруулахыг шаардав. Энэ үед тэнд иргэн Бовизаж зууханд мод зэрэглэн сууж байлаа. Орж ирэгсэд Бовизажийг намхан болохоор нь тэр дороо олж харсангүй болно.



Ихэнх бөгтөр хүмүүсийн адил чичирхийлсэн дорой дуугаар иргэн Бовизаж төлөөлөгчдийг суухыг урин тэдэнд үйлчлэхэд бэлэн гэдгээ мэдэгдлээ.

Шинэ гүүрний ойролцоо суудаг тайж байсан дез Илеттийг таних эсэхийг түүнээс Гено асуув.

— Энэ этгээдийг баривчлах даалгавартай явна даа гэж тэр нэмж өгүүллээ.

Тэгээд Нийгмийг аюулаас хамгаалах хорооны тушаалыг үзүүлэв.

Бовизаж жаал бодсоноо, Дез - Илетт нэртэй хүнийг ер танихгүй юм. Музей, Нэгдэл, Марат, Марселийн зарим салбар газрууд Шинэ гүүрний дэргэд оршдог тул энэ нэр бүхий сэжигтэй этгээд энэ секцийн харьяа газар Суудаггүй байж ч мэднэ, хэрвээ энэ хүн тус секцэд байдаг бол хорооны тушаалд дурдсанаас өөр нэртэй байх, гэсэн ч ямар ч атугай удахгүй олдохдоо л олдоно гэж хариулав.

— Цаг алдахаа больё! Тэр хүний хамсаатан нэгэн эмэгтэйн захиаг зуураас нь олзлон Хороонд хоёр долоо хоногийн өмнө авчирч өгсөн боловч иргэн Лакруад, дөнгөж өчигдөр орой л түүний агуулгатай танилцах бололцоо гарчээ. Түүнээс бид хар авсан билээ. Бид хов

мэдээнд даруулж гүйцлээ, хэнээс нь эхлэхээ мэдэхээ байтал тийм олноороо энд тэндээс ирэх юм гэж Геног өгүүлбэл

— Хов мэдээ манай Ажиглах хороонд хүртэл ирж байна. Нэг хэсэг нь иргэнийхээ үүргийн үүднээс, нөгөө хэсэг нь зуун сугийн шангийн төлөө алтан хошуу өргөх юм. Өв хөрөнгөнд шунаглан эцэг эхээ ховлож байгаа хүүхдүүд гэдэг учир алгаа гэж Бовизаж бахархахгүй байж чадсангүй хариулав.

— Бириби тоглодог байсан сурвалжит хатагтай Рошморын энэ захиа, иргэн Ролины нэр дээр хаяглагдсан боловч үнэн хэрэг дээрээ Питтийн албанд байгаа нэгэн гадаадад зугтсан хүнд очих ёстой байж. Дез - Илеттэй холбогдох бүхнийг танд мэдэгдэхийн тул захиаг би авчирсан гэж Гено өгүүлэв.

Тэрээр халааснаасаа захиа гаргаж ирлээ.

— Энэ эмэгтэйн бичсэнээр бол одоогийнхоос илүү бэх бат шинэ засгийн үед өндөр тушаалд дэвшүүлнэ гэдэг амлалт буюу мөнгөөр хээл өгч болох Конвентын гишүүдийн нэрсийн урт жагсаалтаар уг захидал эхэлжээ. Дараа нь доорх зүйлийг бичсэн байна.

«Шинэ гүүрний ойролцоо, чөтгөр ч олохооргүй нэгэн дээврийн хөндийд суудаг ноён дез - Илеттийнхээр би саяхан орлоо. Тэр хатуу цаасаар хүүхэлдэй хийн хоолоо олж идэж буй ажээ. Түүний бодож байгаад утга зөв юм их байна, иймээс надад ярьснаас нь голыг нь танд уламжилъя. Одоогийн энэ байдал удаан тогтоно гэдэгт тэр итгэхгүй байгаа гэнэ. Одоогийн горим нь зөвхөн эвслийнхний ялснаар төгсгөл болно гэж бас тэр бодохгүй байгаа бөгөөд хэрэг явдал ч үзтэл, түүний саналыг баталж байна. Сүүлийн үед дайн хийх нь тийм таатай биш болж буйг та мэднэ шүү дээ. Шашинд гүн сүжигтэй эмэгтэйчүүд ч ихээхэн үүрэг гүйцэтгэх харц ардын бослогыг зэгсэн боломжтой төгсгөл юм гэж тэр тоолж байгаа ажээ. Хувьсгалт онц шүүхээс булт иргэдэд төрүүлсэн айдас мөд бүх Францыг яacobинчуудын эсрэг нягтруулна гэж таамаглаж байна. «Францын хатан хаан болон талх зөөгч эмсийг шүүж буй энэ Онц шүүх, Англичуудын сэтгэлд дотно Вильям Шекспиртэй төстэй юм гэх зэргээр» тэр хошигнож билээ. Робеспьер, вангийн охинтой гэрлэж биеэ, вант улсын өмөг түшиг гэж зарлахыг хэн байг гэх вэ гэж тэр санаж байгаа гэнэ.

Нигүүлсэнгүй ноёнтон минь ээ, хэрвээ та надад өгөх ёстой мөнгө, үүнд нэг мянган фунт стерлингийг урьд явуулдаг байсан замаараа нааш илгээвэл би машид баярлах сан. Гэхдээ ноён Морхардтыг

ойрмогхон барьж хорьсон тул түүнд захиа бичихээс болгоомжил...” гэж мэтчилэн юм бий.

— Ноён дез Илетт нааданхай хийдэг гэнэ ээ, хэдийгээр тиймэрхүү жижиг гар урчуул манай секцэд цөөнгүй боловч... энэ ч үнэтэй тэмдэг шүү гэж Бовизажийг хэлбээс

— Отгон охин Натальядаа хүүхэлдэй аваачиж өгнө гэж амласан минь санаанд орлоо. Охин маань улаан эсэргэнэ хүрсэн юм. Өчигдөр бие нь туурлаа. Өвчин нь нэг их аюултай биш боловч арчилгаа сувилгаа шаардах юм. Наталь маань насандаа ч байшгүй бие томтой, ухаантай хүүхэд, гэвч бие л султай даа гэж Делурмель хариулав.

— Би ганц хүүтэй. Тэр маань торхны цагариг түрэн, цаасан уугаар агаарын бөмбөлөг л хийж байдаг гэж Геног хэлбэл Бовизаж

— Хүүхдүүд тоглоомтой огт төсгүй юмаар голдуу наадах юм даа. Эмиль гэдэг, миний зээ болох долоон настай хүү бий. Түүний сэргэлэн гэдэг нь ээ, барилга барьж байна гэж шоо мод өрж өдөр өнжих юм... Та тамхилахгүй юу? гэснээ хоёр төлөөлөгч рүү хөөргөө сарвайлаа.

— За, одоо явж нөгөө мондийг барья. Өнөөдөр язгууртан шиг хомхой идэж, аяга цагаан архиар даруулчихаас буцахгүй л байна гэж урт живэрт Делурмель нүдээ догшноор эргэлдүүлэн хэлэв.

Дофины талбайд дез Илеттийг таних байж магадгүй найз ахмад Дюпоны мухлаг руу очихыг Бовизаж зөвлөлөө.

Секцийн дөрвөн цэргийг дагуулан тэд цэвэр агаар амьсгалсаар явцгаав.

— «Ван, Аймшигт шүүхэд» гэдэг ший үзсэн үү? хэмээн Делурмель цуг явагсдаасаа асуугаад — үзвэл зохих жүжиг дээ. Зохиолч, Европын вангуудыг, эцсийн эцэст өөрсдийг нь залгиж буй галт уулын хормой дахь зэлүүд арал дээр нуугдаж байгаагаар үзүүлсэн юм билээ. Ёстой эх оронч зохиол доо гэв.

Гарлей гудамжны өнцөгт оройвчныхоо дээрээс хулдаасан бүрх малгай давхарлаж өмссөн нэгэн эмгэний түрж яваа сүмийн доторх шиг гялтганах жижиг тэргийг Делурмель заан

— Юуны наймаа хийдэг юм бол? гэж асуув.

Эмгэн өөрөө:

— Ноёд оо, үүнийг харцгаа. Төрөл бүрийн эрих, зүүдэг загалмай, Антония хутагтын дүр, зурмал бурхан, Ариун вероникийн алчуур, Ессе Ното Айпиз Ое, Губерт гэгээний бөгж, анчны бүрээ, мөн шашны ёслолын элдэв зүйлс, ер нь есөн шидийн юм бий шүү гэж хариулсанд

— Энэ чинь мухар сүсэгтнүүдийн л хэрэгсэл ёсоороо мөн байна гэж Делурмель эгдүүцлээ.

Тэрээр эмгэнийг бүр ултай байцаахаар шийдсэн авч цаадах нь асуух тоолон нь

— Хүү минь, энэ барааг би дөчин жил зарж байгаа юм гэдэг нэгэн өгүүлбэрээр өчнө.

Нийгмийг аюулаас хамгаалах хорооны төлөөлөгчдийн нэг нь албаны хөх хувцастай цэрэг дэргэдүүрээ өнгөрөхийг үзээд гайхаж хоцорсон эмгэнийг Консьержерт хүргэж өгөхийг тушаав.

Чухмыг хэлбэл, наймаач эмгэнийг Ажиглах хороо л барин секцэд аваачих ёстой байх, тогтож буй засагт зохицуулан үйлчлүүлэхийн тулд шүтлэгийн талаар ямар бодлого баримтлах нь зүйтэйг, цөмийг зөвшөөрөх буюу хорих байна уу, үгүй юу гэдгийг хэн ч мэдэхгүй байгаа гэж иргэн Бовизаж Делурмельд хэлэв.

Мужааны, дархны газар дөхөж очингоо төлөөлөгчид, комиссар нар ууртайяа хашхиралдах, хөрөө хяхтнах, харуул сүр сар хийхийг сонсов. Энэ нь ахмад Дюпан, айлынхаа хаалгач Ремакльтай хэрэлдсэн нь тэр байлаа. Хазаарлан тогтоошгүй нэгэн хүчинд хөтлөгдөн мужааныд байнга ороод туж зомгол, үртэс болчихсон гэртээ ирдэг Ремакль авгайгаас болж хамаг хэрүүл үүссэн юм санжээ. Доромжлуулсан хаалгач, мужааны нохой Мутоньг өшиглөчихжээ. Гэтэл яг тэр үед нь төрсөн охин Жозефина нь нохойг тэврэн сууж байжээ. Цухалдсан Жозефина эцгийгээ хараан загнахад мужаан ууртаа багтран

— Өөдгүй хог! Нохойг минь зодохоо боль гэж бархирсанд Ремакль

— Би тэгвэл гээд шүүрээ далайн, — Би чамайг, миний эхнэр... гэтэл мужааны харуул толгойных нь дээхнүүр шүнгэнэн гарч үгийг нь таслав.

Төлөөлөгчдийг дагуулан иргэн Бовизажийг алсаас харсан тэрээр тосон гүйж

— Иргэн комиссар, энэ тонуулч намайг золтой л алсангүй, чи нүдээр харлаа шүү хэмээн хашхирав.

Гүйцэтгэж буй албан тушаалыг нь ялгах тэмдэг болох улаан малгай өмссөн иргэн Бовизаж эвлэрүүлэнгүй урт гараа сунгаснаа мужаан, хаалгач хоёрт хандан

— Нийгмийг аюулаас хамгаалах хорооны эрж байгаа сэжигтэй этгээд хүүхэлдэй хийдэг тайж байсан дез Илеттийн байрыг хэн зааж

өгсөнд чинь зуун су өгнө гэлээ.

Хаалгач, мужаан хоёр ам өрсөлдөн Броттогийн гэрийг заагаад ховлогчид амласан зуун сугийн цаасан тэмдэгтийг одоо хэн нь авах тухай зөрөлдөж гарав.

Дөрвөн торгон цэрэг, хаалгач Ремакль, мужаан Дюпан болон айлын арван хоёр жаалыг дагуулан Делурмель, Гено, Бовизаж гурав хөл дор хотолзох гишгүүрээр цувран өгссөнөө, өөд нь түшүүлсэн шатаар авирав.

Бротто, таазныхаа нүхэнд хүүхэлдэй сийлэн эцэг Лонгмар өмнө нь сууж тус тусдаа байгаа хэсгүүдийг утсаар нийлүүлэн холбох агаад хүүг нь гарын хөдөлгөөн хэрхэн нэгэн хэмээр эвлэг уян хөдлөхийг харж инээмсэглэн бахдаж суужээ.

Үүдэнд бууны бөгс мод тог хийхийг дуулахдаа Лонгмарын бүх бие дагжин чичирсэн нь туйлын амгалан байдлаа хадгалсаар буй Броттогоос аймхайнх биш, харин орчны нь хүмүүс түүнийг хүндэлдэг нь бие барих талаар санаа тавих явдлаас түүнийг өнөө болтол ангижруулсных билээ. Иргэн Делурмелийн асуултаас цохилт хаанаас ирж буйг Бротто гадарлан эм хүнд итгэснээс эрхий хуруундаа итгэсэн нь дээр гэдгийг нэлээд хожуу ухаарчээ. Иргэн комиссарын хамт явна уу гэхэд тэрээр, Лукрецийгээ, гурван цамцтай авав.

Тэгээд эцэг Лонгмарыг заан

— Энэ иргэн миний гар хөл болдог хүн, би үүнийг хүүхэлдэй хийлцүүлэхээр авсан билээ. Энд, энэ хонгилд байдаг юм гэв.

Гэтэл гэлэнд иргэний итгэмжлэх бичиг байсангүй учир түүнийг Броттотой хамт барилаа.

Хаалгачийн оромжийн хажуугаар тэднийг гарахад Ремакль авгай туужуугаа түшин, хуулийн мутарт атгуулсан гэмт хэрэгтнийг үзээд баярлагч буянтны харцаар Броттог харж билээ. Жаалхан Жозефина, хөөрхөн царайдаа жигшил тодруулан, нэг бус удаа ёотон өгч байсан хуучин андынхаа гарыг долоох гэж зүтгэсэн Мутоны хүзүүвчнээс татав. Хэрэгт дуртай олон Тионвиллийн талбайд дүүрлээ.

Шатны доод чөлөөнд Бротто, дээшээ өгсөхөөр завдаж байсан залуу тариачин бүсгүйтэй тааралдав. Тэрээр нэг тохойдоо өндөгтэй сагс өлгөж, нөгөө гартаа ам даавуунд боосон том бин барьжээ. Энэ бол аврагчдаа баярласны тэмдэг болгож жаал зугаа бэлэг өгөхөөр Палезогоос ирсэн Атенайс байлаа. Ямар нэгэн албаны хүмүүс, дөрвөн

цэргийн хамт «ноён Морисыг» авч явааг үзээд тэрээр нүдэндээ ч итгэсэнгүй зогтуссанаа комиссарт дөхөж очин

— Та нар энэ хүнийг аваачих гээгүй биз дээ? Энэ болшгүй хэрэг... Тануус энэ хүнийг ер мэдэхгүй байна! Бурхан тэнгэрээс ч сайн хүн байгаа юм гэж эелдгээр өгүүлэв.

Иргэн Делурмель түүнийг түлхэн урагш явахыг цэргүүдэд тушаалаа. Тэгтэл Атенайс төлөөлөгч цэргүүдийг муу муухайгаар нь дуудан, хараал зүхэл урсгаж гарсан нь муу усны савны бүх угаадсыг толгой дээрээс нь цацчих мэт тэдэнд санагдаж билээ. Дараа нь бүсгүй Тионвиллийн талбай даяар цуурайтуулан, алмайран зогсогч олныг давхийтэл

— Ван мандтугай! Ван мандтугай! гэж хашхирчээ.

XVIII

Гамлен авгай өвгөн Броттог хайрлан энэ насандаа уулзаж явсан улсаасаа хамгийн элэгсэг хүндтэй хүнд түүнийг тоолдог байлаа. Засгийг хүндлээгүй болох болов уу гэж айсандаа, хүчтэний өмнө өөрийн дорд байранд хүлцэнгүй номхон байж заншсандаа, мөн айж эмээх явдлыг үүргээ гэж үздэгтээ Броттог баривчлагдах үед салах ёс хийж чадаагүй билээ. Энэ явдал яагаад ч тайтгарч чадамгүйгээр түүний сэтгэлийг донсолгожээ.

Аяга хоол ч хоолойд нь орохоо байж, эцсийн эцэст яг гэдэс цатгалан амьдрах боломжтой болсон үедээ ингэчихсэнд тэр гашуудна. Тэрээр хүүгээрээ бахархсаар байсан хэдий авч Эваристын хийж буй аймшигт ажлыг бодохоосоо ч айн өөрийн саналыг хэлэхгүй байх эрхтэй жирийн, бүдүүлэг эмэгтэй болсондоо баярлана.



Хөөрхий эх хайрцгийн ёроолоос хуучин эрих олоод яаж хэрэглэдгийг сайн мэдэхгүй боловч чичирхийлсэн хуруугаараа үргэлж имрэн байх болов. Насанд дарагдталаа шашин шүтээгүй авгай одоо бурханд сүжигтэй болж зуухныхаа дэргэд суун хүү болон сайн ноён Броттог аврахын тулд мөргөн залбирч өнждөг болжээ. Элоди түүнийг дандаа эргэж ирэх ба хоёр эмэгтэй зэрэгцэн сууцгааж бие биеийнхээ нүдийг эгцлэн харж зүрхлэхгүй, өөрсдөдөө ямар ч хамаагүй дэмий юм ярилцдаг байлаа.

Цас малгайлан хаялж, тэнгэр бүүдийн, хотын дуу чимээ бүр бөглүү сонсогдох нэгэн зэвэргэн өдөр гэртээ ганцаараа байсан Гамлен авгай хаалга тогшихыг сонсов. Хэдэн сарын турш яльгүй чимээ гарахад ч тэвдэн сандардаг болсон авгай хирдхийв. Авгайг хаалга нээхэд тасалгаанаа арван найм хорь эргэм насны залуу хүн малгайгаа ч авалгүй орж ирлээ. Цээжийг нь бүрхэн бүслэхийг нь хүртэл унжсан

гурван давхар захтай хар ногоон давхац, түрийг нь эргүүлсэн англи шаахай өмсжээ.

Хүрэн үс мөр лүүгээ мушгиран буужээ. Тэрээр цас дарсан цонхоор нэвтрэх бүх гэрэл өөр дээр нь тусаг гэсэн мэт тасалгааны голд очин хэдэн хором хөдөлгөөнгүй дуугүй дороо зогсов.

Гамлен авгайн гайхан харж байхыг үзээд тэрээр

— Та охиноо танихгүй байна уу? гэж асуулаа. Эмгэн гараа дэлгэн

— Жюли! Энэ чинь чи юу?

Нээрээ юу? гэсэнд

— Тийм ээ, би. Ээжээ намайг үнсээч гэв.

Бэлэвсэн авгай Гамлен охиноо тэврэн давхцын нь зах дээр нулимс дуслуулна.

— Чи Парист иржээ! гэж илтэд түгшсэн янзтай дуу алдав.

— Ээ, ээж минь, би яагаад ганцаараа ирээгүй вэ гээч! Намайг ийм хувцастай хэн ч танихгүй шүү.

— Үнэндээ ч давхац биеийн нь хэлбэрийг халхлан, бүсгүй, түүн шиг халз хагалсан урт үстэй өдий төдий залуусаас огт ялгарах юмгүй ажээ. Наранд борлосон, ядарч туйлдсан, зовлонгоос ширүүн болсон дур татам нимгэн царайд нь эрэмгий зориг тодорно. Туранхайдуу, гоолиг, урт мөртөө эгцхэн хөлтэй тэр биеэ чөлөөтэй авч явах ба гагцхүү хэт цангинасан дуу нь нууцыг нь задруулж мэдэх байлаа.

— Эхийнхээ өлсөж байгаа эсэхийг нь асуухад бүсгүй дуртайяа жаахан юм идмээр л байна гэж хариулав. Эхийнхээ, өмнө нь талх, архи, гахайн утсан мах тавьсанд Баубо өвгөний овоохой дахь өлссөн Церера бүсгүй шиг үзэсгэлэнт Жюли ширээний ирмэг тохойлдон ховдгоор идэж эхлэв.

Дарсаа бага багаар балган тэрээр

— Ээжээ ах хэзээ ирэх бол, та мэдэхгүй биз? Би түүнтэй ярихаар ирсэн юм гэжээ.

Эх нь сандран хүүхнээ харснаа юу ч дуугарсангүй.

— Түүнтэй уулзах хэрэг байна. Нөхрийг маань өнөөдөр баривчлан Люксембург руу аваачсан.

Бүсгүй, Бульегийн нэгэн хорооны офицер, тайж байсан Фортюне де Шассаныг нөхрөө гэжээ. Залуу Ломбардын гудамж дахь үйлчний газар оёдолчноор ажиллаж байхад нь Жюлитэй явдаг болсон, сүүлд нь найман сарын аравны дараа гадаадад зугтахдаа Англи руу босгон аваачсан юм. Тэрээр Жюлийн нууц амраг нь байсан авч эхдээ түүнийг

нөхрөө гэвэл арай зохистой гэж үзжээ. Туулсан зовлон нь тэднийг гэрлүүлсэн, гагц анх далдуур ханилсан явдал л гай тотгор болж байна гэж тэр үнэхээр тооцно.

Лондоны цэцэрлэгт, бандан сандал дээр хоёул өчнөөн шөнийг өнгөрөөсний дээр Пикадиллийн гуанзанд ширээн дороос талхны хальс түүж идэх хэрэг нэг бус удаа гарсан билээ.

Эх нь хариу дуугарсангүй түүнийг гунигтайгаар ширтэнэ.

— Ээжээ та миний үгийг сонсохгүй байна уу? Цаг биднийг хүлээхгүй. Эваристтэй шалавхан уулзах хэрэг байна. Тэр л Фортюнег аварч чадна.

— Жюли, чи ахтайгаа ярилцаагүй нь дээр гэж эх нь хариуллаа.

— Юу? Ээж ээ, та юу гэв ээ?

— Ноён Шассанегийн тухай ахтайгаа ярилцаагүй нь дээр гэж би чамд хэллээ.

— Гэсэн ч энэ нь хамгийн чухал байна, ээж минь!

— Хүү минь, чамайг босгуулан аваачсанаас хойш ноён Шассанийг Эварист одоо болтол уучлахгүй байгаа билээ. Түүний тухай ярихдаа хэчнээн уурладгийг, юу гэж түүнийг нэрлэдгийг чи мэднэ шүү дээ.

— Тийм ээ, Эварист түүнийг садар самуун гэдэг байсан гээд Жюли мөрөө хавчисхийлгэн огцомхон инээвхийлэв.

— Хүү минь, тэр үхтлээ доромжлуулсан. Ноён де Шассаний нэрийг хэзээ ч дурсахгүй гэдэг ам өөртөө өгсөн юм. Тэгээд ч чиний тухай ч, түүний тухай ч ганц үг дуугарахаа больсоор хоёр жил боллоо. Гэвч сэтгэл нь хувираагүй ээ. Чи түүнийг мэднэ, тэр тануусыг уучлаагүй.

— Гэсэн ч, ээж ээ, Фортюне бид хоёр Лондонд гэрлэх ёслол хийсэн шүү дээ...

Хөөрхий эх дээшээ харан гараа дэлгэж

— Фортюне язгууртан, гадаадад зугтсан нь Эварист түүнийг дайсан мэт үзэхэд хангалттай гэв.

— Ээжээ та шулуухан хэлчих. Хэрвээ олон нийтийн яллагч болон, нийгмийг хамгаалах хороонд очиж Фортюнегийн хойноос хөөцөлдөж өгөөч гэж Эваристаас гуйвал тэр зөвшөөрөхгүй гэж та бодож байна уу? Ээжээ надад үүнийг татгалзахын тулд хүний үнэргүй байх хэрэгтэй шүү дээ!

— Хүү минь, ах чинь шударга ч хүн, сайн ч хүү. Гэвч ноён де Шассаний хувь заяанд оролц гэж түүнээс бүү шаард, гуйя чамаас, бүү

шаард... Жюли сонс, тэр санаснаа надад хэлдэггүй юм. Бодвол би түүнийг ойлгохооргүй юм байгаа биз... Гэвч тэр бол, хатуу баримталсан үзэлтэй шүүгч, бас шударга ч ажиллаж байгаа. Жюли түүнээс юу ч битгий гуй.

— Үзвэл, түүний тарыг одоо л таниа шив. Түүний цэвдэг дотортой, хатуу сэтгэлтэй муу санаатай, эзэрхэх дуртай ихэрхэг зантайг та мэднэ. Гэтэл та түүнийг надаас дээрд үздэг байсан. Хамт аж төрж байхад та намайг түүнээс үргэлж дуурайл ав гэдэг сэн. Түүний няхуур хөдөлгөөн, нухацтай үг танд сэтгэгдэл төрүүлж, та түүнийг буянтай хүн гэж үздэг байлаа. Заль мэх гаргалгүй, мод өөд асаж авирч байдаг байсан болохоор минь надад л та муу л болгоныг тохоон намайг л дан зэмлэдэг сэн. Та намайг үзэж чаддаггүй мөртөө түүнийг ганцаарыг нь хайрладаг байсан. Таны тэр Эваристыг би үзэн яддаг юм, мэдэж ав! Тэр бол хоёр нүүртэн.

— Дуугаа тат, Жюли. Чамд ч гэсэн, түүнд ч гэсэн би сайн эх чинь байсан. Би чиний гарыг ганзаганд хүргэсэн. Чи шударга биш бүсгүй болж, манай давхаргын хүнтэй суугаагүйд би буруугүй. Би чамайг энхрийлэн хайрладаг байсан, хайрласаар ч байгаа. Чамайг өршөөгөөд хайрлаж байна биш үү. Гэвч чи Эваристыг бүү муул. Тэр хачин сайн хүү. Тэр намайг байнга бөөцийлж байдаг юм. Чамайг орхиод яваад өгснөөс чинь хойш ажлаа, дэлгүүрээ хаячхаад ноён Шассанийд очсоноос хойш хэрвээ Эварист байгаагүй бол би яах байсан болоо? Би гачигдаж өлсөж үхэх сэн биз ээ.

— Ээж ээ, тэгж битгий ярь хэрвээ та Эваристын нөлөөнд орж биднээс нүүр буруулаагүй бол Фортюне бид хоёр таныг асран өргөх байсан гэдэг тов тодорхой шүү дээ. Эварист сайн үйл хийж чадахгүй, намайг бүү ятга. Тэр намайг үзэн ядуулах гэсэндээ л таныг асрамжилж байгаа дүр үзүүлж байгаа юм Эварист! Танд хайртай гэнэ ээ? Тэгвэл тэр ер нь хүнийг хайрлаж чадах юм гэж үү? Түүнд ухаан, сэтгэл гэж үгүй. Тэр шал дүйгүй авьяасгүй хүн. Уран зураач хүн арай илүү гарын уртай байх хэрэгтэй.

Тэрээр, Эваристын даавуун дээр зурсан зургийг гүйлгэн харснаа явахад нь ямар үлдсэн тэр чигээрээ байгааг ажиг.

— Үүний сэтгэл нь энэ байна! Цэвдэг хүйтэн уй гашуутай сэтгэл бодол нь даавуунд нь шингэжээ. Гадсан дээр суулгасан хүнтэй төстэй, гөлийсөн харцтай, жигшим амтай Орест, түүний Орест бол яахын аргагүй тэр өөрөө мөн шүү дээ... Ээж ээ, та дуулж бай, та ойлгохгүй

байна гэж үү? Би Фортюнег шоронд орхиж чадахгүй ээ. Энэ якобинчууд эх орончид Эваристын энэ бүх бүлгийг та мэднэ шүү дээ. Тэд нар түүнийг ална. Ээжээ хайрт ээж ээ, ижий минь ээ, тэдэнд түүнийгээ алуулахыг би хүсэхгүй байна. Би түүнд хайртай! Би түүнд дуртай! Та надад хачин сайн байсан, тэр бид хоёр даанч их зовлон амссан! Миний өмсөж яваа давхац түүний минь юмаа. Надад алд биеэ хаацайлах ам даавуу ч байгаагүй. Фортюнегийн нэг найз нь надад хүрмээ бүр өгч, Дуврад би нимбэгийн шүүсний худалдаачныд ажилд орж, тэр маань үсчний дагалднаар ажиллаж байгаа. Францдаа буцаж ирнэ гэдэг бол амь дүйсэн хэрэг гэдгийг бид сайн мэдэж байсан боловч биднийг Парист орж чухал даалгавар биелүүл гэсэн юм аа... Бид зөвшөөрсөн, ер нь чөтгөрийнд оч ч гэсэн, юу ч хий гэсэн даалгавар байсан ч авах л байсан юм аа. Бидэнд замд хэрэглэх мөнгө, Парисын нэг банкны эзнээс мөнгө авах баримт өглөө. Гэтэл түүний албан тасалгаа нь хаагдан тэр шоронд ороод өнөө маргаашгүй цаазлуулах гэж байгаа ажээ. Бидэнд сохор зоос ч байсангүй. Бидний холбоотой байсан, бидний очиж болох байсан улсын зарим нь зугтаж, зарим нь баригдсан байлаа. Очмоор айл бидэнд ганц ч байсангүй. Толгойгүй хүүхний гудамжинд морины жүчээнд хоног төөрүүллээ. Сүрлэн дээр бидэнтэй цуг хоносон өр зөөлөн нэг гутал тослогч хайрцгийнхаа нэгийг сойзоо, дуусах шахсан лаазтай тосоо түр хэрэглүүлсэн. Фортюне, Гревийн гудамжинд хоёр долоо хоног гутал тослон хоёр биеийнхээ голыг зогоолоо. Гэтэл даваа гарагт коммуны нэг гишүүн түүн рүү ирэн хайрцаг дээр нь хөлөө тавьж гутлаа арчуулах гэсэн юм. Урьд махны худалдагч байсан тэр луйварчныг мах дутуу жигнэлээ гэж Фортюне бөгсийг нь нэг удаа сайн өшиглөсөн юм санжээ. Фортюне авбал зохих хоёр сугээ авахаар толгойгоо өндийлгөвөл бузар амьтан чинь түүнийг таньж язгууртан гэж дайрч давшлан баривчилна гэж сүрдүүлжээ. Улс цугларч, тэдэн дотор ёозгүй этгээдүүд байж «гадаадад зугтаагчийг тонилго» гэж хашхиралдан цагдаа дуудаж гарсан байна. Яг энэ агшинд би Фортюнед шөл авч ирсэн юм. Нүдэн дээр минь түүнийг секц рүү аваачин Иоаны гэгээний сүмд хийж цоожиллоо. Би түүнийг тэврэх гэсэн чинь цаадуул нь намайг түлхсэн. Би нохой аятай сүмийн довжоон дээр шөнийг өнгөрөөлөө... Өнөө өглөө түүнийг аваад явсан...

Жюли цурхиран уйлсандаа багтран үгээ гүйцээж хэлж чадсангүй.

Тэрээр малгайгаа шалан дээр авч хаян эхийнхээ өмнө өвдөг сөхрөн унав.

Түүнийг өнөө өглөө Люксембургийн шорон руу авч явсан. Ээж ээ, ээж ээ, түүнийг аврахад туслаач! Охиноо өрөвдөөч!

Нус нулимс болсон тэрээр давхцын заамыг яран, амраг бүсгүй ээжийн охин гэдгээ амархан таниулахын тулд хэнхдэгээ гаргаад эхийнхээ гарыг шүүрэн авч чичирч буй цээжиндээ наалаа.

— Жюли, хайрт охин минь, Жюли минь! гээд бэлэвсэн авгай Гамлен санаа алдав.

Тэгээд нулимс болсон нүүрээ залуу бүсгүйн хацарт наав.

Хэсэг зуур чимээгүй болцгоолоо. Хөөрхий эх охиндоо хэрхэн тус болох билээ гэж бодлогошрон, Жюли ч эхийнхээ уйлсан нүднээс нь харцаа үл салгана.

«Юу магад, хэрвээ би түүнтэй ярьж үзвэл түүнийг зөөлрүүлж юу магад. Хүү минь зөөлөн сайхан сэтгэлтэй сэн. Хэрвээ улс төрийн бодлого түүнийг харгис догшин болгоогүй сэн бол, хэрвээ якобинчуудын нөлөөнд автагдаагүй сэн бол юмны учир ойлгохгүй намайг айлгаж байгаа тийм хатуу ширүүн болоогүй байх сан» гэж Эваристын эх бодно.

Тэрээр Жюлийн толгойг хоёр гараараа тэврэн

— Охин минь сонс. Бид Эваристтай ярья. Би түүнийг чамтай уулзуулах бэлтгэл хийе. Тэгэхгүй бол чамайг гэнэт үзээд уурлан хилэгнэж мэднэ. Би түүний анхны хөдөлгөөнөөс л айна... дараа нь би ахы чинь мэднэ. Чиний энэ гоёл түүнд аятай бус санагдах нь дамжиггүй, тэр зан заншил ёс горимтой хамаатай бүхэнд маш нарийн ханддаг хүн. Жюлигээ эрэгтэй хүний хувцастай байхыг үзээд би ч багагүй гайхсан шүү.

— Ээ, эжий минь, гадаадад зугтсан, вант улсад гарсан аймшигт явдлууд хувцас сольж өмсөхийг ердийн зүйл болгосон. Ажил хийхийн тулд, танигдахгүйн тулд хүний паспорт юм уу итгэмжлэх бичгээр амьдрахын тулд ингэнэ шүү дээ. Лондонд Жире гэдэг залуу, эмэгтэй хүний хувцас өмссөн байхыг үзсэн, тэр маш сайхан бүсгүй болсон байж билээ. Гэвч ээж ээ, тийм баг минийхээс долоон дор гэдгийг зөвшөөр.

— Хайрт охин минь, үүгээр ч гэсэн, өөр бусад юмаар ч гэсэн надад биеэ цагаатгах гэсний хэрэггүй. Би эх чинь, чи надад хэзээ ч цэвэр байх болно. Би Эваристтай ярья, түүнд хэлье...

Тэр өгүүлбэрээ дутуу орхив. Хүүгийнхээ хэн болохыг гадарлаж байлаа, гадарлаж байсан ч үүнд итгэхийг хүссэнгүй, мэдэхийг ч

хүссэнгүй.

— Түүний сэтгэл сайхан. Магад... чамд миний гуйсан болгоныг хийж өгнө.

Туйлгүй ядарсан хоёр эмэгтэй дуугаа хураацгаав. Хүүхэд байхдаа дэрлэн унтдаг байсан өвдгөө дэрлэн Жюли дугхийв. Гай зовлонд нам цохиулсан эх нь эрихээ гүйлгэн энэ цастай өдрийн нам гүм алхах чимээ, дугуйн түжигнээн дуулдахаа байж, тэнгэр хүртэл дүлий дүмбэд оргисон нам гүмд сэм ирсэн золгүй явдлыг зөнгөөрөө мэдрэн уйлж байлаа.

Сэтгэл түгшсээр байгаад, соргог болчихсон сонор чихэнд нь хүүгийн нь шатаар өгсөж явах нь гэнэт ялгаран сонсогдлоо.

— Эварист! Нуугд гэж шивгэнээд охиноо унтлагынхаа өрөө рүү түлхэн оруулав.

— Ээжээ өнөөдөр бие чинь ямар байна?

Эварист малгайгаа өлгүүрт өлгөөд хөх фракаа тайлан ажлынхаа цамцаа өмсөж самбарын өмнө суув. Эх орныхоо төлөө амиа өгсөн цэргийн толгойд цэцгийн хэлхээ углаж буй, Ялалтын зургийг хэдэн өдөр нүүрсээр ноороглож байгаа билээ. Энэ ажлаа урамтай нь аргагүй бариад суучих байсан боловч онц шүүх түүний хамаг цагийг нь идэж, бүтнээр нь залгиж байлаа. Зурахаас төсөөрчихсөн гар нь удаан, залхуутай хөдөлнө. Тэрээр «Са га»-г аялж эхлэв.

— Хүү минь, юм идэхгүй юу? Баясгалантай байх чинь гэж Гамлен авгай өгүүлэхэд

— Сайн мэдээ авсан болохоор баярлалгүй яах юм бэ ээж ээ, Вандейг дарж, австричуудыг хиар буулган, Рейны арми Лаутерн, Висембург дахь дайсны бэхлэлтийн шугамыг сэт цохилоо. Ялсан бүгд найрамдах улс энэрэнгүй үзлээ ил гаргах цаг хаяанд туллаа. Гэтэл бүгд найрамдах улсын хүч батжих тутам яагаад хуйвалдагсад гаарч, эх орон, ил дайрч буй дайснаа дарах тусам яагаад урвагчдын дунд хорон санаа хурцдаад байгаа юм болоо? гэв.

Гамлен авгай оймсоо нэхсээр хүүгээ саравчныхаа дээгүүр ажна.

— Чамаар өөрийгөө зуруулж байсан Берцелиус арван ливрийн авлага авахаар ирсэн. Би түүнд мөнгийг нь өглөө. Мужааны өгсөн чанамал жимсийг хэтэрхий идчихээд жаал Жозефины гэдэс нь учиргүй өвдсөн. Би түүнд усан эм бэлдэж өглөө... Деман ороод гарсан. Тэр чамтай дайралдаагүйдээ харамсан, чиний нэг зургийг барлахаар

дуртай авах сан гэж ярьж байна билээ. Тэр чамайг тун авьяастай гэж байсан шүү. Тэр хүү чиний нооргийг үзээд л гайхаж байна билээ.

— Цаг төр төвшрөн, бүх хуйвалдагсдыг устгахтай зэрэг би Орестоо ахин зурж эхэлнэ. Би сагсуурах дургүй, гэвч энэ толгой Давидад тэнцэнэ.

Тэрээр том гэгчийн шугамаар Ялалтынхаа гарыг тэмдэглэв.

— Энэ дал модны мөчир барьж байгаа юм. Хэрвээ гар нь өөрөө дал модны мөчир байсан бол дээр байх сан гэж залуу хэлэв.

— Эварист!

— Юу гээ вэ, ээж ээ?

— Би сураг дууллаа... хэнээс гэдгийг таа л даа...

— Бүү мэд.

— Жюлигээс... дүүгээс чинь... маш муу амьдарч байна гэнээ.

— Сайн байсан бол уур хүрэх сэн.

— Хүү минь тэгж битгий ярь. Тэр чинь чиний дүү шүү дээ. Жюли муу хүн биш. Сайхан сэтгэлтэй байж чадна. Үзсэн зовлон нь нүдийг нь бүр нээжээ. Тэр чамд хайртай. Эварист тэр үнэн цагаан хөдөлмөрөөр амьдрахыг хүсэн чамтай ахиад яаж ойртдог билээ гэж бодож байгааг хэлж чадах байна. Яагаад уулзаж болдоггүй бил ээ? Тэр Фортюне Шассентэй суусан байна.

— Танд захиа бичээ юу?

— Үгүй ээ.

— Түүнээс яаж мэдээ аваа вэ?

— Хүү минь үүнийг би захианаас мэдээгүй, би... Гамлен босон, эхийгээ айлгам дуугаар үгийг нь таслав.

— Ээж ээ, дуугүй бол! Тэр хоёрыг францад буцаж ирсэн гэдгийг надад бүү ярь... Тэд нэгэнт үхэх ёстой бол миний оролцоогүй зүйл дуусаг. Тэдний төлөө, миний төлөө, өөрийнхөө төлөө тэднүүсийн Парист байгааг надад бүү дуулга. Миний харахыг хүсэхгүй байгаа зүйлийг харуулах гэж битгий оролд, эсвэл...

— Хүү минь чи үүгээр юу хэлэх гээв? Чи чадна, чи зүрхэлнэ шүү дээ?

— Ээж ээ, үгийг минь сонсооч, хэрвээ би, миний хүү Жюлийг энд байна (тэрээр хуруугаараа цоожтой хаалга заав) гэж мэдэх юм бол энэ тухай мэдэгдэхээр секцийн ажиллах хороо руу даруйхан очих сон билээ.

Царай нь оройвч шигээ цайсан хөөрхий эх салгалсан гараасаа
нэхэж байгаа юмаа алдан дуулдахын төдий

— Би итгэж чадахгүй байсан юм, гэтэл одоо үүнийг өөрөө үзлээ,
мангас... болж... гэж шивнэв.

Түүнээс ч дутуугүй зэвхийрсэн Эварист амнаасаа хөөс сахруулан
тасалгаанаас ухасхийн гарч Элодийн элгэнд бүхнийг огоорон бүгдийг
ор тас умартан нойрсохоор гүйн одов.

XIX

Эцэг Лонгмар Атенайс бүсгүй хоёрыг секцэд байцааж байх хооронд Броттог хоёр цагдаагаар харгалзуулан Люксембург рүү хүргүүлсэн авч хаалгач нь сул байргүй гээд тэднийг авахаас татгалзав. Өвгөн Броттог Консьержерт хүргэн шилэн хаалгатай ташаалавчаар хоёр хуваасан албаны жижиг тасалгаанд орууллаа. Бичиг хэрэгч, түүний нэрийг баригдагсдын бүртгэлд бүртгэн байх зуур Бротто шилний цаана гудасны тамтаг дээр хоёр хүн хэвтэж байхыг харж амжсан агаад тэд үхсэн мэт хөдөлгөөнгүй гөлрөн ширтэх нь юу ч үзэхгүй байгаа болов уу гэмээр бодогдоно. Дэргэд нь шалан дээр таваг, лонх, талх, махны үлдэгдэл хөглөрнө. Эд бол алагдах ял заагдаад тэрэг ирэхийг хүлээн байгаа улс ажээ.



Тайж байсан дез - Илеттийг газар доорх нүхэнд оруулахад тэрээр тэнд шалан дээр гулдайсан хоёр хүн байхыг дэнгийн гэрэлд олж харсны нэг хоригдол нь муухай сорвитой зэмдэг догшин царайтай, нөгөө нь нүдэнд дулаан найрсаг царайтай ажээ.

Хоёр хоригдол ялгадсанд бохирдсон нүцгэн газар түүнийг хэвтүүлэхгүйн тул үл мэдэг ялзарсан, өт хорхой язганасан сүрлийг түүнд өгч билээ.

Зүг бүхнээс өмхий самхай ханхлах харанхуйд Бротто бандан сандайлан толгойгоо туурганд наан хөдөлсөн ч үгүй, юм дуугарсан ч үгүй суучхав. Хэрвээ хүч хүрдэг сэн бол толгойгоо хананд бяц

дэлсчихмээр зовуурьтай байлаа. Амьсгал нь бүтнэ. Нүд нь бүрэлзэн чих нь удтал шуугин бие нь алдран нойр нь хүрч байгааг мэдрэв. Юутай ч жишишгүй нэгэн агшинд орчны юмс яруу сайхан тов тод болж анхилам тамсаг үнэр үнэртэх мэт болоод тэр мэдээ алджээ.

Ахин ухаан ороход нь хамгийн түрүүн сэтгэлд сэрхийсэн зүйл бол ухаан орох нь ээ гэдэг гаслантай бодол байлаа. Цөхрөнгөө бүр барсан агшинд ч гүн ухаанч хэвээр үлдэж тэрээр яс цоожинд орон, байгаа бүхий л сэтгэлээрээ бахаа хангаж алуулахаа хүлээх хэрэгтэй байж гэж бодов. Тэрээр ахин ухаан тавих гэж оролдсон боловч энэ нь бүтсэнгүйгээр үл барам харин бохир агаар бага багаар уушгинд нь орон биеийн нь илч буураагүй нь мэдэгдэхтэй хамт энэ чинь тэсвэрлэхийн аргагүй үнэн шүү гэж ой тойнд нь орж байлаа.

Энэ завсар хоёр хөрш нь түүний дуугүй байгааг өөрсдийгөө машид доромжилсон явдал гэж үзжээ. Хүнтэй нийлэмжтэй Бротто тэдний сонирхсонд хариулах гэж оролдсон авч тэр бол улс төрийн хэрэгтэн гэгддэг хүмүүсийн нэг, өөрөөр хэлбэл үг буюу оюун ухаанаараа гэмт хэрэг өдүүлдэг хүн гэдгийг мэдмэгцээ дорхноо тэдний сонирхол нь буурчээ. Тэр хоёулаа сүрхий хүнд хэрэгтэй, ахмад нь хүн амины, нөгөө нь мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдсэн хэрэгтэй юм санжээ. Тэд тэр байдалдаа дасаж түүгээр ч үл барам зарим талаар сэтгэл хангамжтай байдаг болсон байна. Толгой дээр нь наран гийсэн шуугиант гудамж бий. Пале - Роялийн аятайхан худалдагч бүсгүйчүүд, үнэртэн, жижиг бараатай лангууныхаа араас чөлөөт аз заяатай зорчигчдыг харан мишээж байгаа шүү гэдэг бодол сэтгэлд нь ургахад, улам ч арга нь барагдана.

Харанхуйлан дүнсийж шоронгоос үл мэдэгдэх авч ер тэртэй тэргүй зовлон гай түйтгэр тарьсан шөнө боллоо. Бротто нэг хөлөө бандан дээр жийж тавиад нуруугаараа хана налан унтав. Мөчрийг нь дамжин шувууд жиргэсэн өтгөн навчит эвэрлэг модон доор сууж байхад нь жаргаж буй наран голын мандлыг дөл мэт ягааруулан, үүлсийн захыг гал улаан болгож байна гэж тэр зүүдэлжээ. Шөнө өнгөрлөө. Тэрээр халууран шаналж усыг шууд домбоноос нь залгилан өвчнөө улам даамжруулна.

Маргааш өглөө нь усан шөл авчирч өгсөн шоронгийн хуяг, тогтоосон шан өгвөл хоригдлуудын өөрийнхөө мөнгөөр суудаг өөр нэг байранд шилжүүлж өгье хэмээгээд зай гармагц оруульа гэж амлан нэг их удаан хүлээх явдал гарахгүй биз гэв. Үнэхээр ч дараа өдөр нь тэрээр

Броттог хорих өрөөнөөс гарахыг тушаав. Дээш өгсөх тутам гишгүүр нэг нэгээр ахих тусам тэнхээ тамир нь сэргэж буйг Бротто мэдрэн, өөрийг нь аваачсан туйпуун шалтай тасалгаанаа муухан ноосон хөнжлөөр бүтээсэн эвхмэл ор байхыг үзээд баярласандаа уйлчхаж билээ. Нэгэн үе дуурийн үзэсгэлэн төгөлдөр бүжигч бүсгүйчүүдэд зориулан захиалж хийлгэж байсан үнсэлдэж буй тагтаануудтай ор түүнийг тэгтлээ баярлуулж, энэ шиг цэнгэлийн дээдийг амлаж байгаагүй билээ.

Өндөр хашлагаар бие биеэс тусгаарласан арван долоон ор тавьсан, сүрхий цэвэрхэн том танхимд ор нь байлаа. Ихэвчлэн тайж байсан хүмүүс, худалдаачид банкны эзэд нар, гар урчуул зэрэг шинэ хөрш нар нь ямар ч хүнтэй таарч тохирдог өвгөний сэтгэлд нийцжээ. Түүн шиг алив цэнгэлээс хагацсан, зандалчны гарт амь алдах үйлтэй энэ завшаангүй хүмүүс, их л наргианч, тоглоом шоглоомд маш дуртайг Бротто ажиг. Хүмүүсийг магтан бахархахыг төдий л таашаадаггүй өвгөн, нөхдийнхөө хөгжөөнт аалийг хувь зохиолоо сайтар тунгаан бодоход нь тотгор болж байгаа хоомой явдал гэж тайлбарлана. Арай ухаалгууд нь гүн уйтгарт дарагдсаныг үзээд эл санал нь батажсан болно. Түүний хөрш нарын олонх нь архи дарсаар сэтгэлээ сэргээж, ам халахлаараа аймшиггүй догшин авирладгийг төдхөн мэджээ. Цөмөөрөө хатан зоригтой улс биш авч бултаараа тийм байх гэж оролдоно. Харчуул харгисаа ууртайгаа, үүгээр ч үл барам сувдаг харамчаа хүлээн зөвшөөрөх боловч хулчгар гэгдэхийг хэзээ ч хүсдэггүйн учир нь хэрвээ тийм ам алдвал зөвхөн зэрлэгүүдийн дунд ч биш боловсон нийгэмд ч үхлийн аюулд хүргэнэ гэдгийг мэддэг болохоор Бротто үүнийг огтхон ч гайхсангүй болно. Чухам ийм учраас л бүх ард түмэн баатарлаг байдаг, бүх арми гагцхүү зүрхтнээс бүрэлддэг гэж тэр боддог билээ. Бууны төмөр хан ян хийх түлхүүр хангир жингэр гэх, цоож хяхран чахрах, харуулуудын хашхиралдах, Онц шүүхийн үүдэнд хөлийн чимээ гарах нь ялтангуудын заримыг нь уйтгар гунигт дарагдуулж заримыг нь дэмийрэн улангасахад хүргэн архи дарснаас ч хүчтэйгээр нөлөөлдөг билээ. Нэг хэсэг нь хоолойгоо сахлын хутгаар огтлон үгүй бол цонхоор үсрэн хэмхэрч үхэж байлаа.

Шинэ байранд орсны дөрөв дэх өдөр Бротто, эцэг Лонгмарыг хулгайч алуурчдын дунд хорхой шавж язганасан ялзарсан сүрэл дээр зовж байна гэж шоронгийн манаачаас дуулав. Тэгэхлээр нь тэрээр

өөрийн суудаг өрөөнд саяхан суларсан орон дээр Лонгмарыг авчирч оруулаач гэж шалгаав.

Гэлэнг тэжээх зардалд мөнгө төлөх үүрэг хүлээсэн өвгөн мөнгөөр яг суусан тул хүний хөрөг зуран нэг ширхгийг нь экюгээр зарж эхлэв. Хуягаар дамжуулан жижиг хар жаазнууд олоод тэрээр жижигхэн чамин эдлэл хялгасаар нэлээд сүрхий урлан түүндээ суулгадаг байв. Ойр дотно хүндээ өөрийн тухай ямар нэгэн дурсгал үлдээх гэсэн хүмүүсийн дунд энэхүү зүйл их амжилт олж байлаа.

Эцэг Лонгмар эрэлхэг хатуужилтай биеэ авч байв. Хувьсгалт онц шүүхэд очих цагаа хүлээн байхдаа биеэ өмгөөлөхөөр зэхнэ. Өөрийн амин хувийн хэргээ сүмийнхээс салгалгүй тэрээр шашинтныг хар болгосны балгаар христос бэрийг хэлмэгдүүлсэн тэр горимгүй дур зоригоороо аашилж буй явдлыг шүүгчдэд ухуулна гэж ам өгчээ. Ромын пап ламыг сүмийн ууган охин доромжлон дайрч байгаа, мөн Францын хуврагууд хар улсын хараанд шившигтэйгээр орон басамжлуулж байгаа хийгээд христагийн жинхэнэ сүр хүчин муудаж, гэлэнгүүд тонуулан газрын нэг тарсан тухай бичье гэж санаж байв. Их Григорий, Иринея гэгээнийг дурдан жаягийн эрхийн хуулиас ихээхэн иш татаж, хууль зүйн зүйл ангийг бүтнээр авч байлаа.

Өдөржингөө орныхоо хөлд суун өдөн үзгийн хугархайг бэх, хөө, кофены нитгэлд дүрэн, лааны цаас, боодлын цаас, гарчгийн хуудас, хуучин захидал, хуучин данс, хөзрийг өвдөг дээрээ тавин дүүртэл бичдэгээр барахгүй урьдаар цардаж байгаад цамцаа хүртэл үүнд ашиглахаар бодож байлаа. Хуудас хуудсаар бичиж хэнд ч гаргагдахааргүй эрээчсэн зүйлээ үзүүлэн

— Шүүгч нарын урд очоод үнэний гэрлээр тэднийг сохолно гэж ярина.

Нэгэн удаа зүгээргүй ихсэж буй өмгөөлөх үгээ бах нь ханасан байртай хараад шүүгчийн нүүрийг улайлгачихсан гэхээс тэсэж ядан бодлого болсон Лонгмар

— Би л бол тэдний оронд байхыг хүсэхгүй сэн гэж дуун алджээ.

Хувь заяа нь энэ өрөөнд хөтөлж оруулсан хоригдлуудын зарим нь рояльч, зарим нь федеральч бөгөөд мөн тэдний дотор нэгийн зэрэг ч якобинч байлаа. Улсыг удирдах системийн талаар өөр өөр саналтай боловч тэдний хэнд ч Христосын шүтлэгийн ул мөр байсангүй. Фельянууд, үндсэн хуульт хаант засгийн бодлоготнууд жирондистууд нь Броттогийн нэгэн адил бурхан тэдэнд ямар ч ашиггүй, харин ард

түмэнд чухал хэрэгцээтэй гэж үзнэ. Якобинчууд нь якобинчлогыг цаглашгүй өндөрт мандуулахын тулд Иеговын оронд якобины бурхныг тавьсан боловч, хэн нь ч алив нэг шашны шинэ нээлтэд итгэх гэнэн хүмүүс бий гэж санахгүй байгаа шигээ тэд эцэг Лонгмарыг тэнэг хүн ердөө л бишийг үзээд төдий чинээ зальтайд тооцож байлаа. Гэлэн бол үнэнч голч хүн гэж Бротто дэмий л батлах авч цаадуул нь Броттог хэлж байгаадаа бүрэн итгэдэггүй хүн гэж үзнэ. Түүний үзэл санаа нь үнэн гэж бодогдохооргүй хэт өвөрмөц бөгөөд хэний ч сэтгэлд төдийлөн үл таалагдана. Жан - Жакийг тэр булай луйварч гэнэ. Гэтэл тэрээр Вольтерийг, сэтгэлдээ дотно Гельвеций Дидро мөн барон Гольбахтай эн зэрэгцүүлэхгүй хэдий авч бишрэх ажээ. Түүний саналаар сүүлчийн зууны сод ухаант хүн бол Буланже байв. Мөн тэр, одон оронч Лаланд болон «Оддын гарал үүслийн тухай эрдэм шинжилгээний өгүүлэл» бичсэн Дюпюиг ихэд хүндэлнэ. Алиа төлөөлөгчид хөөрхий варнавчийг элдвээр элэглэх боловч тэр юу ч үл анзаарах бөгөөд түүний сайхан сэтгэл бүх доромжлолыг няцаах бүлгээ.

Амар заяа үл үзүүлэгч бодлоо мартагнах, мөн хийх юмгүй уйдаахгүйг хичээн ялтнууд даам, хөзөр мэтийг тоглоцгооно. Хөгжим биедээ авч байх хориотой. Оройн хоолны дараа цугаараа дуулах юм уу шүлэг уншина. Вольтерийн «Орлеаны ариун бүсгүй» нь эдгээр золгүй хүмүүсийн сэтгэлийг жаал зугаа баясаж, хамгийн аятайхан хэсгээс нь дуртайяа ахин дахин чагнадаг байлаа. Гэвч зүрхэнд нь хурж, тамлан зовоох бодлоосоо бүрмөсөн ангижирч чадахгүй учир үүнийгээ баясал цэнгэлээр солихыг хичээн тэд заримдаа арван найман ортой хорих өрөөндөө унтахынхаа өмнө Хувьсгалт онц шүүх болон тоглоно. Ролийг хүн бүрийн дур хүсэл авьяас билигт тохируулан хуваана. Нэг хэсэг нь шүүгч, яллагч, нөгөөдүүл нь хэрэгтэн, гэрч, бусад нь зандалчин түүний туслагчид болно. Яллагдагсдыг орон дээр нь хэвтүүлэн хүзүүн дээрээс нь банз буулган алж байгаагаар бүх явц үргэлж дуусдаг байлаа. Дараа нь үйл явдал тамын оронд шилжинэ. Арай чадвартай жүжигчид цагаан даавуугаар биеэ ороон сүнс болон тоглоно. Бордо хотоос ирсэн жижигхэн хялар нүдэт бөгтөр нуруут, майга хөлт тас хар царайт Дюбоск овогт залуу доголон чөтгөр болон толгойдоо эвэр хийж эцэг Лонгмар луу очиж хөлөөс нь чангааж орон дээрээс нь буулган, энэ нь орчлонг заяагчийг, атаа жөтөөч, тэнэг мангуу, ууртай хортой амьтан, баяр цэнгэл, хайр дурлалын дайсан болгосон учир нэг насны тамд унасан юм гэж өгүүлдэг байлаа.

— А-а-а гэж чөтгөр чангаар орилон муу өвгөн хуушаан чи, хамгийн шилдэг өргөлөө авалгүй тэвчиж, мацаг барьж мөргөл үйлдэн лагшингаа тарчилган байх нь бурханд таалагддаг гэж сургадаг. Мэхт хоёр нүүрт сувдаг амьтан чи шор дээр сууж, насаа элтэл өндөгний хальс идэж явагтун! гэнэ.

Чөтгөрийн багийн цанаа гүн ухаанч хүн байна гэдэг нь наад үгээс чинь мэдэгдэж байна. Тамын сүнсний хамгийн өчүүхэн нь ч гэсэн бурхны номыг зах зухаас нь үзсэн болохоор нэвтэрхий тольчоос бүдүүлэг биш, иймээс тийм тэнэг юм ярихгүй гэдэг үгсээс өөр илүү юм эцэг Лонгмар үл дуугарна. Харин жирондист үзэлтэй өмгөөлөгч түүнийг Капуцин гэхтэй хамт тэрээр бухимдан, варнавчийг францисканцаас ялгахгүй хүн юмны хар цагааныг ажиглахгүй гэнэ.

Хороонууд шоронг зогсолтгүй дүүргээд хувьсгалт онц шүүх яаран сулласаар байсан агаад гурван сарын дотор арван наймтын өрөөнийхний тэн хагас нь шинэ улс болжээ. Эцэг Лонгмар чөтгөрөөсөө хагацав. Өмгөөлөгч Дюбоск, Хувьсгалт онц шүүхэд шилжээд, бүгд найрамдах улсын нэгдэл нягтралыг бутраах хуйвалдаанд оролцсон федералист хүн гэгдэж алуулах ял заагджээ. Онц шүүхээс гараад бусад яллагдагсдын адил тэрээр шоронгийн нэг үзүүрээс нөгөө рүү гурван сарын турш хөгжөөн баясгаж байсан хорих өрөөний нь хаалга хүрдэг үргэлжилсэн урт хонгилоор өнгөрөв.

— Ноёнтон минь, хөлөөс чинь татан орон дээрээс буулгаж байсныг уучлаарай,

— Ахиад тэгэхгүй гэж тэрээр эцэг Лонгмарт өгүүлээд Бротто руу эргэн,

— Баяртай, танаас урьтаад хумхын тоос болох нь ээ, намайг бүрэлдүүлж байгаа махбодыг байгальд нь дуртайяа буцааж өгье. Үнэнийг хэлэхэд би түүнд ер тохироогүй болохоор хэтэд байгаль надаас илүү ашиглаасай гэж хүснэ гэв.

Түүнийг бичиг хэргийн өрөө рүү буухад Броттогийн зүрх шантарч. эцэг Лонгмар дагжин цас шиг цайн энэ хүний ийнхүү хутганы ирэн дээр ч инээж байхыг үзээд үхтлээ айжээ.

Хаврын тэргүүн сар гарахад цэлмэг өдрүүд ирлээ. Бротто уулын хуял хүн болохоор эмэгтэйчүүдийн корпусын цонх харсан хашаа руу өдөрт хэдэнтээ гарч хоригдол хүүхнүүдийн өглөө цагаан хэрэглэлээ угаадаг усан сан руу очно. Хашааг дундуур нь тороор хуваасан боловч завсраар нь гар гараа атган үнсэлдэн таалалдаж болохоор ажээ. Авралт

шөнийн харанхуйд хос хосоороо торонд наалдацгаана. Тэгэхэд нь Бротто чимээгүйхэн холдож шатны гишгүүр дээр очиж суугаад хүрэн сюртукнийхээ хармаанаас Лукрецийн ботийг гаргана. Sic ubi... Бидний амьдрал дуусахад юу ч, атугай өөрсдөөсөө үлдсэнийг цөмийг нь нэгтгэн хольсон тэнгэр, газар далай ч бидний сэтгэлийг хөдөлгөж чадахаа болино» гэсэн хатуу бөгөөд тайвшруулсан мэргэн үгийг дэнлүүний гэрэлд уншина. Энэ аугаа их цэцэн үгсийг шунан уншигч Бротто варнавчаас орчлонг халхлаад байгаа элий балай ухаанд нь атаархана.

Алан хядлага сар өнгөрөх тутам ширүүсэж байлаа. Шөнө тоолон согтуурах харгалзагчид хоточ нохдоо дагуулсаар хорих өрөөнүүдээр хэсэн ялын төлөвлөгөө тарааж, овог нэрийг муруй хазгай дуудан сөөнгөтөн хашхичиж аминд нь хүрэхээр төлөвлөсөн хорин хүний төлөө, хоёр зуун хүнийг сүнсгүй айлган хоригдлуудыг сэрээнэ. Сугалаагаар эднийг шилж аваагүй байгаа даа? гэсэн асуулт өөрийн эрхгүй төрмөөр нийгмийн байдал, зан чанараараа тэс ондоо эр эм өвгөн, залуус ялтнууд өчүүхэн ч хэл ам гаргалгүй хорь гучаараа цусан сүүдэр татсан хонгилоор өнгөрөх бүлгээ.

Ялтнууд хэзрөө тоглон, бургунд дарс ууж янз бүрийн төлөвлөгөө зохиож шөнөөр болзоондоо очсоор л байна. Бараг бүхэлдээ шинэчлэгдсэн шоронгийн хүн амаа одоо голдуу «мухар сүсэгтэй» «галзуу» хоёроос бүрэлдэж байлаа. Хэдий тийм боловч арван наймтын өрөө урьдын адил сайхан харьцаатай эелдэг хүмүүсийн байрлах газар болсоор урьдын төрхөө хадгалсаар байлаа. «Хонь» өөрөөр хэлбэл тагнуул байж мэднэ гэж сэжиглэгдэж байгаа саяхан Люксембургээс Консьержерт шилжиж ирсэн хоёр хоригдол иргэн Наветта, Болье нараас бусад нь цөм шударга бие биеийгээ итгэдэг хүмүүс байлаа. Энэ тасалгаанд Бүгд Найрамдах Улсын цэрэг дайны амжилтыг хундага өргөн тэмдэглэнэ. Ажилгүй хүмүүсийн дунд үргэлж дайралддаг хэдэн яруу найрагчид тэнд байв. Арай чадварлагууд нь Рейны ялгуусан армийн дурсгалд зориулан магтаал бичиж түүнийгээ их л хөгжөөнтэй баясгалантай уншихад бусад нь нижигнэтэл алга ташна. Ганц Бротто л ялагч ба түүнийг магтан дуулагчдыг төдийлөн үл сайшаана.

— Бүр Гомерын үеэс хойш яруу найрагчдын дунд дайчдыг магтах дон байсаар байгаа юм. Дайн бол урлаг биш гагцхүү тохиол л тулалдааны хувь заяаг шийддэг юм. Бие биеийн эсрэг үзэлцэх хоёр ав адилхан тэнэг жанждын нэг нь ялагч болох нь дамжиггүй билээ. Та

нарын шүтээд байгаа энэ цэрэг шуу юмны чинь нэг толгойг тань эрт орой нэгэн цагт, тогоруу мэлхийг залгидаг гэж ёгт үлгэрт байдагчлан, залгина даа, түүнд бэлдэцгээ. Тэгэх цагт тэр чинь нээрээ бурхан болно. Бурхны чанар нь тэдний идэх дур хэр зэрэг байгаагаар танигддаг юм чинь гэж тэрээр нэг удаа өгүүлж билээ.

Зэр зэвсгийн алдар Броттогийн сэтгэлийг огт хөндөж байсангүй. Тэрээр бүүр урьдаас мэдэж байсан болохоор Бүгд Найрамдах Улсын ялалтад өчүүхэн ч үл баярлана. Шинэ ялалт байгуулах болгонд бэхжиж байдаг улс төрийн байгууллагыг тэр эс таашаана. Үүнд дургүйцэх үндэс түүнд хангалттайгаас хангалттай байлаа.

Нэгэн өглөө хамгаалах хорооны комиссарууд нэгжлэг хийж мөнгө, алт мөнгөн эдлэл, хутга, хайч хураан авна. Тийм нэгжилтийг Люксембургт хийсэн, тэнд захиа, цаас номыг хүртэл авсан гэж ялтангуудад мэдэгдлээ. Хүн бүр хамгийн үнэтэй зүйлээ нуучихаар далд газар олохыг хичээнэ. Эцэг Лонгмар өмгөөлөх үгээ тэврэн усны хоолой руу очиж ам руу нь чихэв. Бротто Лукрецийгээ зуухан дотор үнсэнд буллаа.

Хүзүүндээ гурван өнгийн тууз зангидсан комиссарууд нэгжихээр орж ирээд өөрсдөд нь хувь болгон үлдээх нь зүйтэй гэж үзсэн зүйлийг л хоригдлуудаас олжээ. Тэднийг явангуут эцэг Лонгмар усанд норж салхинд сэмэрсэн өмгөөлөх үгнийхээ үлдэгдлийг олж бас Бротто зуухнаас хар хөө болчихсон Лукрецийгээ гаргав.

«Зарим нэгэн шинж байдлаас үзэхэд бидний мэдэлд тун ялихгүй хугацаа үлдсэн тул энэ байгаа цагт цэнгээд авъя» гэж Бротто шийдэв.

Шоронгийн хашааны дээрх цэнхэр тэнгэрт хавирган сар мөнгөрөн гялалзсан прериалийн дулаан шөнө өвгөн ердийнхөөрөө Лукрецийгээ уншин чулуун шатны гишгүүр дээр сууж байтал нь гэнэт эмэгтэй хүний огт танихгүй байрын сайхан дуу гарч түүнийг дуудах нь сонстов. Бротто, хашаа руу орон торны цаана зогсоо эмэгтэйн барааг харахад сүүмийн харагдах гоолиг галбир нь түүний дурлаж явсан бүх эмэгтэйчүүдийг санагдуулах учир дууг нь таниагүй шигээ биеийг нь бас таньсангүй. Саран түүнийг мөнгөлөг цэнхэр гэрлээрээ гийгүүлэх ажээ. Гэнэт Бротто, Фейдогийн гудамжны нүдэнд дулаахан жүжигчин хүүхэн Роза Тевененыг танилаа.

— Хүү минь, та юу? Тантай энд учирна гэдэг яасан гаслантай баяр вэ? Энд удав уу, яагаад та энд байдаг бил ээ?

— Өчигдрөөс хойш гээд эмэгтэй шивнэн

— Намайг роялист гэж ховложээ. Хатан хааныг суллах зорилготой хуйвалдаанд оролцсон гэж надад ял тулгаж байна. Энд байгааг чинь мэдэх болохоор таныг эрж олох гэж шууд мэрийсэн юм. Миний хэлэхийг сонсож бай. Найз минь... ингэж дуудахад та лав дургүйцэхгүй биз дээ. Эндэхийн нөлөөтэй хүмүүсийн дотор миний танил бий. Хаа ч нийгмийг аюулаас хамгаалах хороонд хүртэл ая талтай байгаагаа би мэдэж байна. Нөхдөөрөө хөөцөлдүүлж эндээс гараад ээлждээ би таныг суллана гэлээ.

Гэтэл Бротто түүнийг хичээнгүйлэн гуйсан дуугаар хориглож эхлэв.

— Хүүхээ, өөртөө үнэтэй цэнтэй юм бүхнийхээ төлөө та юуг ч бүү хийгтүн! Хэнд ч бүү бичээрэй, хэнийг ч бүү царайчлаарай! Хэнээс ч юу ч бүү гуй, танаас би гуйж байна. Таныг тэд ор тас мартаг.

Цаадах нь түүний үгийг чухалчилсангүй бололтой байхад нь Бротто улам хүчлэн гуйж гарлаа.

— Роза, таг чимээгүй болчих, таныг мартаг, үүнд л аврал байна. Таны нөхдийн хийх гэж оролдох зүйл үхлийг тань зөвхөн түргэсгэх болно. Цаг хожихыг чармай. Одоо нэг их хүлээлгэхгүй, ер нь тун удахгүй байх гэж найдаж байна. Шүүгч, төлөөлөгчид, ямар нэг Гамлены сэтгэлийг наашлуулах гэдэг бодлогоо таягдан хая, энэ нь гол нь. Эднүүс бол хүмүүс биш амьгүй юмс, тэгэхлээр нь амьгүй юмтай үг хэлэлцэх нь ямар ч ашиггүй. Таныг тэд мартаг, хэрвээ та миний үгийг дагавал хонгор минь, би амийг тань аварсандаа баярласаар үхэх болно.

— Таны үгэнд оръё. Үхлийн тухай дэмбэрэлгүй юм битгий яриач дээ гэж хүүхэн хариулахад Бротто мөрөө хавчисхийлгэснээ,

— Амьдрал минь дуусжээ. Та л аз жаргалтай амьдарч яваарай гэлээ.

Хүүхэн түүний гарыг аван цээжиндээ наав.

Хонгор минь, сонс! Би дөнгөж ганц өдөр л таныг харсан, гэхдээ та надад хамаагүй бишээ. Миний хэлэх зүйл жаахан ч гэсэн амьдралд чинь дуртай болгож магадгүй. Таны хүссэн болгоныг... зөвшөөрнө гэдгийг мэдэж яваарай гэв.

Тэгээд хоёул торонд наалдан үнсэлдэв.

XX

Онц шүүхийн нэгэн унжирсан хуралдааны үед Эварист бүгчим агаарт шүүгчийн суудалд суун нүдээ аньж ийн сэтгэрүүн:

«Маратыг харанхуй буланд нуугдахад хүргэсэн золигууд түүнийг шөнийн шувуу, харанхуйд ч хуйвалдагсдыг билгийн нүдээр олж хардаг Минервийн шувуу болгон хувиргажээ. Одоо цэнхэр нүдний нь гөлөрсөн хүйтэн харц Бүгд Найрамдах Улсын дайснуудыг нэвт шувт харж Кордельерын цэцэрлэгт мөнх нойрссон Ардын нөхрөөс ч гярхайгаар урвагчдыг илчилж байна. Түрүүнийхээс зүтгэлтэй илүү хэтийг харагч шинэ авралт хүн хэний ч ажаагүй юмыг олж үзэх бөгөөд түүний гозойлгосон ганц хуруу эргэн тойронд айдас төрүүлнэ. Мууг сайнаас, гэмийг буянаас зааглах шалихгүй үл анзаарагдам ялгааг ч харах бөгөөд тэр байгаагүй сэн бол тэднийг хольж хутган эх орон, эрх чөлөөнд хор учруулах сан биз. Тэрээр нарийхан шулуун зам гаргаж байгаа агаад түүнээс зүүншээ, барууншаа гажвал л төөрөгдөл, гэмт хэрэг, хорлолд орох. Хэтрүүлэгчид буюу дэндүү доройгоо үзүүлэгчид, оюун санааг тахин шүтэхийг мөрдөж хавчигсад, шашны төлөөнөө хувьсгалын хуулийг эсэргүүцэгчид нь гадаадын дайсанд хэрхэн үйлчилж байгааг үл хахуульдагдагч тайлбарлана. Ле - Пельтье, Маратыг алсан өөдгүй амьтдаас доргүйгээр гэгээн дурсгалд нь хир буртаг суулгах зорилгоор тэднийг бурхан мэт өргөмжлөгчид гадаадын дайсанд үйлчилж байна. Дэглэм журам цаг үеэ олсон арга хэмжээний оновчтой гэдэг үзэл санааг заавал мөрдөхийг үл зөвшөөрөн хүлээсэн хэн боловч харийн тагнуул мөн, зан заншлыг басамжлан дайрч сайн үйлийг доромжилж хэт зоригоороо бурхныг үгүйсгэгч хэн боловч харийн тагнуул мөн. Мухар сүсэгт лам нар ч үхэх ёстой. Гэхдээ мухар сүсэгтэй тэмцэх хувьсгалын эсэргүү арга бас бий. Зарим тохиолдолд няцаж буцах нь гэмтэй байдаг. Дундыг баригч ч улсыг хөнөөж байхад хийрхэгсэд бас мөхөөж байна.



Аяа, хамгийн мэргэн хүний лүндэн буулгасан шүүгч нарын аймшигт үүргээ гэж! Язгууртан федералист, орлеанист бузрууд мэтийн эх орны илэрхий дайсныг зөвхөн дарах ёстой бишээ. Бүхий л янзаар зүсээ хувиргагч Протей бол харийн тагнуул хуйвалдагч мөн. Тэрээр эх оронч хувьсгалч хүн вангийн дайсан мэт баашлан эрх чөлөөний төлөө ч биеэ зориулж байгаа мэт итгүүлнэ. Дуугаа өндөрсгөж Бүгд Найрамдах Улсын дайсныг дагжуулагч хүн бол Дантон бөгөөд хэтэрхий хувьсгалч үг нь түүний шившигт санааг бараг хаацайлж чадахгүй, эцсийн эцэст биеэ худалдсан нь бусдад илэрхий болж байна. Хувьсгалын тэмдгийг хамгийн түрүү малгадаа хадсан тэр уран үгт ээрүү үлгэр жишээч иргэний маягаар «дэнлүүний прокурор» гэж өөрийгөө егөөдөн нэрлэсэн тэр шог найруулал бичигч Камиль, Демулен бол хуйвалдагч, харийн тагнуул хүн, тэрээр урвагч генералуудыг өмгөөлөн тэднийг гэсгээн цээрлүүлэх болоход огт үл зохицох энэрэл үзүүл гэж шаардаад мөсөө таниулсан юм. Филиппо ч тэр, Геро ч тэр жигшүүрт Лакруа ч тэр адилхан мөн жигшим хуурамч үгээрээ эрх чөлөөг басамжлагч эцэг Дюмен бузар гүтгэлгээрээ Антуанеттыг хүртэл өрөвдөх сэтгэлийг төрүүлж байсан Дюшен бол хуйвалдагч, харийн тагнуул мөн. Тэр Шометт, коммуныг толгойлчлоод биеэ төлөв, найртай, хэр тааруу, буянт сайн хүн гэдэг тэр Шометт гэсэн шашингүйн үзэлтэй билээ. Энэ улаан малгай хүрэм, чархи өмссөн өөрсдийгөө якобинчдаас илүү эх орончид гэж сайрхагч санкюлотууд бултаараа хуйвалдагсад харийн тагнуул мөн. Дэлхий дахины хаант засгаас алах ял заагдсан хүн төрөлхтнийг хамгаалагч Анахарейс

Клоотс ч гэсэн прусс хүн болохоор ч ямар ч хэрэг тарьж магадгүй, иймд тэр мөн л хуйвалдагч, гадаадын тагнуул мөн.

Одоо догшрогсод, дундыг баригчид зэрэг энэ бүх олиггүй амьтад Дантон, Демулен, Гебер, Шомет зэрэг энэ урвагчдын толгойг авчээ. Бүгд найрамдах улс аврагдаж бүх хороо, бүх ардын хурлаас Максимилиан, Зовлон хоёрыг сайшаах эвсэг дуун цуурайтаж байна. «Эрх чөлөөт ард түмний нэр төртэй төлөөлөгчид үлэмж биетний хөвгүүд ихэмсэг тэргүүнээ өргөлөө. Ачит Уул, ивээлт Синай, чиний буцлах хэвлээс авралын цахилгаан харвалаа» гэж сайн иргэд дуу алдацгаана.

Энэ дуунд магтаалын ихээхэн хэсэг нь онц шүүхийн хувьд ноогдоно. Сайн үйлс бүтээх хэчнээн аятай, зон олны талархах баясах нь шударга шүүгчийн сэтгэлд хэчнээн тааламжтай!

Гэвч үүний зэрэгцээ жинхэнэ эх оронч хүн гайхахгүй буюу түгшихгүй байж чадах уу? Яаж гээ вэ? Ард түмний эрх ашгаас тэрслэхэд Мирабо, Лафайта, Байя, Петион, Бриссо хангалтгүй байсан гэж үү? Эдгээр урвагчдыг илчлэгчид бас хэрэгтэй болоо шив, яаж гээв! Хувьсгалыг мандуулсан эдгээр хүмүүс түүнийг хөнөөх гэж л хийсэн юм гэж үү? Агуу өдрүүдийн агуу зоригжуулагчид нь Пиэтто Кобург нартай хамсан Орлеанчуудын үе залгамжлах ноёрхлыг тогтоох XVII Людовикийг ивээх гэж хувьсгал хийв үү? Яаж гээв! Дантон бол Монк байсан юм уу? Яаж гээв! Өөрсдийн цаазын газар явуулсан федералчуудаас илүү итгэл хөсөрдүүлсэн Шомет болон гебертистүүд улсаа сөнөөхийг бодолхийлсэн гэж үү? Итгэл эвдсэн Дантончууд болон найдвар алдсан Шометуудыг эрлэг рүү илгээгчийн дундаас Робеспьерын цэнхэр нүд эднээс ч итгэлгүй улсыг маргааш олж үзэх юм биш биз? Үл хахуульдуулагчийн гярхай нүд хэдийд хэрэгтэй болж урвагчдын бие биеэ гутамшигтайгаар барьж идэх явдал хэзээ нэг зогсох бол?..

XXI

Энэ зуур Жюли Гамлен, хар ногоон давхацтайгаа өдөр бүр Люксембургийн цэцэрлэгт очиж модны захын сандал дээр суун ордны нэгэн давчуу цонхоор амрагаа шагайхыг хүлээнэ. Тэд, өөрсдийн зохиосон дохиогоороо занган ярьж хэл амаа ололцоно. Хоригдол овоо дориун өрөөнд нийлэмжтэй нөхдийн хамт байгаа, мөн хөнжил, жин хэрэгтэй байгаа. Тэрээр янаг бүсгүйгээ энхрийлэн хайрласаар байгаа зэргийг Жюли иймэрхүү замаар олж мэджээ.



Гяндан болон хувирсан ордны цонхоор хайртынхаа царайг хардаг хүн ганц Жюли биш ээ. Хажууд нь зогсох залуу эх нэгэн цонхноос харцаа үл салган, түүнийг нээгдэхтэй зэрэг тэвэрч буй хүүгээ аль болох дээш нь өргөнө. Нүүрэндээ хар торон бүрхүүл хийсэн настай хатагтай хүүгээ хормын төдий ч атугай харах сан гэж дэмий л горилон эвхмэл сандал дээр бүтэн цагаар хөдөлгөөнгүй суух боловч хүү нь эхийгээ үзээд уяран уйлчихгүйн тул цэцэрлэг хаатал шоронгийн хашаанд зээрэнцэг шидэж өнжинө.

Ийнхүү удтал хүлээн байх үес цэлмэг ч бай, бороотой ч бай хамаагүй, Жюлийн дэргэдэх сандал дээр нэгэн харимал насны зэгсэн махлаг, маш үзэмжтэй хувцасласан хүн, нэг бол унжлага зүүлт хөөргөөрөө тоглон, үгүй бол огт уншихгүй мөртөө сонин эргүүлж тойруулан суудаг байлаа. Тэрээр алтан саатай гурван талт малгай, ухаа ягаан фрак мөнгөн хошмогтой хөх хүрэм өмсөж хуучны маягаар хувцаслажээ. Түүний байдлыг харахад хүндэтгэх сэтгэл төрнө. Хармаанаас нь цухуйх лимбэний үзүүрээр үзэхэд түүнийг хөгжимч гэлтэй.

Хувцсаа сольсон залуугаас хоромхон ч нүд салгалгүй үргэлж инээмсэглэн түүнийг явах гэж байгааг ажигламагцаа мөн л босон хойноос нь зайтайхан дагана. Энэ өвгөн, ганцаардсан золгүй түүнийг далдхан өрөвдөж байгаа нь Жюлийн сэтгэлийг хөндөв.

Шиврээ бороотой нэг өдөр Жюлийг цэцэрлэгээс гарахад үл таних тэр хүн түүнд дөхөж ирэн лут том улаан шүхрээ дэлгэж бүсгүйд миний шүхэр доогуур орж хоргодохгүй юу гэв. Бүсгүй, цангинасан дуугаар за гэж аяархан хэлэв. Гэвч тэр хүн энэ дууг сонсонгуутаа, магад ч үгүй, эмэгтэй хүний үл мэдэг үнэр авмагцаа Жюлийг аадар бороон дунд орхин шалавхан холдсонд бүсгүй цөмийг нь ойлгон сэтгэл гонсойсон ч гэсэн инээдээ барьж чадсангүй.

Жюли, Шерш - Мидийн гудамжнаа нэгэн байшингийн дээвэрт байрлаж өөрийгөө ажил эрж буй цэмбэний наймаачны даамал гэжээ. Охин нь гэртээ байгаа шигээ хаанаа ч тэгж аюулд орохгүй байгаад бэлэвсэн авгай Гамлен эцэстээ итгэн залуу хүүхнийг Тионвиллийн талбай, Шинэ гүүр, секцээс холхон суулгахыг хичээж эрвийх дэрвийхээр идэш ууш, дотуур хувцас нэмэрлэж байлаа. Жюли өөртөө жаахан хоол хийж идэн, дурлалт хүнийхээ барааг харахаар Люксембургийн цэцэрлэгт очсоныхоо дараа оромждоо ирэх бөгөөд нэгэн хэвийн амьдрал нь зовлонг нь жаал зугаа хөнгөлөн нас залуу болохоор бөх гэгч нойрсоно. Эршүүд зантай хал үзсэн, мөн эрэгтэй хүний хувцас өмссөнийхөө ачаар айх юмгүй гэж санан тэрээр Дефур гудамжнаа орших дураараа дургигч хүүхнүүд болон элдвийн хүмүүс цуглардаг «улаан загалмай» гэдэг нимбэгийн охь худалддаг мухлагт заримдаа очдог байв. Тэнд Жюли сонин уншин суух буюу эс бөгөөс мухлаг сахигчдын хэн нэгтэй юм уу үгүй бол тамхиныхаа утааг хамар луу нь үлээдэг цэргийн хүнтэй триктрак гэдэг тоглоомоор тоглоно. Энд архидах нь архидаж, хөзөрдөх нь хөзөрдөж, янаглах нь янаглалцаж байх агаад зодоон цохион гарах нь ердийн үзэгдэл байлаа. Нэгэн орой зочдын нэг нь гудамжинд морин төвөргөөн гарахыг сонсмогцоо хөшиг сөхөн, штабынхныхаа хамт давхин өнгөрөх үндэсний гвардийн дарга иргэн Анриог таниад шазуур зуун

— Робеспьерын зусарч гэж өгүүлэв. Үүнийг дуулсан Жюли инээд алдав. Гэвч нэгэн сахалтай эх оронч түүнийг дор нь зогсоолоо.

— Ийм юм хэлэхийг талархагч хүн шившигт язгууртан мөн, толгойг нь Самсоны сагс руу өнхрөхийг би дуртайяа үзэх байна. Генерал Анрио бол хэрэгцээтэй цагт Парис Конвентыг хамгаалж чадах

шударга эх оронч хүн гэдэг нь бүхэнд илэрхий. Иймээс л роялчууд түүнийг үзэж чадахгүй байгаа юм.

Тас тас хөхөрсөөр байх Жюлийг эгц ширтсэн сахалт

— Хүүе, амны салиа арилаагүй жулдрай минь! Эх орончдыг хүндлэн харьцдаг болж суртлаа өшиглүүлүүзэй, сайхан мэдээрэй гэж хашхирлаа.

— Анрио архичин, тэнэг!

— Анрио шударга якобинч! Анрио мандтугай! гэж бархиралдав.

Хоёр талцсан зодоон үүсэж малгай шалчийтал буулгах, нударга гялалзан ширээ онхолдож, шилэн аяга бут үсрэн дэнлүү унтарч хүүхнүүд зүрх зүсэм чарлалдав. Хэд хэдэн эх орончийг дайран ирэхэд Жюли сандлаар үзэлцсэн боловч түлхүүлэн ойчоод биеэ хамгаалан маажиж хазаж гарлаа. Давхцын заам нь урагдаж хөх нь чичгэнэн цухуйв. Шуугианаар эргүүл гүйдэн ирсэнд залуу язгууртан бүсгүй чүү чамай цагдаа нарын савраас мултарчээ.

Өдөр бүр тэрэг дүүрэн ялтанг зөөнө.

— Хайртыгаа цаазлуулж хэрхэвч чадахгүй! гэж Жюли эхдээ ярина.

Тэрээр хороо, албан газар, ардын төлөөлөгчид, шүүгчид, ер хөлөө хүрэх газар яваад хөөцөлдөж гуйхаар шийдлээ. Түүнд эмэгтэй хүний хувцас байсангүй. Эх нь Блез бүсгүйгээс судалтай даашинз, хошуу алчуур, торон оройвч авч охиндоо өгсөнд Жюли ч эмэгтэй хүний эх оронч гоёлоо өмсөж аваад Мазарини гудамжнаа орших чийгтэй, дүнсгэр байшинд суудаг Реноден шүүгч дээр очив.

Дагжин чичирсээр тэрээр паалантай тоосго суулгасан модон шатаар өгсөв. Шүүгч түүнийг нарсан ширээ, хоёр сүрлэн сандлаас өөр тавилгагүй тохь муутайхан өрөөндөө хүлээж авлаа. Хананд наасан хуартай цаас салбайн унжих ажээ. Жалмайсан хар үс, зэвүүн харц, жимбэгэр уруул, шөнтгөр эрүүтэй Реноден ярь гэж дохиод чимээгүйхэн чагнах ажээ.

Люксембургийн шоронд хоригдсон иргэн Шассаны дүү нь гээд Жюли яаж баригдсаныг нь аль болох урнаар ярин ямар ч гэмгүй байж хэлмэгдсэн золгүй хүн байгаа юм гэж маш шаргуу гуйлаа.

Шүүгч хэнэггүй царайлан гуйвшгүй сууна.

— Бүсгүй уйлан хөлд нь унав.

Реноден нулимсыг нь үзмэгцээ царай нь хувиран бор нүдэнд нь тачаангуйн гал дүрэлзэн янхигар хөх эрүү нь хатсан хоолойгоо

шүлсээр дэвтээх гэсэн мэт явигнав.

— Бүсгүй, хэрэгцээтэй зүйлийг хийж өгнө, бүү зов.

Тэгээд тэрээр хаалга нээн өвдөг сөгдөгч бүсгүйг шаазан суулга, ханын алтадсан цаг, цэцэглэг дэн гэрэл, суудал нь хонхойсон матмал сандал, Бушегийн малчны амьдралыг харуулсан зурагтай хивсэн аравч бүхий зөөлөвчит бандан тавьсан, ягаан эрээн ханатай жижигхэн тасалгаа руу түлхэв. Жюли ч гагцхүү амрагаа аврахын тулд яахаас ч буцахгүй байлаа.

Реноден дээрэнгүй бөгөөд хурдан эдлэв. Жюли, Элодийн гоёлын бошинзыг зассаар босохдоо харц нь догшин тохуурхсан харцтай мөргөлдсөнд шал дэмий хохирсноо дорхноо мэдэв.

— Ахыг минь суллана гэж та надад амласан шүү дээ гэж бүсгүйн хэлэхэд тэрээр жуумалзав.

— Бүсгүй минь, би хүссэн зүйлийг тань бүтээнэ, өөрөөр хэлбэл. ахтай чинь яг л хуульд зааснаар харилцах болно гэж би хэлсэн. Мөн бүү зов гэсэн, ер зовох юм юу байх вэ? Хувьсгалт онц шүүх ямагт шударга билээ.

Түүн тийш үсрэн очиж. хазаж хайран, нүдийг сох маажчихмаар бүсгүйд санагдана. Гэвч ингэвэл Фортюне Шассаныг бүрмөсөн сүйд хийнэ гэдгийг ухварласан тэрээр тасалгаанаас бушуухан гарч, хонгилдоо яаран ирээд Элодийн бузарлагдсан даашинзыг тайлж хаяв. Тэгээд бухимдаж зовсондоо шөнөжин уйлж билээ.

Маргааш өглөө нь Люксембург рүү очоод Жюли цэцэрлэгээр дүүрэн цагдаа болчихсон эмэгтэйчүүлийг хүүхэд шуухадтай нь тэндээс хөөж байхыг үзэв. Цэцэрлэгт зогсох олон харуул хоригдлуудыг хүнтэй ярихыг хориглоно. Хүүхдээ тэврэн өдөр бүр ирдэг залуу эх, шоронд хуйвалдаан гарсан гэдэг цуу дэгдсэн мэт, язгууртан урвагч нарт туслах хөдөлгөөн ард түмний дунд гаргах зорилгоор эмэгтэйчүүдийг цэцэрлэгт цугларсан гэж буруутгаж байгаа мэт Жюлид ярив.

XXII

Гэнэт Тюильерийн цэцэрлэгт уул босголоо. Тэнгэр цэв цэлмэг. Хөх фрак, шар өмд өмссөн Максимилиан, тарианы түрүү, хөх цэцэг, намуу цэцгийн баглаа барин нөхдийнхөө манлайд морилж явлаа. Тэрээр, уул өөд залран гарч Бүгд найрамдах улсынхаа бурхнаар Жан - Жакийг тунхаглав. Аяа ариун ёс! Аяа дөлгөөн төлөв зан! Аяа үнэн шашин! Аяа өнө эртний эгэл байдал! Аяа зовлонгийн нулимс! Аяа элбэгийн шүүдэр! Аяа нинжин сэтгэл! Аяа хүмүүсийн ахан дүүгийн барилдлагаа!

Бурхангүйн суртал, гутамшигт толгойгоо дэмий л өргөвөөс Максимилианы шүүрэн авсан бамбарын дөл мангасыг хайлуулж, түүний оронд нэг мутраараа хурмастыг зааж нөгөөгөөрөө оддын титэм барьсан цэцэн билэг гарч ирнэ.

Тюильерийн ордны өмнө босгосон тавцан дээр Эварист, уярсан олны дунд зогсонхон баярын нулимс асгаруулж бурхныг талархана. Жаргалангийн эрин эхэлснийг тэрээр үзжээ.

— Хэрвээ өөдгүй амьтад л зам гудас саад тотгор болохгүй бол бид ингээд л жаргалтайгаас жаргалтай, ариунаас ариун боллоо гэж сүүрс алдана.

Харамсалтай нь өөдгүй амьтад замд нь хөндөлслөө. Цаазлах хэрэгтэй, бузар цусыг ус мэт урсгах хэрэгтэй. Шинэ холбоо болон хурмаст хорвоо хоёрыг эвлэрүүлсний баярыг ёслон тэмдэглэснээс хойш гурван өдрийн дараа Конвент, хилс хэрэгт унасан хүнийг хамгаалахын тул шударга ромчуудын үед зохиосон зүйл бүхнийг, ердийн хуулийг нэн амарлингуй өөрчлөгч прериалийн хуулийг гаргав. Одоогоос мөрдөхөө ч, байцаахаа ч больж, гэрч ч, өмгөөлөгч ч авахаа байж эх орноо хайрлах хайр бүхнийг орлох боллоо.

Хэрэгтэн гэмтэй, гэмгүйгээ дотроо л хадгалсаар эх оронч шүүгчдийн өмнүүр дуугүй өнгөрнө. Бас тэгээд энэхэн хугацаанд адармаатай, будилаантай, бүрхэг хэргийг ялгаж салгах хэрэгтэй шүү дээ. Одоо яаж шүүх вэ? Шударга хүнийг өөдгүй этгээдээс, эх орончийг, эх орны дайснаас нэгэн агшинд хэрхэн ялгах вэ?

Хэсэг самгардсаны дараа Гамлен одоогоос үүрэг нь юунд оршиж буйг ойлгон шинэ ажилдаа дасжээ. Илүүц ажиллагааг цомхотгох явдал бол хуучирсан жигнүүр дээр за юу, үгүй юу гэдгийг нухацтай цэгнэдэг үг үсэгтэй зууралдагч эрдэмтэд биш харин нүд ирмэхийн зуур үнэнийг

ойлгогч, эх оронч гэрэл гэгээг удирдлага болгогч санкюлотүүд, гүйцэтгэгч нь болсон аврагч догшин үнэний шүүхийн жинхэнэ биелэл болох юм гэж үзэж байлаа. Өмгөөлөлт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь бүхнийг хөнөөж байхад үнэнч зүрхний тэмүүлэл цөмийг аварна аа. Хэзээ ч ташаардаггүй ачит байгаль эхийн сургаалыг дагах нь зүйтэй. Зүрх сэтгэлээрээ шүүх хэрэгтэй. Гамлен Жан - Жакийн нэрийг барин «Буянт нөхөр минь, та хүнийг хайрлах, түүнийг мандуулан бадраах үйлст хичээнгүйлэн зүтгэхэд намайг зоригжуулж хайрла!» гэнэ.

Түүний ихэнх нөхөд нь түүн лүгээ адилхан сэтгэж байлаа. Эд бол голчлон хар бор улс байсан хийгээд ажиллагааны хэлбэрүүд цомхон болохтой зэрэг бүр ч амарчээ. Шүүхийн ажиллагааг хялбарчилсан нь тэдний сэтгэлд таарав. Түүний шуурхай явц тэднийг зовоосонгүй. Өөдгүй этгээд биш мөртөө ялтангууд нь тэднээс өөрөөр сэтгэж байж болно гэдгийг ардын төлөөлөгчид бодолгүй зөвхөн үзэл бодлыг нь лавлана. Тэд биеэ үнэнч, цэцэн билигт, дээд зэргийн тустай улс гэж санах учир сав л хийвэл дайснуудаа төөрөгдсөн муу үйл хийсэн гэж тулгана. Бурхныг толилон харж байсны улмаас тэд хүчирхгээ мэдэрч байлаа.

Хувьсгалт онц шүүхийн энэ ардын төлөөлөгчид, бурхныг толилон харж байлаа. Максимилианы бий гэж зөвшөөрсөн далдын хүчтэн тэдэн дээрээс гал дөл мэт бууж иржээ. Тэд хайрлаж ч, шүтэж ч байлаа.

Одоо зөвхөн бүлэг бүлгээр нь шүүх болсон учир ялтны сандлыг тавин хүн уужуухан багтах том тавцангаар сольжээ. Олон нийтийн яллагч хэргийг нэгтгэж, Онц шүүхэд л нүүр нүүрээ үзэж байгаа улсуудыг ч хамаагүй хамсаатан хэмээн яллана. Прериалын хуулиас олгосон эрхийн ёсоор Онц шүүхийнхэн, дантончууд болон коммуныхныг шүүсний дараа гарсан хуйвалдааны талаарх хэргийг тун өнгөц хянан үзэж байв. Огт хамаагүй улсыг эдний хамсаатан хэмээж, байгаагүй шоронгийн хуйвалдааныг бий болгосон нь элдэв хий бодолд автсаны үр ажээ.

Бүгд Найрамдах Улсын эсрэг харь газрын алтны тусламжтайгаар явуулсан хуйвалдааны, зохисгүйгээр дундыг барих, зориудаар хэтэрхийлэх хоёр гол шинжийг нотлохын тулд, мөн түүнээс гадна дантончууд болон гебертчүүдийн үйлдэж буй хоёр хоёр гэмт хэрэг бийг үзүүлэхийн тулд хэрэгтэн Камилийн бэлэвсэн гэргий дур булаам хүүхэн Люсиль, гебертчийн гэргий аманцар хүүхэн Момор нарыг энэ

хуйвалдааны удирдагчид болгон тавьжээ. Тэр хоёрыг эн зэрэгцүүлэхийн тул шоронд хамтад нь хорьж, тэнд нэгэн чулуун сандал дээр хамтад нь уйлуулж, эн зэрэгцүүлэхийн тулд цаазын газар хамтад нь илгээжээ. Энэ нь ямар нэгэн прокурорын сэдсэн, мөр зэрэгцүүлэх маш цэцэн, бэлгэ тэмдэгт, онцгой санаа байсан боловч үүнийг Максимилиан л ухаан сийллээ гэлцэж байв. Хууль, зан үйлийн өөрчлөлт, жилийн улирлыг өөрчилсөн явдал, ургацын гарц, халдварт өвчний тархалт зэрэг тус оронд үүтгэгдэж буй муу сайн бүх хэрэг явдлыг ардын энэ төлөөлөгчид л тохож байлаа. Турьгүй, нүдэнд хүйтэн, цэвэрч, муурын царайт энэ хүн ард түмнийг эрх мэдэлдээ бүрэн барьж байсан болохоор энэ нь зүй ёсны шударга бус зүйл байлаа...

Тэр өдөр Онц шүүх, шоронгийн хуйвалдаанд оролцсон, Люксембургийн маш номхон хоригдол гэгдэх авч илэрхий роялч, федералч гучаад хүнийг нөгөө ертөнц рүү тонилгов. Цорын ганц ховчийн мэдүүлэг дээр үндэслэн бүх ялыг тулгажээ. Төлөөлөгчид хэрэгтэй ер танилцаагүйгээр барахгүй хуйвалдагсдын нэрийг ч мэдэхгүй байв. Ялтны суудлыг хальт харсан Гамлен тэдний дунд Фортюне Шассань байхыг үзэв. Удтал хоригдсоноос турсан, шүүхийн танхимын хурц гэрэлд догшин дүртэй үзэгдэх зэвхий царайтай Жюлийн нууц амраг гоо жавхлан, омог бардам зангаа өчүүхэн ч атугай хадгалсаар ажээ. Түүний харц Гамленыхтай мөргөлдөхдөө жигшлээр гялалзав.

Уур хилэн нь бадарсан Гамлен үг хэлэх зөвшөөрөл аваад шүүгчийн толгой дээр өлгөөтэй байгаа эртний Брутагийн⁶ баримлыг ширтэн

— Иргэн дарга, шийтгүүлэгчдийн нэг бид хоёрын хооронд хэрвээ нууц биш ил байсан сан бол ураг төрлийн гэж тооцох барилдлагаа бий боловч би шүүхийн ажиллагаанд оролцохоо байя гэж гуйхгүй ээ. Хоёр Брута Бүгд Найрамдах Улсыг аврахын төлөө, эрх чөлөөний үйл хэргийн төлөө хүүгээ шийтгэх юм уу өргөж авсан эцгээ цааш харуулах болохдоо хуралд оролцохоос татгалзаагүй билээ гэж хэлээд ахин суудалдаа суухад нь

— Ямар цагаандаа гарчихсан хог вэ гэж Шассань шүд зуун хэлэв.

Гамлен жирийн сэтгэл бодлоос дэндүү хальснаас ч тэр юм уу, дээгүүр ихэмсэг зан улиг домог болсноос ч тэр юм уу, цуглагчид төлөөлөгчийн үг хэлэхэд хөөрөн баяссангүй билээ.

— Иргэн Гамлен, хууль ёсоор бол шүүхийн ажиллагаанд оролцохоос татгалзах тухайгаа шүүхийн хуралдаан эхлэхээс хоногийн өмнө бичгээр мэдэгдсэн байх ёстой. Гэвч ямар ч эрмэлзлээс эх оронч үзэл илүү болохоор ингэхийн хэрэг чамд огт байгаагүй гэж дарга өгүүллээ.

Хэрэгтэн тус бүрийг гурав дөрвөн минутаас илүүгүй байцаав. Яллагч бүгдийг цаазаар авахыг шаардсанд төлөөлөгчид ганц өгүүлбэрээр буюу толгой дохин нэгэн дуугаар саналаа илэрхийлэв. Ээлжээ болоход Гамлен

— Бүх шийтгэгдэгчид хэргээ хүлээсэн, харин хууль ямар нэг тайлбар тавихыг зөвшөөрөхгүй байна гэлээ.

Хар ногоон давхацтай арван долоо, арван найм орчим насны залуу шүүхийн шатаар бууж явахад нь Эваристыг зогсоов. Дагзан дээрээ тавьсан дугуй бүрх малгайны нь хүрээ үзэсгэлэнт цонхигор царайг нь тойрсон дугуй хар сацраг мэт үзэгдэнэ. Тэрээр төлөөлөгчдийн замыг хаан зогсож айсан цөхөрсөн дуугаар

— Бузар амьтан! Хүний үнэргүй хог! Алуурч! Өөдгүй солиг, намайг ч гэсэн алаад аль. Би бүсгүй хүн, намайг барьж ал гэж тушаагаач, яргачин минь! Би дүү чинь байна гэж хашхирав.

Тэгээд Жюли түүний нүүр лүү нь нулимав.

Тэр үед «нэхмэлчин» болон санкюлотуудын урьдын хувьсгалч сэрэмж нь буурч эх оронч гал цог нь унтарчээ. Гамлен болон түүнийг доромжлогч хоёрыг тойрогсод дөнгөж шийдвэргүйхэн хөдөлснөөс наашгүй. Жюли сониуч олны дундуур чихцэлдэн бүрэнхий дунд далд орлоо.

XXIII

Ядарч зүдэрсэн Эварист Гамлен жаахан ч амарч чадалгүй шөнө хар даран зүүдэлж хориод удаа цочин сэрнэ. Зөвхөн хөх тасалгаанд Элодийн элгэнд хэдэн цаг нүдний хор гаргана. Нойрон дундаа тэрээр ярьж хашхирч Элодийг сэрээх боловч бүсгүй үгнээс нь юу ч үл ойлгоно.



Нэгэн өглөө тэрээр шөнө нь Евменидыг⁷ зүүдэлж аймшигт хий үзэгдлээс тамаа цайн, хүүхэд шиг тэнхээгүй болчихсон сэрэв. Эваристын дух руу унжих үс нүдийг нь бүрхэн таглахад толгойн тушаа нь суух Элоди дуулгаваргүй үсийг нь аяархан хойш илнэ. Энэ удаа тэрээр, эгч хүний энхрий харцаар түүнийг ширтэн духан дээр нь чийхарсан хүйтэн хөлсийг амны алчуураар арчиж байв. Тэгээд Еврипидын «Орестын» нэг сайхан үзэгдэл, Гамлены зурахаар ноороглосон, хэрвээ дуусгасан бол шилдэг бүтээл нь болох байсан, золгүй Электрагийн ахынхаа уруулд цахарсан хөөсийг арчиж буй тэр нэгэн зураг нь Гамлены сэтгэлд ургав. Тэгээд «Хонгор ах минь, өш авагч охин тэнгэр чиний ухаан санааг чинь авчхаагүй байгаа дээр миний үгийг сонс...” гэж Элоди нь нам дуугаар түүнд хэлэх мэт бодогдоно.

«Ямар ч гэсэн би эцгээ алсан хүн биш. Харин тэс ондоо, чухамхүү хүүгийн хайраар жигүүрлэсэн би эх орныхоо дайснуудын бузар цусыг урсгаж байна» гэж Эварист боджээ.

XXIV

Энэ шоронгийн хуйвалдаанд төгсгөл гэж байсангүй. Дахин дөчин есөн хүнийг ялтны ширээнд суулгалаа. Морис Бротто дээд эгнээний баруун талд хүндтэй байрыг эзлэв. Урьд өдөр нь Лукрецийн ботид үрэгдэн цоорсон хармааг нь нөхөж нямбай нь аргагүй цэвэрлэсэн хүрэн сюртукээ өмсжээ. Броттогийн хажууд будаг шунх, оо энгэсэг тавин оёж гоодсон айдас хүрмээр хатагтай Рошмор сууж байлаа. Рошмор болон Мадлонет гэдэг шоронд ороод бүр чиг залуужсан Атенайс бүсгүй хоёрын дунд эцэг Лонгмарыг суулгав.

Цагдаа нар хэрэгтнүүдийг тууж авчран ялтны ширээнд суулгав. Эднийг дээр дурдсан улсын аль нь ч танихгүй бөгөөд тэд өөрсдөө бие биеэ мэдэхгүй байсан ч байж магад. Гэвч энэ нь эдгээр депутат, хуучин тайж нар, борчуулыг хуйвалдагсад гэж мэдэгдэхэд саад болсонгүй. Рошмор хатагтай, төлөөлөгчдийн суудалд сууж буй Гамленыг ажиглав. Хэдийгээр тэр нь Рошморын гуйж гувшсан захиа, нэг биш удаа илгээсэн бичигт нь ганц ч хариу өгөөгүй боловч хатагтай горьдож түүнийг уярааж сэтгэлийг нь татахыг хэчнээн гуйсан харцаар горь үл тасран харж байлаа. Гэвч залуу шүүгчийн хүйтэн харц горьдлогыг нь тасаллаа.



Нарийн бичгийн дарга ялын төлөвлөгөө уншлаа. Хэрэгтэн бүрд багагүй анхаарал хандуулсан авч шийтгэгсдийн тоо нь олон учраас түүнийг унших гэж их цаг идэв. Ардын төлөөлөгчид болон Парисын хүн амын цуснаа бүгд найрамдах улсыг живүүлэх зорилгоор шоронд байгуулсан хуйвалдааны байдлыг маш тод томруунаар онцлог шинжтэй дурдаж хэрэгтэн тус бүрийг тогтоолд тэмдэглэсэн нь:

«Энэ шившигт хуйвалдааныг санаачилсан тун аюултай хүмүүсийн нэг нь урьд дез - Илетт гэгдэн эзэн хааны хаанчлалын үед алба гувчуур худалдаж аван дамладаг байсан Бротто юм. Харгис засгийн үед ч садар самуун зан байдлаараа тодорч байсан энэ хүн нь ард түмэн, эрх чөлөө, аз жаргалын томоохон дайсан гэдгийн биет гэрч бөгөөд үнэхээр ч сангийн мөнгийг үрэн, ард түмний хөрөнгийн ихээхэн хэсгийг наргиан

цэнгэлд бүрэлгээд энэ этгээд гадаад дүрвэгчидтэй захидлаар харилцаж гадаадын хайвалдагсдад манай санхүүгийн бэл зоорь, манай цэргийн хөдөлгөөн, олон нийтийн сэтгэл санааны өөрчлөлтийн тухай мэдээлж байхын тул урьд нөхцөж байсан Рошмортойгоо сүлбэлдсэн байна.

Ийнхүү гутамшигтайгаар амь зууж байх үедээ Бротто нь Фромантын гудамжны балчиг шавхайнаас олж авсан янхан бүсгүй Атенайстай нөхцөж байсан хийгээд үүнийгээ өөрийн төлөвлөгөөнд хялбархнаа татан оруулж ичгүүргүй үл бүтэх уриа хашхирч, хувьсгалын эсэргүү үг хэл гаргахыг ятгасан байна.

Энэ хорт хүний хэлсэн хэд хэдэн үг нь түүний шившигт үзэл санаа хөнөөлтэй зорилгыг тодхон тодорхойлж байгаа юм. Одоо үүнийг гэгсгээх гэж байгаа эх оронч Онц шүүхийн тухай тэрээр «Хувьсгалт онц шүүх бол Вильям Шекспирийн хамгийн цуст үзэгдлүүд нь нэн жигшүүртэй алиалалтай солигдон байдаг жүжигтэй адилхан» гэж ичгүүргүйгээр баталж байлаа. Ард түмнийг сулруулах, завхруулах итгэлтэй хэрэгсэл болох бурхангүйн суртлыг цөхрөлтгүй номнож байлаа. Консьержерийн шоронд байхдаа тэрээр манай ялгуусан армийн ялалтыг гай гамшиг мэтээр үзэн гашуудаж эх оронч үзэлтэйгээ нэг бус удаа нотолсон жанждыг сэжиглүүлэхийг махран, тэднийг төрийн эрхийг авах гэж хүсэж байгаа мэтээр гүжирдэж байлаа. Үзгээр ч бичиж зүрхлэмгүй булай үг хэлж тэр «бэлхэн байгтун», зэр зэвсгээ хангинуулагчдын нэг нь та нарыг ёгт үлгэрт тогоруу мэлхийг залгисан гэж байдаг шиг л залгих болно, түүнд бэлхэн байгтун» гэж занаж байжээ.

Ялын төлөвлөгөөнд цааш дурдсан нь:

«Броттогийн нөхцөж байсан тайжийн авгай Рошмор нь түүнээс багагүй зэмтэй. Энэ нь гадаадтай харилцан Питтээс, өөрөөс нь мөнгөн харамж авч байснаар зогсохгүй Жюльен (Тулузийн), Шабо нартай хамсан, урьд барон байсан де Батцтай сүлбэлдэн энэ үл бүтэх этгээдтэй цуг Энэтхэгийн холбооны цаасан тэмдэгтийг хямд үнээр худалдаж аваад арга хэрэглэн өртгийг нь гэнэт нэмэгдүүлж улсын болон амины өмчид хор хүргэж түүний ханшийг бууруулах зальт аргыг сүвэгчлэн бодож олж байжээ. Бурба, Мадлонетэд хоригдож байхдаа тэрээр шоронд ч гэсэн хуйвалдаан болон биржийн дамын худалдаанд оролцохоо зогссонгүй үүний хажуугаар шүүгчид төлөөлөгчдийг хахуульдахыг чармайж байлаа.

Тайж, капуцин байсан Луй Лонгмар нь хариуцлагад татагдаж байгаа урвах ажиллагаанд биеэ зориулахаас өмнө янз бүрийн шившигт явдал, гэмт хэрэгт оролцож байлаа. Броттотой нэгэн оромжид суунгаа тэрээр Атенайс гэгдэж байгаа Горкю бүсгүйтэй ичгүүртэйгээр явалдаж байсан хийгээд дээр дурдсан хүүхэн, тайж хоёрын хамсаатан нь болно. Консьержерт хоригдож байхдаа, эрх чөлөө, олон нийтийн амгалан байдалд халдсан гүтгэлгээ ганц ч өдөр алгасалгүй бичиж байжээ.

Атенайс хэмээх Марта Горкюгийн талаар бол янхан хүүхнүүд нь ард түмний ёс суртахууныг доромжлогч шилбүүр, нийгмийн гутамшиг, түүнийг бузарлагч гэдгийг тэмдэглэхэд зохистой. Хэрэгтэн эмэгтэйн өөрөө ичгүүргүйгээр улайж байгаа ой гутам гэмт хэргийг зарлаад байхын хэрэггүй билээ...”

Ялын төлөвлөгөөнд дараа нь Бротто, Лонгмар, Рошмор хатагтай нарын хэн нь ч ганц хоёрыг нь шоронд нүүр үзсэнийг л тооцохгүй юм бол, огт үл таних, гэсэн ч «Ард түмнүүдийн он дарааллын бичигт урьд өмнө ер гарч байгаагүй шившигт хуйвалдаанд» хамт оролцсон гэгдсэн бусад дөчин таван хүний тухай дурджээ.

Ялын төлөвлөгөөнд бүх шийтгүүлэгчдийг цаазаар авахыг шаардсан байлаа.

Броттог анхлан байцаав.

— Чи хуйвалдаанд оролцсон уу?

— Үгүй оролцоогүй. Саяын сонссон ялын төлөвлөгөө дэх юм цөм худал байна.

— За харахгүй юу, одоо ч гэсэн чи Онц шүүхийн эсрэг хорон санаа агуулсаар л байна биш үү.

Тэгээд дарга, Рошмор хатагтай руу ороход цаадах нь бүх асуултад нь нулимс асгаруулан цөхрөн мэлзэж булзааруулахыг оролдон өчиж байлаа.

Эцэг Лонгмар бурхны таалалд бүрэн найджээ. Тэрээр, тэр ч байтугай бичсэн өмгөөлөх үгээ ч авсангүй.

Түүнд тавьсан асуудалд тэрээр байдгаа умартан өчиг мэдүүлэв. Гэвч дарга түүнийг капуцин гэж дуудахад тэрээр хуучин хэвдээ оров.

— Би капуцин биш, би лам варнавчуудын холбооны гишүүн хүн гэж хэлсэнд

— Энэ чинь адилхан шүү дээ гэж дарга тайван гэгч татгалзав. Эцэг Лонгмар түүнийг эгдүүцэн хараад

— Христосын эрхэм шавь Павелын байгуулсан варнавчуудын холбооны гишүүнийг капуцинтэй хутгана гэдгээс илүү жигтэйхэн алдааг хийхэд хэцүү гэв.

Хүмүүс хөхрөлдөн шивэр авир хийв.

Эцэг Лонгмар ийнхүү инээлдсэнийг хүмүүс миний хэлснийг зөвшөөрөхгүй байгаагийн тэмдэг гэж үзээд үзэл бодлыг нь зүрхэндээ хадгалж явдаг Варнавын ариун холбооныхоо гишүүн чигээр үхэхэд бэлхэн байна гэв.

— Чамайг шившигтэйгээр энхрийлж байсан Атенайс гэгдэх Горкю бүсгүйтэй хамт хуйвалдаанд оролцсоноо хүлээх үү? гэж дарга асуув.

Эцэг Лонгмар гунигт нүдээр дээш мэлрэн харж, алив самуун үг хэлчихээс болгоомжилсон лам хүний байдал, сэтгэлийнхээ угаас гайхсан байдлыг илэрхийлэн энэ асуултад хариу өчсөнгүй.

— Бүсгүй Горкю, чи Броттотой цуг хуйвалдаанд оролцсоноо хүлээх үү? гэж дарга Атенайст хандан асууваас бүсгүй

— Ноён Броттог зөвхөн сайн үйл л бүтээж явсан хүн гэж би боддог. Ийм хүн ертөнцөд олон байгаасай! Түүнээс сайн хүнийг би мэдэхгүй. Түүнийг муушаагаад төөрөгдөж байгаа юм. Миний хэлж чадах юм энэ л байна гэж төлөвхөн хариулав.

Броттотой хууль бусаар ханьцаж байснаа хүлээх үү гэж дарга түүнээс асуулаа. Энэ нэр томъёог бүсгүй ойлгоогүй учир тайлбарлаж өгөх хэрэг гарав. Чухам юуны тухай ярьж буйг ухаарахдаа бүсгүй, бүх юм тэр хүнээс л шалтгаалах байсан, гэвч тэр, энэ талаар юу ч хүсээгүй хэмээн хариуллаа.

Үзэгчдийн дунд инээлдэх нь сонстож, дарга, хэрвээ ахиад ингэж ичгүүр сонжуургүй аашлах юм бол танхимаас гаргана гэж түүнийг сүрдүүлэв. Тэгэхэд бүсгүй түүнийг хоёр нүүрт, гөлгөр царайлсан амьтан гээд төлөөлөгч, шүүгч нарыг аль муухайгаар зүхэж, цагдаа нарт чирэгдэн тасалгаанаас гартлаа догшров.

Дараа нь дарга бусад хэрэгтнийг сандал дээр сууж буй эрэмбээр нь товч байцаав. Наветт гэдэг хүн, дөнгөж дөрвөн өдөр л шоронд хоригдож байгаа болохоор уул хуйвалдаанд орсон байх боломжгүй гэж хариулав. Дарга, энэ тайлбарыг анхааруштай юм байна гэж хүлээгээд үүнийг харгалзаж үзэх хэрэгтэй гэж ардын төлөөлөгчдөд хэлэв. Белье хэмээгдэгч мөн л тийм өчиг мэдүүлсэнд дарга, ялтанд талтай үг ардын төлөөлөгчдөд хандан хэлэв. Зарим нь шүүгчийн энэ найрсаг байдлыг

сайшаагууштай шударга явдал мөн гэж байхад нөгөөдүүл нь хов хүргэсний шан гэж тооцож байлаа.

Олон нийтийн яллагчийн орлогч үг хэлэх зөвшөөрөл авав. Тэрээр ялын төлөвлөгөөний доторх үндсэн зүйлийг зөвхөн баяжуулаад доорх асуудлыг тавив.

— Морис Бротто, Луиза Рошмор, Луи Лонгмар, Атенайс хэмээх Марта Горкю, Евсевич Роше, Пьер Гюитон - Фабле, Марселина Декурти болон бас бус хүмүүс нь алан талах, өлсгөлөн гаргах, цаасан болон төмөрлөг мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэх, нийгмийн ёс суртахууныг завхруулж, олон нийтийн санал сэтгэлийг алдагдуулах, шоронд үймээн дэгдээх зэрэг аргаар амжилт олох, иргэний дайн хийж, ард түмний төлөөлөгчдийн газрыг тарааж, вангийн засгийг ахин тогтоох зорилготой хуйвалдааныг хийсэн гэдэг нь батлагдсан уу?

Ардын төлөөлөгчид зөвлөлдөх өрөө рүү оров. Эхлээд дарга, дараа нь олон нийтийн яллагч хоёроос хэрэгт холбогдолгүй гэж үзэн дээр нэр цохсон Наветт, Белье хоёроос бусад ялтанг буруутай гэж тэд нэгэн дуугаар зөвшөөрөв. Гамлен

— Хэрэгтэн этгээдүүдийн гэмтэй нь тов тодорхой, тэднийг шийтгэх нь үндэстний тусын тулд чухал бөгөөд тэд ч нүглээ наманчлах цор ганц арга болох алах ялыг өөрдөө хүсэх ёстой гэв.

Дарга, шүүхийн тогтоолыг хэрэгтнүүдийн эзгүйд уншин сонсгов. Тийм ажиллагаа явагдсан өдөр, хуульд заасныг зөрчин, шүүхийн тогтоолыг уншиж сонсгохоор ялтангуудыг танхимд оруулж ирэхээ байсны учир нь ийм олон хүн цөхөрсөндөө гэнэт зад дайрч мэднэ гэж халширсан хэрэг буюу. Дэмий айжээ. Тэр үед хэлмэгдэгсэд хязгааргүйеэ номхон хүлцэнгүй байсан билээ! Нарийн бичгийн дарга тогтоолыг уншихаар доош буусан хийгээд цаадуул нь түүнийг таг чимээгүй сонссон нь эдгээр прериал сард хохидоо гарагчдыг, огтлохоор болсон мод лугаа жишиж үзвэл таарах мэт өөрийн эрхгүй санагдах ажээ.

Рошмор хатагтай хөл хүндтэй гэж хэлэв. Ардын төлөөлөгчдийн дунд мэс засалч байсан учир хүүхнийг үз гэж түүнд даалгав. Түүнийг ухаа алдаж унахад нь шорон руу аваачлаа.

— Ээ чааваас гэж, энэ шүүгчдийг өрөвдмөөр юм, тэдний сэтгэл санааны байдал үнэхээр гашуудам юм. Тэднүүс цөмийг нь будилж, варнавчийг францисканчтай андуураад байх юм гэж Лонгмар гашуудан хэлж билээ.

Цаазын ажиллагаа, мөн өдөртөө «Хөмөрсөн хаан ширээний» харуулын дэргэд болох ёстой байлаа. Үсийг нь авч, цамцны нь захыг хайчилсан ялтангууд бичиг хэргийн тасалгаанаас шилэн ташаалавчаар тусгаарласан жижиг өрөөнд мал шиг туугдан ороод алуурчаа хүлээж байв.

Зандалчныг туслагч нараа дагуулан ирсэнд Лукрецийн сургаалыг тайвнаа уншиж байсан Бротто, дөнгөж эхэлсэн хуудсандаа тэмдэг тавиад номоо хавхийтэл хамхин сюртукнийхээ хармаанд хийж

— Эцэгтэн минь, танд үзлээ бүрэн итгүүлж чадахгүй нь гэж бодохоос галзуурмаар байна. Бид хоёулаа эцсийнхээ нойроор нойрсоно. Би ч «За харж байна уу, та ахиад юу ч мэдрэхгүй, юу ч ухамсарлахгүй, та сүнснээсээ хагацсан. Хойд нас, урьд наснаас ямар ч ялгаа байхгүй» гэж хэлэхийн тул ханцуйнаас тань татан таныг сэрээж чадахгүй ээ хэмээн варнавчид өгүүлэв.

Тэрээр инээмсэглэх гэсэн боловч цээж рүү хатган өвдөж эгээ л ухаан алдсангүй.

Гэвч тэрээр үргэлжлүүлэн

— Би танд доройгоо мэдэгдлээ. Эцэг минь, би аминдаа хайртай, түүнээсээ харамсалгүй хагацаж чадахгүй нь гэсэнд гэлэн

— Ноёнтон минь, та надаас зоригтой, гэвч үхэл таныг тун бачимдуулж байгааг анхааралдаа авагтун. Энэ нь одоо болтол таны үзэхгүй байгаа нөгөө ертөнцийг би харж байна гэсэн үг биш үү? хэмээн хариулбал

— Та, амьдралыг үргэлж үхэлтэй адилтгаж байсан, тэгэхэд би танаас илүү амьдарч чадаж байсан болохоор би амьдралдаа харамсаж байгаагаар үүнийг тайлбарлаж болох юуны магад вэ гэж Бротто татгалзав.

— Ноёнтон минь гээд Лонгмарын царай зэвхийрэн — одоо ёслолын цаг боллоо. Тэнгэр бурхан болгоож хайрла. Эцсийн зуушинд ч ам хүрэлгүй үхэх нь тодорхой боллоо. Өнөөдөр миний ингэж хүсэж байхад тэнгэр надад түүнийг соёрхохоос татгалзаж байгаа болохоор би хэзээ нэгэн цагт ариун хишгийг нь зохих ёсоор чичрэн дагжиж, гялайснаа илэрхийлж хүртээгүй юм байж дээ гэв.

Тэрэг гадаа хүлээж байлаа. Гарыг нь хүлсэн хэрэгтнүүдийг чихэлдүүлэн суулгав. Мэс засалч, жирэмсний шинж тэмдэг олоогүй учир Рошморыг нэгэн тэргэн дээр өргөж гаргав. Эцсийнхээ хүчийг шавхан тэрээр, алив найдлага хэдий тасарсан боловч амь аврах хүн

байна уу хэмээн горилон үзэгч олныг мэлрэн ширтэнэ. Гуйж гувшсан байдал нүдэнд нь төгс ажээ. Урьдынхыг бодвол хүн цөөхөн цугласан хийгээд сэтгэл хөөрөн бархиралдах нь тоотойхон байв. Зөвхөн хэдхэн хүүхэн л «Эрлэгт нь тонилго!» гэж хашхиран, үхлээ хүлээгчдийг даажигнах ажээ. Харчуул, болгоомжилсондоо ч гэхэд хаашаа юм, хуулийг хүндэлсэндээ ч гэхэд хаашаа юм, дув дуугүй зогсон мөрөө хавчисхийлгэсэнээ буруу харж байв.

Атенайсыг гарч ирэхэд тэр нь бүр хүүхдээрээ юм шиг санагдсан учир хүмүүс давхийв.

Бүсгүй, гэлэнгийн өмнө толгой гудайн

— Ноён ламбугай минь, миний хилэнцийг арилгаж өгөөч гэв.

Эцэг Лонгмар, уншлагаа баясгалантайгаар амандаа уншсанаа

— Охин минь, та балчиг намагт тун айхавтар шигдсэн хүн юм, гэвч би тан шиг цайлган, эрхэм сэтгэлтнийг хаан ширээнд өргөмжлөхийг хүсэх сэн гэв.

Бүсгүй, тэргэнд шурдхийн орж цэхрэн босоод бяцхан толгойгоо бардмаар өргөн

— Ван мандтугай! гэж хашхирав.

— Ноёнтон минь, шүтэхгүй байгаа бурхандаа миний төлөө залбирч соёрхооч гэж танаас хишиг гуйж байгаа юм шиг гуйя. Яаж мэдэх вэ, та надаас ч илүү түүнд ойр шадар юм билүү. Ганц агшин л бүгдийг шийдвэрлэж болох шүү. Тэнгэр бурхны хайрт үр нь болоход хормоос илүүгүй хугацаа хэрэгтэй. Ноёнтон минь миний төлөө мөргөөрэй гэж эцэг Лонгмар эпикурийн сурталч гүн ухаантанд хэлэв.

Хотын захын цардмал замаар тэрэгний дугуй хяхтнан чахран эргэж, гэлэн амандаа сэтгэлдээ хойдохоо уншсаар явав.

Бротто, байгалийн бадрангуй дуучийн “Sic ubi non erimus...” гэдэг шүлгийг санагалзав. Гар нь хүлээстэй тэрээр донсолгоо бүрд овсхийв ч тэрхүү гутамшигт тэргэн дээр ч гэсэн налгар намбаа тавиагүй хийгээд бүр ч тухалж явах гэсэн мэт харагдах ажээ. Түүний дэргэд, Францын хатан хаан шиг үхэх нь гэж омог бардам яваа Атенайс, олныг ихэмсэг харцаар намжирдан, өвгөн Бротто юм мэддэг хүний байртай залуу бүсгүйн цагаахан хүзүүг шохоорхон байх зуураа амьдрал нь ингээд дууслаа гэдэгт хар бууж явлаа.

XXV

Броттог, хамсаатан нарын нь хамт цаазын газар хүргэж яваа тэрэг морьт цагдаа нараар хүрээлүүлэн «Хөмөрсөн хаан ширээний» талбайд дөхөж явахад Эварист, Тюильрийн цэцэрлэгт, бандан дээр бодол болон сууж байлаа. Тэрээр Элодийг хүлээн суугаа нь энэ ажээ. Наран баруунаа гудайж галт сацраг нь туулайн бөөр модны өтгөн навчсыг нэвглэн тусна. Цэцэрлэгийн торон хашааны харалдаа жигүүрт аргамаг хөлөглөсөн Алдар бүрээгээ зогсолтгүй татна. Сонин худалдагчид Флерюсын дэргэд хийсэн том ялалтын тухай сүүлчийн мэдээг хашхичиж байв.



«Гийм ээ, ялалт манай талд байна. Гэвч бид үүнийг их үнээр олж авсан юм» гэж Гамлен бодлогоширно.

Чадваргүй гэж яллагдан толгойгоо авхуулсан генералуудын сүүдэр Хувьсгалын талбай дээрх цус шингэсэн тоосон дунд харагдах шиг болно. Биелүүлэхэд нь биеэр оролцсон энэ хатуу арга хэмжээг аваагүй бол австричуудын морь энд модны холтос холтлон мэрж байх сан биз гэж бодохдоо тэр маасгархан инээмсэглэв.

«Аяа, алан хядлага, чи авралтай юм» алан хядлага чи ариун юм! Ноднин жил яг энэ үед хамгаалагчид маань ноорхой хувцастай ялагдсан баатрууд байлаа. Дайсан, эх орны минь хөрс шороог уландаа гишгэж, департаментын гуравны хоёрт нь бослого гарсан байж билээ. Одоо сайтар зэвсэглэсэн, сайтар сургуулилсан манай дайчид чадварлаг жанждын удирдлагын дор давшилтад орж хорвоо дэлхийд эрх чөлөөний үрийг тараахад бэлхэн байна... Бүгд Найрамдах Улсын нутаг дэвсгэр даяар энх төвшин цаг ирж байна... Аяа, алан хядлага, чи

авралтай юм, алан хядлага, чи ариун юм! Аяа, гильотина, чи үнэтэй цайтай юм! Ноднин жил яг энэ үед Бүгд Найрамдах Улсыг хуйвалдагсад тасчин хувааж, федерализмын хөндий хэвэлт могой золтой л залгичхаагүй билээ. Одоо нэгдэн нягтарсан якобинчид бүх улсад мэргэн засаг төрөө төвхнүүлэн тогтоож байна...” гэж сүүрс алдана.

Хэдий тийм боловч түүний царай баргар байлаа. Гүн атираа духанд нь гарч, завжинд нь зовлонгийн үрчлээ суужээ «Ялья. эсвэл үхье гэж бид ярьдаг байсан. Бид алджээ. Ялаад үхье гэж хэлэх хэрэгтэй байж» гэж тэр бодно.

Гамлен эргэн тойрноо харав. Хүүхдүүд элсээр наадацгаана. Эмэгтэйчүүл, юм оёх нь оёж, нэхэх нь нэхэн модон доорх сандал дээр суух ажээ. Фрак, хачин маягийн өмд өмссөн, ажил хэрэг, зугаа цэнгэл хөөцөлдөх дэгжин эрс гэртээ харьцгааж явна. Гамлен, тэдэнтэй эх орон нэгтэй ч биш, тэдний үеийн хүн ч биш болохоор тэнд ганцаардана. Юу гээч болчих нь энэ вэ? Урам зориг сэргээсэн сайхан цагийн халааг бүхнийг хайхрамжгүй болгон сульдаасан, магадгүй жигшлийг нь төрүүлэх болсон цөвүүн цаг яагаад авав аа? Хувьсгалт онц шүүхийн тухай эдгээр хүн ахиад сонсохыг илэрхийеэ үл хүсэн, гильотиныг харахаас дургүй нь хүрэх болжээ. Хувьсгалын талбай дээр босгосон гильотин, бүгдийн нүднээ тээр болон үзэгдэх болж, түүнийг хотын захад Антуаны талбайд нүүлгэж аваачсан. Гэтэл тэнд ч гэсэн гайт тэргийг харахдаа хүмүүс эгдүүцэн шуугилаа. Нэг удаа хэд хэдэн хүн «Боллоо» гэж хашхирсан гэлцэнэ.

Урвагчид, хуйвалдагсад байсаар байхад боллоо гэнэ ээ! Хороог шинэчлэн конвентыг цэвэрлэх хэрэгтэй байхад боллоо гэнэ ээ! Ард түмний төлөөлөгчдийн газрыг өөдгүй этгээдүүд гутааж байхад боллоо гэнэ ээ! Хувьсгалт онц шүүхэд хүртэл Үнэнчийг алахаар бодолхийлж байхад боллоо гэнэ ээ. Бодохоос аймаар юм. Гэвч яахын аргагүй тийм юм чинь. Фукье хүртэл хуйвалдаан байгуулж, Максимилианыг л хөнөөхийн тулд эцгээ алсан хүний адилаар улаан цамц өмсгөн цаазын газар хүргэсэн тавин долоон хүнээр түүнд тахил өргөлөө биш үү! Францчуудыг нийтэд нь гэнэт нэрвэсэн өрөвчхөн сэтгэл хаанаас бий болов? Тэгэхлээр Францын хайр энэрлийн тухай гуйж байхад нь хүсэл зоригийг нь сөрөн түүнийг аврахын тул чихээ бөглөж байгаад хядах хэрэгтэй юу? Халаг минь гэж үүнийг зурхайч зурж үзсэн юм, эх орон,

аврагчдадаа хараал хийжээ. Эх орон биднийг хараач, гагцхүү аврагдвал барав.

«Язгууртнууд, санхүүчид, сэтгүүлчид, яруу найрагчид, ямар нэг Лавуазье, Руше, Андре Шенье нарын зэрэг нэргүй хүмүүсийг алах нь бага хэрэг. Уулын намыг устгахаар зэхэгч, цусанд будсан гараа алтанд дүрэгч айхтар хүчит Фуше, Тальен, Ровер, Карьер, Бурдончуулыг дарах нь чухал. Улсаа, бүх дайснаас нь чөлөөлөх хэрэгтэй. Хэрвээ Гебер дийлсэн бол Конвентийг хөөн тарааж бүгд найрамдах улсыг хөлгүй гүн жалга руу өнхрүүлэх байсан, хэрвээ Демулин, Дантон нар дийлсэн бол Конвент ёс суртахууны талаар ялзран бүгд найрамдах улсаа язгууртнууд, биржийнхэн болон генералуудад тасчуулахаар өгөх байсан. Хэрвээ Тальеныхан, Фуше болон тонон дээрэмдэж цусанд ханасан энэ мангасууд ялсан бол Франц гэмт хэрэг, гутамшгийн далайд живэх байсан... Робеспьер, чи унтаж байна, гэтэл айж хилэгнэсэн харгисууд чамайг алан, эрх чөлөөг эгнэгт булшлахаар санаархаж байна. Кутон, Сен - Жюст нар хуйвалдагсдыг илчлэхээ юунд алгуурлана вэ?

Яалаа гэнэ ээ! Урьдын төр, харгис засаг жил тоолон дөрвөн мянган хүн шоронд хатаан, арван таван мянган хүн өлгөж, гурван мянгыг цовдлон хядаж засгаа бэхжүүлж байсан байхад Бүгд Найрамдах Улс өөрийн хүчин чадал, аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс хэдхэн зуун хүний толгойг авахаас хулгаж байна гэж үү? Бид цусанд хахаж цацавч эх орноо аварна...”

Хааш яаш хувцасласан, цонхийж цайсан Элодийг түүн дээр гүйж ирэхэд тэрээр ийм бодолд автсаар л байлаа.

— Эварист, чи юу хэлэх гээ вэ? Яагаад «Амур — зураачид» хөх тасалгаанд очсонгүй бил ээ? Яах гэж намайг нааш дуудав? гэвэл

— Чамаасаа үүрд хагацахын тулд гэлээ.

Бүсгүй, юу ч ойлгохгүй байна, солиотой юм шиг гэж бувтнав.

Залуу гараараа үл мэдэг дохин түүнийг зогсоогоод

— Элоди, би үүнээс хойш чиний хайр дурлалыг хүлээж авч чадахгүй нь ээ гэв.

— Болиоч дээ, Эварист минь болиоч!

Энд тэднийг хүн харж үгийг нь сонсож магад тул бүсгүй жаахан цаашилья гэлээ.

Гамлен хориод алхсанаа тун тайвнаар

— Би эх орондоо амь нас, нэр төрөө зориулсан билээ. Би гутамшигтайгаар үхэж бүгдийн үзэлд орсон нэрээс өөр юу ч чамд гэрээсэлж чадахгүй болох нь ээ... Бие биеэ хайрлах гэнэ ээ? Намайг хайрлаж болно гэж үү? Бид хайрлаж чадах юм гэж үү? хэмээн өгүүлэв.

Бүсгүй, галзуу юм гэж ахин хэлснээ түүнийг хайрладаг, хайрласаар байх болно гэж ятгаж гарлаа. Ийнхүү Элоди үнэн сэтгэлээсээ цогтойёо ярина. Гэвч, тэрээр, Гамлен шиг, түүнээс ч илүү залуугийн үг аргагүй үнэн болохыг ухамсарлан, мэдээжийн юмны эсрэг маргаж байна.

Гамлен үргэлжлүүлэн

— Би биеэ ердөө ч буруушаахгүй. Өнөө хүртэл ажиллаж байсан шигээ цаашид ч ажиллах байсан. Эх орныхоо төлөө би олноосоо хөндийрлөө. Би хараал идсэн. Би хүн төрөлхтнөөсөө тасран гарч хэзээ ч эргэж ирэхгүй. Үгүй ээ! Агуу их зорилтууд хараахан төгс биелэгдээгүй байна. Өршөөх ий? Хэлтрүүлэх ий? Тэгвэл урвагчид өршөөдөг үү? Хуйвалдагсад нигүүлсэнгүй юу? Манай армийн эгнээнд амиа өгвөл таарах залуус, цэвэр, сайхан, гэмгүй царай үзүүлэгч өвгөд хүүхэд, эмэгтэйчүүд, эх орноос тэрслэгчид, цаг ирэх тутам, газар дороос гараад ирэв үү дээ гэмээр олширч, зүг бүхнээс хуран цугларч байна. Тэднийг цаазлахаар оронд нь өөр улс бүр ч олон болчихоод гараад ирэх юм... Би амьдралын алив баясгалан, дурлал цэнгэл, амь наснаасаа хүртэл татгалзах ёстой болсныг чи сайн мэдэж байгаа гэв.

Тэгээд тэр дуугүй болов. Энгийн нэг цэнгэж байх угаас дуртай Элоди, зовлонт амрагийнхаа элгэнд тачаангуйн жаргаланг эдлэн байхдаа нүдэндээ цуст явдал үргэлж үзэгдэх болсныг сүүлийн үес нэг бус удаа түгшин бодох болжээ. Бүсгүй үг дуугарсангүй. Залуу хүүхний ам нээсэнгүйд Эварист зовлонгийн аяганаас ус уух мэт болов.

— Элоди, бид толгой эргэм хурдаар урагшаа тэмүүлж байгааг чи сайн харж байна. Ажил маань биднийг дарж байна. Бидний өдөр, бидний цаг он жилтэй тэнцэнэ ээ. Би мөдхөн зуу хүрнэ. Миний толгойг хар, амраг залуугийн толгой мөн үү? Дур лах гэнэ!

— Эварист, чи минь, чамайгаа би тавихгүй, би чамайг дураар чинь орхихгүй.

Энэ бол амь дүйсэн хэрэг байлаа. Үүнийг Эварист дууных нь өнгөөр мэдрэв. Бүсгүй ч өөрөө үүнийгээ мэдэв.

— Элоди чи намайг өөрийн үүрэгтээ үнэнч байсан, бодол минь үнэн, сэтгэл минь цагаахан байсан, нийгмийн ашиг тусын төлөө

гэдгээс өөр хүсэл эрмэлзэл надад байгаагүй намайг угийн өр нимгэнтэй, ялдам хүн байсан гэдгийг хэзээ нэгэн цагт хэлж зүрхлэх үү? «Тэр үүргээ гүйцэтгэсэн» гэж чи хэлэх үү? Үгүй ээ? Чи үүнийг хэлэхгүй. Би ч үүнийг гуйхгүй. Миний тухай дуртгал ор мөргүй арилаг. Алдар нэрээ би зөвхөн сэтгэлдээ хадгалж явна, гэтэл би амьтны шившиг болно. Хэрвээ чи надад сэтгэлтэй байсан бол миний тухай ганц үг бүү дурсаарай.

Энэ үед найм ес орчим насны жаап хүү цагариг тоглож яваад Гамлены өвдгийг гүйхээрээ ирээд мөргөчхөв.

Эварист түүний гарыг хурднаа шүүрэн авлаа.

— Жаал аа, чи эрх чөлөөтэй, аз жаргалтай хүн болж өснө, чи үүгээр жигшүүрт Гамленд ач хариулах ёстой болно. Чамайг аз жаргалтай байгаасай гэж хүссэндээ би ийм харгис байна. Чамайг сайн хүн болоосой гэж хүссэндээ би ийм хэрцгий байна. Бүх францчуудыг маргааш баярын нулимс асгаруулан тэврэлдээсэй гэсэндээ би хайр найргүй байна гэв.

Гамлен түүнийг цээжиндээ наан

— Жаал аа, чи эрийн цээнд хүрэхдээ аз жаргалаараа надад ач хариулах ёстой болно. Тэгэхдээ миний нэрийг дуулмагцаа чи харааж зүхэх болно гэв.

Тэгээд тэрээр хүүхдийг газар буулгасанд цаадах нь. өмнөөс нь яаран ирж явсан эхийнхээ зүг айн гүйчхэв.

Цагаан даавуу даашинзтай, гаднаас нь харвал сурвалжит байрын үзэсгэлэнт залуу эх хүүгээ ихэмсэг гэгч нь хөтлөн одов.

Гамлен нүдээ сүртэйгээр гялалзуулан Элоди тийш эргэж

— Би энэ хүүхдийг үнслээ, харин эхийг нь цаазын газар илгээж мэднэ гэж өгүүлэв.

Тэгээд тэр модны сүүдэр дагаж том том алхлан холдов.

Хэсэгхэн зуур Элоди хөдөлгөөнгүй газар ширтэн зогсов. Дараа нь гэнэт амрагийнхаа хойноос менада тэнгэр мэт үсээ намируулан ухасхийж, улангасан, тасчин хаях гэж байгаа адил түүнийг зууран бариад нулимсандаа хахаж цацан

— За яая гэх вэ, хонгор минь, гильотин руу очъё! Миний толгойг ч гэсэн ав гэж тушаа! хэмээн тэр хашхирлаа.

Тэгээд хутганы ир хүзүүнд нь хүрч байна гэж төсөөлөн бодоход гол нь хүйт даан гижиг нь хүрэх шиг болов.

XXVI

Термидорын наран цусан улаан туяа татуулсаар шингэв. Бодолд дарагдан хүрлийсэн Эварист, биеэ оторлогч Парисынхны зугаалгын газар үндэсний өмч болсон Марбефын цэцэрлэгээр хэрэн хэсэж явлаа. Тэнд жимсний ус уух нь ууж зайрмаг идэх нь идэж зогсоно. Тэнд бас морин цогио, залуу эх орончдын өргөхөд зориулсан туухай байх ажээ. Модон доор уранхай хувцас, хар малгайтай савояр жаал хөөрөгт цоор үлээн түүний хяхтнасан аялгуунд нэг зурам бүжиглэж байв. Нохой дагуулан яваа хөх фрак өмссөн, цэх нуруутай, будмал үстэй идэрхэн эр энэ хөдөөгийн хөгжмийг сонсохоор зогсов. Эварист Робеспьерыг танилаа. Тэрээр цонхийж тураад, царай нь догшин дүр орж духанд нь уй гашуудлын атираа суусныг Гамлен ажив.



«Хэчнээн хөдөлмөр, хэчнээн зүдүүр энэ магнайд тэмдгээ үлдээгээ вэ! Хүн төрөлхтний аз жаргалын төлөө ажиллах хэчнээн хүнд хүчир вэ! Тэр одоо юу бодож байгаа бол? Уулынхны хөөрөгт цоорын эгшиг түүний ажил төрлийг нь мартагнуулж байгаа болов уу? Үхэлтэй гэрээ хийснээ, өшөө бодох цаг хаяанд ирснийг бодож байгаа болов уу? Самуун дэгдээгчдийн дийлэнхээс болж Аюулаас хамгаалах хорооноос Кутон, Сен - Жюст гурвуулаа гарснаа одоо ялалт байгуулан эргэж очих арга сэдэж байгаа болов уу? Энэ юу ч үл мэдэгдэх царайны цаана ямар найдвар болгоомжлол халхлагдаж байна вэ?» гэж бодож байлаа.

Энэ зуур Максимилиан инээмсэглэн, төлөв, найрсаг дуугаар хүүхдээс, хөөрхий түүний орхиж гарсан төрөлх нутаг, гэр орон, эцэг

эхийнх нь тухай асуугаад жижиг мөнгөн зоос чулуудан цааш явав.

Хэд алхсанаа тэрээр эргэн мэрэгчийн үнэр авсан нохойгоо хэдэрлэсэн зурам руу харан архиран байхад нь

— Браунт! Браунт гэж дуудлаа.

Тэгээд гудамжны бүрэнхий дундуур алсав.

Хүндэтгэхийн улмаас Гамлен түүний ганцаар явахад нь саад хийхийг хүссэнгүй. Гэвч харанхуйн дунд замхарч буй нарийхан бөртөлзөх барааг ажиглан дотроо түүнд ингэж хэлэв

«Би чиний уйтгар гунигийг үзлээ, Максимилиан би чиний бодлыг ойлголоо. Уй гашуут, алжаал ядрал, тэр ч атугай нүдэнд чинь илрэх айдас хүртэл, ер нь бүх юм чинь «Алан хядлага зогсож, ахан дүүсэг ёс тогтог! Францчууд аа нэгдэн нягтар, хатан зориг баригтун, сайхан сэтгэлтэй байцгаа, бие биеэ хайрла! гэж өгүүлж байна. За яах вэ! Чамайг санаа бодлоо биелүүлэхэд би тусална. Иргэний хагарал бутралыг дуусгавар болгож, бие биеэ үхтэл үзэн ялдагийг болиулж, зандалчныг хүний толгой биш байцаа, хяргаж байдаг ногоочин болгон хувиргахад чинь цэцэн энэрэнгүй чамд хамжилцахын тулд Онц шүүхийнхээ нөхдийн хамт хуйвалдагч урвагчдыг устган энэрэнгүйн үзэлд замыг нь нээж өгье. Сэрэмж, харгислал хоёрыг хувь илүү дээшлүүлье. Ганц ч гэмтэн биднээс мултрахгүй ээ. Бүгд найрамдах улсын эцсийн дайсны толгой өнхрөхөд л сая чи гэмт хэрэг үйлдэлгүй нинжин сэтгэл гаргаж болно. Францад гэмт хэрэггүй, ач буяны ноёрхлыг тогтоож чадна, ай эх орны минь эцэг!»

Үл хахуульддуулагч хэдийнээ холджээ. Дугуй бүрх, нанх өмдтэй хоёр хүн түүнтэй замын тойруу дээр дайралдсаны нэг нь Тальентай төстэй, хараажийн догшин, өндөр, туранхай, цагаан нүдтэй агаад тэд түүнийг хяламхийн харснаа таниагүй дүр үзүүлэн цааш өнгөрөв. Нэлээд зайдуухан очоод үгээ хэн ч дуулахгүйд итгэмэгц:

— Манай ван, манай эцэг, манай бурхан энэ дээ. Аа Екатерина Тео бол түүний төлгөч нь байгаа юм гэв.

— Дарангуйлагч, урвагч харгис хаан! Чамайг цааш харуулах Брута шиг хүн олдоно оо гайгүй.

— Бузар хог тэгж л бай!

Тарпейн хад Капитолигоос холгүй ээ гэж шивнэлдэв.

Браунт тэдэнд дөхөж очив. Тэд дуугаа хураан шуурхайлан алхав.

XXVII

Робеспьер, чи унтаж байна. Цаг, эрдэнэ мэт цаг өнгөрч байна...

Тэгж тэгж термидорын найманд, Конвентод, үл хахуульдүүлэгч босон ярих гэлээ. Таван сарын гучин нэгний наран дахиад мандах нь энэ үү? Гамлен хүлээн горьдсоор л байлаа. Федералчуудаас ч ял ихтэй, Дантоноос ч аюултай хууль тогтоогчдыг бузарласан сандлаас нь Робеспьер ашид хөөнө... Үгүй ээ одоо биш!

«Хууль зүйн гүн нууцыг халхалж байгаа хөшгийг бүрэн ураад хаячхаж би зүрхлэхгүй байна» гэж тэр ярина. Агаарт сарних цахилгаан хуйвалдагсдын хэнийг ч ниргэлгүйгээр тэднийг бүгдийг чичрүүлнэ. Тэдний жараад хүн нь хоёр долоо хоног гэртээ хонож зүрхэлсэнгүй. Марат бол урвагчдын нэрийг цохон хуруугаараа чичилж байсан. Гэтэл үл хахуульдагдагч эргэлзэж байна, ингэхлээр энэ агшнаас хойш тэр бурууджээ.



Орон нь якобинчуудын клубийн танхим, гудам, хашаагаар л нэг хүмүүс цугларан учир зүггүй чихэлдэн бужигнаж байлаа.

Амтай нөхөд, дуугүй дайснууд энд цөм байв. Конвентынхан таг чимээгүй сонссон нөгөө л үгээ Робеспьерыг хэлэхэд якобинчууд алга нижигнүүлэн ташна.

— Энэ бол миний гэрээс. Өчүүхэн ч чичрэхгүй аяга сорьслог уухыг минь та нар харах болно гэж түүний өгүүлэхэд Давид

— Бид ч бас тантай хамт ууна гэж хариулав.

— Бид цөм, бид цөмөөрөө ууна! гэж якобинчууд хашхиралдан шийдсэн юмгүй тарцгаалаа.

Дайснууд, Үнэнчийг алахаар бэлтгэж байх үед Эварист Тослогийн цэцэрлэгт христагийн шавийн бөх нойроор нойрсож байлаа. Өглөө нь тэрээр, секцүүдийн хуралдаж байсан Онц шүүх рүү явав. Түүний очсон секцэд Сен - Лазарын шоронд гарсан хуйвалдааны хэргийг байцаан үзэж байлаа. Гэтэл яг энэ үед «Зургаан цаг хуралдсаны эцэст Конвент нь Максимилиан Робеспьер, Кутон, Сен - Жюст мөн түүнчлэн

ялтангуудын хувь тавилангаас хуваалцахыг хүссэн Огюстен Робеспьер, Леба нарыг хариуцлагад татахаар тогтоол гаргасан. Тавуулыг баривчлан хорилоо» гэсэн цуу тархав.

Мөн зэргэлдээ танхимд байрладаг секцийн дарга иргэн Дюмаг албан үүргээ гүйцэтгэж байхад нь баривчилсан боловч хуралдаан нь үргэлжилж байгаа нь мэдэгдэв. Цугларах бүрээ татан түгшүүрийн хонх дэлдэх нь сонстоно.

Ардын төлөөлөгчийн суудалдаа сууж байхад нь Гамленд хотын захиргаа руу Ерөнхий Зөвлөлийн хуралд очих тушаал гардуулав. Хонхны дуу бөмбөрийн нижигнээн дунд тэрээр нөхдийн хамт ялын тогтоол гаргаснаа, гэртээ харьж эхтэйгээ уулзах, гурван өнгийн уяагаа уяхаар гүйлээ. Тионвиллийн талбай эл хуль байв. Секцүүд Конвентын төлөө ч, түүний эсрэг ч санал өгөхөөс түдгэлзэнэ. Зорчигсод, хананд айн наалдаж хаалгаараа гүйлдэн орж гэртээ бушуухан орохыг хичээнэ. Хонхны дуу, бөмбөрийн нижигнээнтэй тасхийн хаагдах цонхны хаалт, хар яр хийх цүү цуургын чимээ хөг нийлүүлнэ. Ахмад Дюпон дархныхаа газарт нуугдаж, хаалгач Ремакль шовгортоо орж үүдийг нь цоожлов. Жаал Жозефина айн Мутоныг тэвэрнэ. Бэлэвсэн авгай Гамлен бүх гамшгийн шалтгаан бол идэш ууш үнэтэйд л байна гэж сүүрс алдана. Шатны доод чөлөөнд Эварист Элодитэй халз тулгарав. Бүсгүй амьсгаадан мушгиа хар үс нь хөлөрсөн хүзүүнд нь наалджээ.

— Би чамайг Онц шүүхээр эрлээ. Саяхан тэндээс явчихсан байна. Чи хаачих нь вэ?

— Захиргаа хүрье.

— Тийшээ бүү яв! Биеэ хөнөөнө гэсэн үг. Анрио баригдсан... Секцүүд яахаа ч мэдэхгүй байна. Пикийн секц Робеспьерын тулгуур л нам тайван байгаа. Би мэдэж байна, эцэг минь түүний гишүүн шүү дээ. Хэрвээ чи захиргаа руу очвол хий дэмий биеэ хөнөөнө гэлээ.

— Чи намайг хулчийгаасай гэж бодож байна уу?

— Үгүй чиш, одоо эрэлхэг зориг Конвентэд үнэнч байх, хуульд захирагдахад л оршиж байна.

— Хэрвээ үл бүтэх этгээдүүд дийлж байгаа бол хууль устсан хэрэг.

— Эварист Элодийнхоо үгийг сонс, эгчийнхээ үгийг сонс.

Үймэрсэн сэтгэлээ тайтгаруулахаар дэргэд минь суу.

Эварист түүнийг харахад бүсгүй түүнд хэзээ ч тийм хүслэнтэй санагдаж байсангүй, хэзээ ч түүний дуу тийм янаг, итгэлтэй сонстож байсангүй.

— Хайрт минь, хоёр алхам, хоёрхон алхам!

Бүсгүй, онхолдуулсан хөшөөний суурь байгаа зүлэгт дэнж дээр түүнийг хөтлөн аваачив. Гоёсон харчуул хүүхнүүд эргэн тойрны сандал дүүрэн суужээ. Жижиг бараа худалдаалагч эхнэр тор худалдаж аваач гэнэ. Лонх үүрсэн эмийн ханд зардаг хүн хонх жингэнүүлэн, охид цагариг тоглоцгоож байлаа. Налуу эрэг дээр загасчид гартаа дэгээ барин хөдөлгөөнгүй сууцгаана. Тэнгэр бүрхэг, салхи үлээнэ. Эргийн хашлагыг түшин, хөлөг онгоцны хошуу адил нарийхан арлыг ширтэн, моддын орой салхинаа ёолох мэт исгэрэхийг чагнан байхад нь хөл үймээнээс хол амар тайван суух сан гэдэг хүсэл Гамлены сэтгэлд оргилон ирэв.

Элодийн намуухан дуу түүний бодсон бодлыг нь чихнээ чимэгт нэгэн дуулиа лугаа адил дэргэд нь хангинав.

Хээр талыг хараад чи ямар нэгэн тосгонд энгийн шүүгч болон суух юм сан гэж байснаа санана уу? Энэ бол жаргал байх байсан шүү.

Гэвч моддын сэрчигнээн болон бүсгүйн дууг даран хонхны дуу бөмбөрийн нижигнээн, морьдын бүдэг төвөргөөн, засмал замаар явах их бууны түрчигнээн сонстоно.

Түүнээс хоёр алхмын зайтай нэгэн үзэсгэлэнт эмэгтэйтэй ярилцаж байсан залуу эр

— Сүүлчийн сонин мэдэж байна уу?

Дуурийг, хуулийн гудамжнаа нүүлгэн аваачсан шүү дээ гэв.

Гэвч бүх юм тодорхой болжээ. Робеспьерын нэр хүмүүсийн зүрхийг үхүүлсээр байсан учир тун болгоомжтой шивнэлдэн ярилцана. Хүүхнүүд түүний унасан тухай ам амандаа эмээсэн байртай ам дамжуулан ярилцаж инээдээ барина.

Эварист Гамлен, Элодийн гарыг шүүрэн авснаа дор нь тавиад

— Хагацъя! Би чамайг аймшигт хувь заяандаа орооцолдууллаа, чиний амьдралыг үүрд баллачихлаа. Хагацъя! Намайг мартахыг бодоорой!

Өнөө шөнө гэртээ очиж болохгүй шүү. «Амур - зураачид» оч. Хонх бүү дараарай, цонхны хаалт руу жижиг чулуу шидээрэй. Би чамд өөрөө хаалга тайлж өгөөд дээврийн хонгилд нуумз.

— Нэг бол ялалт байгуулаад буцаж ирнэ, нэг бол хэзээ ч ирэхгүй. Хагацъя!

Захиргаа руу дөхөж явахдаа Гамлен агуу их өдрүүдийнх аятай нүргээн тэнгэр тулам хадаж байгааг сонсов. Гревийн талбайд зэр

зэвсэг хангир янгир хийн, гурван өнгийн тууз алаглан Анриогийн их бууг дайны журмаар эгнүүлсэн байлаа. Тэрээр ёслолын шатаар өгсөж зөвлөлийн танхимын хаалганы дэргэдэх хуудсан дээр гарын үсгээ зурав. Коммуны Ерөнхий зөвлөлийн дөрвөн зуун ерэн нэгэн гишүүн хэрэгтнүүдэд ашигтайгаар нэгэн дуугаар саналаа хэлэв.

Хүний эрхийн маягт авчрах захирамжийг Мэр өгч «Хэрвээ засгийн газар, ардын эрхийг хөсөрдүүлбэл бослого нь ард түмний ариунаас ариун, чухлаас чухал үүрэг болно» гэсэн зүйлийг дуудан уншив. Конвентын хийсэн төрийн эргэлтэд коммун ард түмний бослогыг сөргүүлэн тавьж байна гэж Парисын гол албаны хүн мэдэгдлээ.

Ерөнхий зөвлөлийн гишүүд байрандаа байсан чигээр үхэх тангараг өргөжээ. Гревийн талбайд очиж ард түмнийг эх орон, эрх чөлөөгөө аврах зорилгоор коммунтай нэгдэхийг уриалах даалгавар засаг захиргааны хоёр офицерт өгчээ.

Бие биеэ эрэн, сонин сайхныг харилцан ярилцаж зөвлөгөө өгнө. Энд хотын захиргааны түшмэдийн дунд гар урчуул цөөхөн байв. Хувьсгалт онц шүүхийн шүүгч ардын төлөөлөгч Бовале, Гамлен мэтийн зураачид, хөрөнгөтөн, профессор, бэлтэй борчуул, будмал хиймэл үстэй, гэдэс дээрээ энгэрийн цагны оосор унжуулсан том худалдаачид зэрэг коммуны яacobинчуудын цэвэрлэгээнээс үлдсэн гишүүд энд цугларсан бөгөөд модон чархи өргөн өмд, хүрэм, улаан малгай өмссөн хүн бараг үл үзэгдэнэ. Энэ, энэ хөрөнгөтнүүд олуулаа. Тэд бултаараа эцсээ хүртэл тэмцэхэд бэлхэн ажээ. Гэвч үнэндээ Парис дахь жинхэнэ эх орончид тэднээр бараг шавхагдаж байлаа. Тэд амарлингуйн далайгаар зүг бүхнээсээ хүрээлэгдэж, эрх чөлөөний цохио хад гэлтэй захиргаан дээр шавжээ.

Энэ зуур аятайхан мэдээ ирж байлаа. Шоронг нээн ялтангуудыг суллан тавьж байв. Форсоос ирсэн Огюстен Робеспьерыг хамгийн түрүүн захиргаанд ирэхэд алга ташин угтав. Максимилиан тээнэгэлзэж тээнэгэлзэж мөн л коммунд ирэхээр шийдсэн гэдгийг найман цагт мэдэцгээв. Түүнийг хүлээнэ, тэр одоохон ирэх ёстой, тэр орж ирлээ. Алга нижигнэтэл ташихад хуучны засаг захиргааны байшингийн хүнхэр адар доргиж байв. Түүнийг баяр ёслолын байдалтайгаар өргөн явлаа. Энэхүү хөх фрак, шар өмд өмссөн турьгүй хэр нь ээ нүд дүүрэн хүн бол тэр мөн ажээ. Тэрээр байраа эзлэн ярьж эхлэв.

Түүнийг босго алхаж завдаагүй байхад нь Ерөнхий зөвлөл захиргааны байшинг гэрлээр чимэглэхийг тушаав. Тэр байшинд бүгд найрамдах улс тэр чигээрээ багтаж байлаа. Тэрээр үг болгоноо цэгнэн өндөр дуугаар ярьсаар байв. Энэ цугларагсад түүний төлөө амиа өгөхөд бэлэн байгсад, хороонд болон индэр дээрээс илтгэж чаддаг энэ чалчаа хувьсгалт алхам хийж, түргэн шийдвэр гаргаж чаддаггүй юм байна гэдгийг нь сэтгэл өвдөн ажиглав.

Түүнийг зөвлөгөөний танхимд аваачив. Энэ алдарт гэмт хэрэгтнүүд Лебо, Сен - Жюст, Кутон нар цөмөөрөө цуглалаа. Робеспьер яриад л байлаа. Шөнийн арван хоёр цаг хагас болсон боловч тэр ярьсаар л байв. Энэ завсар зөвлөлийн танхимд Гамлен цонхонд нүүрээ наан харанхуйг гунигтайяа ширтэж, шөнийн харанхуйд дэн хэншүү тортог гарган асахыг харна. Анриогийн их буунууд захиргааны байшингийн өмнө жигдэрлээ. Пад харанхуйд талбай дээр яахыгаа мэдэхээ больж түгшсэн олон үймэлдэнэ. Арван хоёр цаг хагаст Ванри гудамжны булангаас бамбар үзэгдэн сүр жавхланг илтгэгч, Конвентын төлөөлөгч хүрч ирлээ. Бамбарын улаан гэрэлд тэрээр цаасаа эргүүлэн, үймээнт Коммуны гишүүд, мөн тэдэнтэй санал нэгтэй ажиллагч Ерөнхий зөвлөлийн гишүүд, түүний уриаг хүлээн авагч бүх иргэнийг хууль бус хэмээн тунхагласан Конвентын тогтоолыг уншив.

Хууль бусын тунхаглал, шүүх ажиллагаа, мөрдөн байцаалтгүй цааз! Энэ тухай дөнгөж бодмогц л хамгийн шийдвэр төгс улсын царай хувхай цайна. Духандаа хүйтэн хөлс дааварлахыг Гамлен мэдэв. Гревийн талбайгаас сандран одож байгаа хүмүүсийг тэрээр харна.

Гамлен эргэн харвал саяхан хөл гишгэх ч зайгүй байсан танхим хүнгүй шахам болжээ.

Гэвч Ерөнхий зөвлөлийн эл гишүүд зугтсан нь дэмий болжээ. Тэд гарынхаа үсгийг зурсан юм чинь мэдэгдэлгүй яах билээ.

Шөнийн хоёр цаг болж байв. Хажуугийн өрөөнд коммун болон хууль бусын гэж зарлагдсан засаг захиргааны түшмэдтэй үл хахуульдагдагч зөвлөлдөнө.

Гамлен горь тасарсан харцаар харанхуй талбайг ширтэнэ. Дэнлүүний гэрэлд хүнсний барааны худалдагчийн мухлагийн хажуугийн саравч дээрх тулгуур моднууд тун тан хийтэл мөргөлдөхийг тэр ажна. Хүчит салхин хөдөлж дэнлүү савлан анивчина. Хэсэг азнасны дараа аадар бороо асгасанд талбай бүрэн эзгүйрч, аймшигт тогтоолын хөөж чадаагүй хүмүүсийг усны хэдхэн

дусал зугтаалгах нь тэр ажээ. Анриогийн их буунуудыг заяа нь мэдэг гээд хаячихсан байлаа. Гялалзан цахих гялбааны гэрэлд Конвентын цэрэг мөрний эрэг Антуаны гудамжнаас нэгэн зэрэг гарч ирэхэд захиргааны үүдэнд амьтай амьтан алга болсон байлаа.

Эцсийн эцэст Максимилиан, Конвентын эсрэг Пикийн секцээс тусламж гуйхаар шийдэв.

Ерөнхий зөвлөл, сэлэм, гар буу, бууг тийш нь аваачихыг тушаалаа. Гэтэл буу зэвсгийн хан ян хийх, тов тов гүйлдэх, шил хангинан хагарах дуун барилгаар нэг түглээ. Конвентын цэргүүд зөвлөгөөний танхимаар үерийн ус мэт шуугин өнгөрч Зөвлөлийн танхим руу тэмүүлцгээв. Буу дуугаран эрүүгээ яйр буудуулсан Робеспьерыг ойчихыг Гамлен үзэв. Эварист, тонгорог буюу өлсгөлөнгийн өдрүүдэд хөөрхий эхэд талх зүсэн өгч байсан тэр хямдхан хутгаа Оранжийн гацаан дахь сайхан үдэш дэнчин тавьж тоглон ахуйд Элодийн өвдөг дээр хэвтэж байсан тэр тонгоргоо шүүрэн авч тэнийлгэн зүрх рүүгээ шаасан боловч үзүүрт нь хавирга нь тааралдаж туялзан хоёр хуруугаа эсгэв. Гамлен цусаа урсган уналаа. Тэрээр аймшигт тулааны шуугиан үймээн дунд хүний хөлд гишгэлэгдэн хөдөлгөөнгүй хэвтэж ясандаа янгинатал дааран байхдаа залуу дайчин Анрийн

— Эзэн хаан хэдийнээ үхлээ. Түүнийг дагалдагчид бут цохигдлоо. Хувьсгал өөрийн жавхланта сүрлэг замаараа явах болно гэх дууг тодхон сонсов.

Гамлен ухаан балартлаа.

Өглөөний долоон цагт Конвентээс явуулсан мэс засалч түүний шархыг боов. Гильонтиноос нэгийг ч алдахгүйн тул Конвент, Робеспьерын хамсаатнуудад тун их анхаарал тавьж байлаа. Ардын төлөөлөгч коммуны ерөнхий зөвлөлийн гишүүн байсан зураачийг дамнуургаар Консьержерт хүргүүлэв.

XXVIII

Термидорын арванд шоронгийн орон дээр Эваристыг өгүүлэхийн аргагүй айн сэрэхэд үлэмжийн том бөгөөд үзэсгэлэнт сайхан Парис наран зүг баясгалантайяа мишээж, хоригдлуудын сэтгэлд горьдлого төрөн, наймаачид мухлагаа баяртай гэгч нь нээн хөрөнгөтнүүд биесээ улам ч баян, залуус улам ч жаргалтай, хүүхнүүд улам ч хөөрхөн болсон мэт санаж байгаа нь Робеспьерын унасны ач гэнэ ээ. Хуруу дарам цөөхөн яacobинчид, үндсэн хуульд андгай өргөсөн хэдхэн тооны лам нар болон хэсэг эмгэд, засгийн эрх муу бөгөөд даамай хүмүүсийн гарт орлоо гэж бодохдоо эмээн чичирч байлаа. Хувьсгалт онц шүүх, хуйвалдааныг тас цохисонтой холбогдуулан баяр хүргэж олон нийтийн яллагч, хоёр шүүгчийн бүрэлдэхүүнтэй төлөөлөгчийг Конвентод илгээв. Хурлаас цаазын индрийг ахин хувьсгалын талбай дээр босгох тогтоол гаргалаа. Мөн баячуул, гангачуул, үзэсгэлэнт хүүхнүүдэд тэр өдөр Робеспьерыг хэрхэн цаазлахыг тухтай харуулахыг хурал хүсэж байв. Дарангуйлан захирагч ба түүний аялдан дагалдагсдыг хууль бусын гэж зарласан хийгээд Онц шүүхээс тэднийг зандалчны гарт даруйхан шилжүүлэхийн тулд хоёр засаг захиргааны офицер л биеийн тодорхойлолтыг өгөхөд хангалттай байлаа. Гэтэл санаандгүй саад учрав. Бүх Коммун хууль бус гэж зарлагдсаны улмаас жинхэнэ хуулиас шаардах зүй ёсоор биеийг тодорхойлно гэдэг байж болшгүй зүйл билээ. Иймийн тул гэмт хэрэгтнүүдийн биеийн тодорхойлолтыг ердийн гэрч нараар тодорхойлуулах зөвшөөрлийг хурал Онц шүүхэд олгожээ.



Хэлэлцээ хийгч гурав болон тэдний гол хамсаатнуудыг баясан хөхисөн, уурлан хилэгнэсэн, харааж зүхсэн, инээж хөхрөлдсөн, бүжиг наадам болсон олны дундуур чирч гулдран цаазын тавцан тийш аваачлаа.

Маргааш нь тэнхрэн хөл дээрээ арай ядан тогтож байгаа Эваристыг өрөөнөөс нь гарган Онц шүүхэд хүргэж өөрөөс нь өмнө алдартай алдаргүй өдий төдий хэлмэгдэгсдийн сууж байсан тэр дэвсгэр дээр суулгалаа. Энд сууж шийтгэгдсэн хүмүүсийг тэр нэг бус удаа харсан билээ. Одоо тавцан далан хүний хөл дор чахрах агаад эдний ихэнх нь Коммуны гишүүд, зарим нь Гамлен шиг хууль бусын гэж зарлагдсан ардын төлөөлөгчид байлаа. Тэрээр түшлэгийг нь ихэнхдээ налан суудаг байсан сандлаа, золгүй хүмүүсийг айлгаж бэмбэгэнүүлэн сууж агсан газраа, Жак Мобель, Фортюне Шассань, Морис Броттогийн харц, хичээл зүтгэлээр нь ардын төлөөлөгчөөр томилогдоод сүүлд нь алах ял зааж ачийг нь хариулсан Рошмор хатагтайн өршөөл гуйсан харцыг тэсэн өнгөрөөж байсан суудлаа харлаа. Шүүгч нарын суудаг час улаан утрехт хилэн бүрээстэй гурван ум зандан сандал тавьсан өндөрлөг дээр Шалье, Марат, нэрийг нь нэг бус удаа дуудаж байсан Брутагийн баримал байхыг Гамлен үзэв. Алман сүх ч, бараа бологчийн бургасны баглаа ч, туурганаа наасан цаасан дээрх улаан малгай ч «нэхмэлчдийн» үхлээ хүлээгчдийг даажин тохуу хийдэг нь ч хүний амийг бүрэлгэгч бичиг баримтыг хичээнгүйлэн уудалж байдаг зөрүүд ажилсаг шударга шүүгч хүний

ёсоор өчигдрийнхөө найз нарыг цаазын газрын илгээгч Фукье Тенвиллийн сэтгэл аль аль нь өөрчлөгдсөнгүй ээ.

Хаалгач, оёдолчин иргэн Ремакль, Тионвиллийн талбайн мужаан Шинэ гүүр секцийн Ажиглах хорооны гишүүн ахмад Дюпон хоёр, зураач Хувьсгалт онц шүүхийн ардын төлөөлөгч, коммуны ерөнхий зөвлөлийн гишүүн байсан Гамлены (Эваристын) биеийг тодорхойлов. Тэд секцээс төлсөн зуун сугийн цаасан тэмдэгтийн шантайгаар гэрчилж буй ажээ. Гэвч Гамлентай дотно хөрш түүгээр барахгүй нөхөрсөг харьцаатай байсан тул түүний улаан нүүрийг харахад ичгэвтэр байлаа. Түүнээс гадна халуун байсан учир тэдний ам ангаж, нэг нэг аяга дарс уухаар явахын түүс болно.

Гамлен цус их алдаж, шарх нь янгинан өвдөх учир тэргэн дээр арайхийн гарав.

Дэлбэгч ясан хэдрэг морио гуядаж алмайран бөөгнөрч элэг доог хийгчдийн дундуур хөдөллөө.

Гамленыг таньсан эмэгтэйчүүл

Цус сорогч, зам чинь энэ! Өдрийн арван найман франкийн хөлстэй алуурч! Одоо инээхгүй байна, царай нь яаж цонхийгоо вэ, хараач... зүрхээ зүсүүлсэн хог гэж бархиралдаж байв.

Эд бол сав саяхан Гамлен болон түүний нөхдийн цаазын газар илгээж байсан хуйвалдагсад, язгууртнууд, хэтэрхийлэгчид болон дундыг баригчдыг цөмийг нь хараан зүхэж байсан тэр хүүхнүүд ажээ.

Тэрэг Морфондын хөвөө рүү эргээд Шинэ гүүрээр гарч зоосны гудамжаар аяархан гэлдрэх бөгөөд зам Хувьсгалын талбай руу, Робеспьерыг цаазалсан газар тийш хөтлөн явна. Морь доголж дэлбэгч ташуураараа толгойг нь тасралтгүй ороолгоно. Баярлан хөгжсөн сониуч олон харгалзагчдын явдлыг удаашруулав. Мориныхоо амыг татах цагдаа нартай тэд мэнд зөрнө. Оноре гудамжны өнцөг дээр ирээд доромжлол хувь илүү нэмэгдлээ. Гоёмсог рестораны хоёр давхрын танхимуудад сууж байсан залуус гартаа ам арчих цаасаа барьсан чигээрээ цонхон дээр шавжээ.

— Каннибалууд! Махчид! Цус сорогчид гэж тэд хашхиралдана.

Бүх нийтээрээ үймсэн энэ хоёр өдөр цэвэрлээгүй угаадсанд тэрэг шигдсэнд сээхэлзүүр залуус хөөрөн баясаж

— Тэрэг нь шивхэд шигдлээ! Якобинчуудаа, байр чинь энэ дээ гэлцэв.

Гамлен бодолд автан, цөмийг нь ойлгож байгаа мэт санагдана.

«Би үхвэл зохих хүн мөн. Биднээр дайруулан бүгд найрамдах улсыг харааж зүхэж байгааг бид бүгдээрээ шударгаар тэвчинэ. Уг нь тэр хараал зүхлээс улсаа хамгаалах ёстой байсан юм. Бид сул ажилласан. Өршөөл энэрлээр бид нүгэл үйлдсэн. Бид бүгд найрамдах улсаасаа урвасан. Бид санасандаа хүрлээ. Робеспьер, ямар ч өөгүй шударга Робеспьер ч гэсэн номхон энэрэнгүй сэтгэл гаргасан буруутай, тэгээд энэ алдаагаа зовлонгоороо цагаатгасан. Түүн шиг би ч бас бүгд найрамдах улсаасаа урвасан. Бүгд найрамдах улс маань мөхөж байна, шударга ёс, намайг түүнтэй хамт үхэхийг шаардаж байна. Би бусдын цусыг хайрласан, тэгэхлээр өөрийн минь цус урсаг! Би үхье! Би ингэх ёстой...” гэж бодов.

Ийнхүү бодлогошрон явтлаа тэрээр гэнэт «Амур - зураачийн» хаягийг олж үзлээ. Уйтгартай амттайхан дуртгалууд сэтгэлд нь үерийн урсгал мэт халгин орж ирэв. Мухлагийг цоожилж, хоёрдугаар давхрын гурван цонхны хаалтыг цөмийг нь доош буулгасан байна. Зүүн талын цонхны доогуур хөх тасалгааны цонхны доогуур тэрэг өнгөрөх үед ядам хуруундаа бөгжтэй эмэгтэй хүний гар хаалтыг үл мэдэг сөхөн түүн тийш улаан лиш цэцэг чулуудсанд Гамлены гар нь ардаа хүлээстэйн улмаас барьж авч чадсангүй боловч энэ нь түүний уруулыг өчнөөн удаа сэрүү татуулж байсан тансаг үнэрт ув улаан уруулын дүр зураг бэлгэ тэмдэг байсан болохоор цоо ширтлээ. Ийнхүү эцсийн удаа мэнд хүргэсэнд бүх бие сэтгэл нь догдолсон тэрээр нүдэндээ нулимс мэлтэлзүүлэн Хувьсгалын талбайд хурсан олон дээгүүр гялалзан байгаа цус болсон хутгыг харж билээ.

XXIX

Сэрүү орж Сена мөрөн хэдийнээ мөстөж эхэлсэн байлаа. Тюильрийн усан сан, горхи, усан оргилуур хөлдлөө. Умрын салхи гудамнаа цасан хуй маналзуулан босгоно. Морьдын хамраас цагаан уур савсана. Хотын иргэд, галт шилчдийн мухлагийн дэргэдүүр өнгөрөхдөө халуун хүйтний хэмжүүрийг харна. Даамал «Амур - зураачийн» цан хүүрэг болсон цонхыг арчиж, цусыг нь уухын тул хүний зүрхийг нимбэг лүгээ адил аяганд шахаж байгаа Робеспьер, мөн Франц руу хааныг явуулсан хөндий хэвэлт могой, аймшигт мангасыг багширч байгаагаар дүрсэлсэн «Робеспьерын яргалал» мэтийн том ёгт зураг бүхий шинэ маягийн хэвийг үзэхээр сониучхон улс зогсосхийнэ. Мөн тэнд «Робеспьерын аймшигт хуйвалдаан», «Робеспьерыг барьсан нь», «Робеспьерын үхэл» зэрэг зураг тавьжээ.



Тэр өдөр үдээс хойш хавтас сугавчилсан Филипп Деман Жан Блезийн мухлагт орж очлоо. Тэрээр Жан Блезэд «Робеспьерын амиа хорлосон нь» гэдэг зураасан барын самбар авчирчээ. Барлагч цүүцээрээ Робеспьерыг болохуйц хэмжээгээр нь жигшил хүрэм ёжтой шог дүрсэлжээ. Одоо хувьсгалын бүхий л гэмт хэрэг тохогдож буй хүний аймшигт бузар үйлийг мөнхжүүлэхийг оролдогч тиймэрхүү бүтээлд Францын ард түмэн ханаж хараахан амжаагүй байлаа. Гэвч олон түмнийг сайн мэддэг хэвийн худалдаачин, Деманд үүнээс хойш зөвхөн дайны сэдвээр л захиалга өгч байх болно гэж сануулжээ.

— Бидэнд ялалт, ололт, сэлэм, соновтор, генералууд хэрэг болно. Бид яруу алдрын замд орлоо. Үүнийг би өөрөөсөө мэдэж байна. Манай ялгуусан армийн гавьяаны тухай ярихад зүрх минь хүчтэйгээ булгилдаг

болж. Надад ямар нэгэн сэтгэл төрөхөд бултад надтай адил нэг зэрэг тийм сэтгэл төрөхгүй байх нь ховор. Дайчид, эмэгтэйчүүд, ангараг, цолмон л бидэнд хэрэгтэй.

— Иргэн Блез, барлуулахаар таны өгсөн Гамлены зурсан хоёр гурван зураг надад үлдсэн юм сан. Түүнийг яаравчлан дуусгахын хэрэг бий юу?

— Ямар ч хэрэг байхгүй.

— Ялдамд хэлэхэд өчигдөр Тамплийн цэцэрлэгт гудамжаар явж байтлаа Бомаршегийн байшингийн яг өмнө талд нь орших нэгэн хуучин юм зардаг мухлагт хөөрхий Гамлены бүх зураг, мөн «Орест, Электра хоёр» нь байхыг үзэв шүү. Гамлентай төстэй Орестын толгой хачин сайхан, толгой мөр нь даанч гоё гарсан... гэдгийг танд баталъя... Хуучин юм худалдаалагч, дээр нь өөрийн бүтээлээ туурвих зураачдад энэ даавуунуудыг худалдана... гэж надад хэлсэн. Хөөрхий Гамлен! Хэрвээ улс төрийн бодлогоор хөөцөлдөөгүй бол тэргүүн зэргийн уран зураач, гарах байсан юм даа.

— Тэр чинь заяаны цусан гартай хүн. Түүнийг цусанд шунах хүслээ зоргод нь тавиагүй байхад нь яг энд би орой руу нь ортол хэлж өгсөн юм. Ингэлээ гэж намайг үзэж чаддаггүй байж билээ... Яа яа яа, тийм үл бүтэх этгээд ч нүдний гэм дээ!

— Хөөрхий! Тэр шударга хүн. Түүнийг мухар сүсэгтнүүд л алж байгаа юм.

— Түүнийг зөвтгөх гэж таныг оролдохгүй болов уу гэж бодож байна. Түүнийг цагаатгаад байх юм үгүй.

— Тийм ээ, иргэн Блез, түүнийг цагаатгаад байх юм үгүй.

Иргэн Блез, үзэсгэлэнт Деманн мөрийг алгадан

— Цаг өөр болсон. Конвент, хөөгдөгсдийг сөөрөг нь дуудаж байгаа одоо үед таныг «Барбару» гэж дуудаж болно, мэдэж байна уу, Деман, ямар бодол толгойд минь оров гээч? Шарлотта Кордийн хөргийг барлаадхаач гэв.

Мухлагт, үстэй дээл өмссөн, хар үстэй, нуруулаг сайхан бүсгүй орж ирээд иргэн Блез рүү найрсгаар толгой дохив. Энэ бол Жюли Гамлен байсан авч тэрээр энэ бузар овгоор овоглохоо хэдийнээ болиод бэлэвсэн бүсгүй Шассань гэж өөрийгөө нэрлэсэн бөгөөд дээлийнхээ дотуур нь алан хядлагын үеийн улаан цамцатны дурсгалд зориулсан улаан бошинз өмсжээ.

Ахтай нь хамаатай аливаа юм түүний жигшлийг төрүүлэх тул эхлээд Жюли, Эваристын дурлалт бүсгүйд нэг л төдгүй байдаг байв. Гэвч Блез бүсгүй Эваристыг үхсэний дараа золгүй эхийг «Амур - зураачийн» дээвэр дор хоргодуулж байлаа. Эхний үед Жюли мөн тэнд толгой хавчуулж байгаад Ломбардын гудамжнаа гоёмсог мухлагт ажил олжээ. «Цаазлагдагсдын» маягаар үсээ ахарлан тайрсан ба язгууртны намба гашуудлын хувцас нь сээхэлзүүр залуусын талархлыг татаж байв. Роза Тевененд бараг хаягдсан Жан Блез түүнийг гоц анхааран үзэж эргүүлэх болсонд Жюли дургүйцсэнгүй болно. Урьдын эмгэнэлт өдрүүдийнх шиг Жюли эрэгтэй хүний хувцас өмсөх дуртай хэвээр агаад хээнцэр фрак захиалаад том таяг барин ямар нэг гуанзанд танил оёдолчинтойгоо хоол идэхээр Севр буюу Медон руу очдог байв. Зориг чангатай Жюли нэрийг нь зүүж яваа залуу тайжийн нас барсны дараа тайтгарч яагаад ч чадахгүй уур хилэнгээ гаргаж л уй гашуугаа жаал зугаа нимгэлдэг агаад якобинчдыг харахдаа зорчигчдоос тонилгохыг шаардан тухирна. Эхээ тун бага харж хандах бөгөөд цаадах нь ч оромждоо өдөржин эрх имрэн сууна. Хүүгээ эмгэнэлтэйгээр амь үрэгдсэнд балмагдсан авгай зовлонгоо мэдэхээ ч байжээ. Роза ч «хойд эхтэйгээ» сайн таараад байдаг Элодитой дотно үерхэх болов.

— Элоди хаа байна? гэж Шассань бүсгүй лавлав.

Жан Блез толгой сэгсрэв. Тэрээр охиныхоо хаа байгааг хэзээ ч мэддэггүй бөгөөд үүнийгээ ёс мэт чанд баримталдаг билээ.

Монсод орших англи цэцэрлэгтэй жижигхэн байшинд Роза Тевенен сууна. Жюли, Элодитой тийш очихоор эднийхээр орсон юм санж.

Консьержерт хоригдож байхдаа Роза Тевенен армид хоол хүнс тушаадаг томхон хүн иргэн Монфортой танилцжээ. Жан Блез хөөцөлдөж байж түүнийг суллуулсанд хүүхэн өөрөө иргэн Монфорыг шоронгоос гаргаж чадсан хийгээд цаадах нь Рошийн гудамжнаа Тиволийн ойролцоо орших бяцхан харшийг түүнд бэлэглэжээ. Энэ харш өндөр үнэтэй байсан боловч Монфор зэргэлдээ газрыг нь илүү үнээр арилжиж бүх зарлагаа нөхсөн учир түүнийг сул авсан гэж хэлж болно. Жан Блез томоотой хүн болохоор хориг тавьж хүч хүрэхгүй зүйлтэй эвлэрэх хэрэгтэй гэж бодоод Роза Тевененийг Монфорт хэрүүл шуугиангүй найр тавьж өгчээ.

Жюлийг мухлагт ирсний дараахан нүдээ бүлтийтэл гоёсон Элоди дээрээс бууж ирлээ. Хэдийгээр хүйтэн байсан ч тэрээр үстэй дээл

дотгуураа цагаан нэхмэл эдээр хийсэн задгай даашинз өмссөн бөгөөд царай нь цайж бэлхүүс нь нарийсан нүд нь тормолзон гэрэлтэх ба ер нь бие цогцос нь тачаангуйн байдлыг илтгэж байлаа.

Хоёр хүүхэн, тэднийг хүлээж буй Роза Тевененийх рүү явав. Деман тэдэнтэй нийллээ. Жүжигчин хүүхэн гэрийнхээ тавилгыг янзлахдаа түүний зөвлөгөөнийг авдаг байжээ. Харин залуу эр Элодид дурласан юм санж. Элоди ч хүлээх зовлонгоос нь түүнийг ангижруулахаар бараг шийдсэн байлаа. Хувьсгалын талбайд цаазлуулагсдыг булаад шохойгоор дарсан Монсо гудмаар өнгөрөхдөө Жюли

— Одоо хүйтэн байхад ч дажрахгүй ээ, харин хавар л үхдэлийн үнэр танар хотын ихэнхээр тарах болно доо гэж дуугарав.

Роза Тевенен найз нараа эртний маягаар зассан зочдынхоо өрөөнд хүлээж авав. Бүх зөөлөвчит бандан, түшлэгт сандлыг Давидын зургаар гоёсон ажээ. Хөшөө, баримал, алтан өнгөөр будсан гэрэвчний дээр туурганаа ромын сийлбэрээс нэгэн өнгөөр хуулбарлан хийсэн сийлбэр өлгөжээ. Мөн жүжигчин хүүхэн шав шар, долгиотсон хиймэл үс хийсэн байна. Тэр үед хиймэл үсэнд амь тавьдаг байсан агаад хуримын сагснаа зургаа, арван хоёр, арван наймаар нь хийдэг байжээ. Биеийг нь барьсан бачуу «капридин» маягийн даашинз өмссөн байлаа.

Дээлээ хэдрээд тэрээр хоёр найз болон барлагчийг Ледийн төслийн дагуу засаж байгаа боловч нүцгэн мод зоргодос овоолсон цэцэрлэгт дагуулан оров. Түүгээр зогссонгүй тэрээр, Фингаловын агуй готын хонхтой суварга дуган үзүүлэв.

— Энд гээд тэрээр санаа алдсанаа хэсэг гацуур руу дагуулан очиж, би хувьгүй Бротто дез Илеттийн дурсгалд пайлуур босгох гэсэн юм сан. Түүнд би зүгээргүй сайн байсан билээ. Тэр бол сэтгэл татам хүн байсан юм. Яргачид түүнийг хороож би мөн ч их нулимс урсгасандаа. Деман, та надад баганан дээр бумба зурж өгөөрэй гэснээ тэр дороо нэмэн

— Муухай юм... энэ долоо хоногт би найр хийе гэсэн боловч бүх хийлчдийг гурван долоо хоногийн урьд өөр газар урьчихсан байх юм. Тальен хүүхнийд орой бүр бүжиг наадам болдог юм гэж өгүүллээ.

Үдийн хоолны дараа Роза Тевенений сүйхээр гурван найз Демантай хамт Фейдо театрт очив. Тэнд «эртний» буюу «хохилогчдын» маягаар үсээ самнасан том ухлаадастай алтан одтой гал улаан буюу цагаан даашинзтай хүүхнүүд, өндөр хар захтай,

эрүүгээ халхалсан өргөн цагаан зангиатай харчуул зэрэг Парисын гангачуул цөм цугларсан байлаа. Тэр орой «Федра», «Цэцэрлэгчийн нохой» гэдэг жүжгүүд тавьжээ. «Ард түмэн сэрсэн нь» гэдэг хээнцэр сээхэлзүүр залуусын дуртай дууг дуулахыг танхим даяараа шаардаж байлаа.

Хөшиг нээгдэн тайзан дээр пагдгар тарган эр гарч ирсэн нь алдарт жүжигчин Лаис байжээ. Сайхан төв хоолойгоор тэр

Францын ард түмэн, бид цөм ахан дүүс ээ!

гэж дуул ав.

Гэрэвчний болор унжлага хангинан жингэнэтэл нижигнүүлэн алга таших нь сонсогдлоо. Дараа нь үл ойлгогдох гүнгэнэсэн дуу гаран дугуй бүрх малгайтай иргэн үзэгчдийн суудлаас

Хонгор сайхан эх орны минь хөвгүүд, урагшаа!...

гэж «Марсельчуудын сүлд дууг» дуулан хариулав.

Түүнийг гүйцэд дуулуулсангүй, исгэрэх хашхиралдах нь сонсогдлоо.

— Алан хядагсад сөнөтүгэй! Якобинчуудыг эрлэгт нь тонилго!

Тэгээд Лаисыг дахиулсанд тэрээр термидорчуудын сүлд дууг дахин дуулав.

Францын ард түмэн, бид цөм ахан дүүс ээ!

Бүх театрын үзэгчдийн танхимд баганан дээр буюу эсвэл суурин дээр Маратын баримлыг тавьсан байсан юм. Фейдо театрт энэ баримал тайзны өмнөх хайсны хоёр талын хүнхрийн нэгэнд байгаа суурин дээр сүндэрлэн байлаа.

Найрал хөгжим «Федра, Ипполит хоёрын» удиртгалаас тоглож байх зуур нэг хээнцэр залуу таягийнхаа үзүүрээр баримлыг заан

— Марат сөнөтүгэй! гэж хашхирсанд

— Марат сөнөтүгэй! Марат сөнөтүгэй! гэж танхим дүүрэн тосон авлаа.

Нийтийн хашхиралдаан дундаас

— Энэ баримал энд байсаар байгаа нь шившигтэй хэрэг.

— Шившигт Марат хааяагүй ноёрхсоор байдаг нь ичмээр ажээ.

Түүний баримлын тоо түүний цаазлахыг хүсэж байсан толгойноос ч

цөөнгүй билээ.

— Хорт бах!

— Барс!

Хар могой! гэх тод дуун ялгаран сонсогдож байлаа.

Гэнэт нэгэн дэгжин эр хажуу суудлын сэртэн өөд авиран гарч баримлыг түлхэн унагалаа. Бүх үзэгчдийг суудлаасаа босон зогсож

Францын ард түмэн, би цөм ахан дүүс ээ!

гэж «Ард түмэн сэрсэн нь» гэдгийг дуулан алга ташиж байх зуур гөлтгөнийн хэлтэрхийнүүд хөгжимчдийн толгой дээр ойчив...

Ихээхэн сэтгэл хөөрсөн дуучдын дотор прокурорын бичээч, анх дурлалаа зориулж явсан сайхан залуу Анри нь байхыг Элоди үзэв.

Шийний дараа Деман сүйх дуудан Элоди бүсгүйг «Амур — зураачид» хүргэж өглөө.

Сүйхэнд ороод залуу эр Элодийн гарыг хоёр гараараа атган

— Элоди, намайг өөртөө хайртай гэдэгт итгэдэг үү? гэлээ.

— Та хүүхэн бүрд дуртай болохоор итгэдэг.

— Тэднийг бүгдийг нь орлож чадаж байгаа болохоор танд л хайртай.

Бүсгүй инээмсэглэн

— Одоогийн маягийн хар, шаргал, хонгор хиймэл үст бүх хүүхнийг орлохоор шийдвэл ч тун ч төвөгтэй юм болох сон гэв.

— Элоди, андгайлъя танд...

— Юу? Андгай гэнэ ээ, иргэн Деман? Та намайг гэнэн юм гэж бодож байна, эсвэл та өөрөө дэндүү гэнэн хүн юм.

Деман хариулах үгээ олсонгүй, бүсгүй надад ухаан алджээ гэж сэтгэл хангалуун бодов.

Хуулийн гудамжны өнцөгт дуулах хашхиралдах чимээ сонстон ямар нэгэн улс сүүтгэнэн гүйлдэж байлаа. Эд бол Францын театраас гараад Ардын нөхрийг дуурайлгасан мануухайг шатааж байгаа хэсэг залуус ажээ.

Оноре гудамжнаа дэнлүүнээс өлгөсөн Маратын шог зурагт дэлбэгчийн малгай тээглэчхэв.

Сэтгэл хөгжсөн дэлбэгч суусан улс руугаа эргэн урьд өдөр нь Монторгейль гудамжны цувдайны худалдагч «Үүнийг л энэ ертөнц дээр юунаас ч илүү хүсэж байсан юм» гэж өгүүлэнгээ Маратын баримлыг хэрхэн цусаар будсан, дараа нь арваад насны хүүхдүүд

түүнийг нь муу усны шуудуу руу хэрхэн хаясан, мөн тэнд байсан иргэд «Түүний Пантеон нь энэ» гэж хэрхэн хашхирч байсныг ярив.

Тэдний хажуугаар нь өнгөрсөн бүх ресторан, бүх нимбэгийн усны газарт улс амьтан

Францын ард түмэн, бид цөм ахан дүүс ээ!

гэж дуулалдаж байлаа.

«Амур - зураачийн» үүдэнд ирээд Элоди сүйхнээс үсрэн бууж
— Баяртай! гэлээ.

Гэтэл залуу эр, өмнө нь хаалгаа хаачих зүрх даанч байхгүй биз гэж тун ялдам, тун шаргуу, тэгсэн мөртөө тун төлөв гуйж гарав.

— Орой болжээ. Би таныг түр оруулья гэж бүсгүй өгүүллээ.

Унтлагын хөх өрөөнд Элоди дээлээ тайлж хаяад биеийн нь илч шингэсэн «эртний» бариу цагаан даашинзтайгаа үлдэв.

— Та даарч байна уу. Түлш бэлхэн, гал түлээдэхье гэж бүсгүй хэллээ.

Тэрээр гал ноцоон асаж буй зомголыг зууханд хийв.

Хүчтэй гэдгээ илтгэн Филипп, Элодийг эелдэг бөгөөд болгоомжтойхон тэвэрсэн нь бүсгүйд нэг л онцгой сайхан санагдав. Үнсэн таалахад нь эсэргүүцэхгүй шахуу байсан хүүхэн гэнэт залуугийн гараас мултран гарч

— Намайг тавь! гэлээ.

Зуухны толины өмнө зогсон малгайгаа авснаа бүсгүй солгой гарынхаа ядам хуруунд зүүж яваа Маратын балрах дөхсөн хавтгай дүртэй жижиг мөнгөн бөлзгийг гунигтайяа харав. Нүднээсээ нулимс мэлмэрэн цийлэлзтэл түүнийгээ ширтсэнээ хуруунаасаа авч галд шидэв.

Гагцхүү үүний дараа л доголон нулимстай инээмсэглэнхэн янаглал хайраасаа улам ч хөөрхөн болсон тэрээр Филиппийн элгэнд ухасхийн наалдлаа.

Блез бүсгүй өрөөнийхөө хаалгыг амрагтаа нээж өгөн


— Хайрт минь, баяртай! Эцэг минь одоо ирнэ. Хэрвээ шатан дээр хүний хөлийн чимээ гарвал дээд давхар өөд өгсөж гараад алив аюул өнгөрлөө гэдэгт итгэхээс нааш бүү буугаарай. Доор хаалгач хүүхний цонхыг гурав тогшиход тэр чамайг гадагш гаргана. Баяртай амраг минь! Баяртай, амин сүнс минь! гэж харанхуйн дунд шивнэх үед хэдийнээ шөнө дүл өнгөрсөн байлаа.

Зуухан дахь нүүрс шатаж дуусав. Аз жаргалтай, алжааж ядарсан
Элоди дэрэн дээрээ толгойгоо аяархан тавилаа.

*

**

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.



Өглөгийн эзний сонорт

×

Та манай номын санд хандив өргөж болно.

Таны хандивласан мөнгө:

- Хэвлэгдсэн номыг цахим хэлбэрт оруулах
- Цахимд оруулсан номыг ариутган шүүх
- Цахим технологийн тоног төхөөрөмж авах
- Цахим номын санг өргөжүүлэх
- Цахим номын сангийн чиглэлээр судалгаа хийж, сурч байгаа оюутан судлаачийг дэмжихэд зарцуулагдана.

Хандив өргөх данс "Хаан банк" 5027 8982 35 (төгрөг) ЦОГТ ОХИН ТЭНГЭР САН

Орау

1969 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл

АНАТОЛЬ ФРАНС

УНДААССАН БУРХАД

УЛСЫН ХЭВЛЭЛИЙН ГАЗАР
УЛААНБААТАР-1969

Орчуулсан Г. Аким
Редактор Г. Амар

Уран сайхны редактор Г. Актив
Зураач Б. Түмэннасан
Техн. редактор Т. Тогтох
Хянагч Д. Болд, Д. Цэгмэд

Өрөлтөд 23/11 1968.
Хэвлэлтэд 23/11 1969

Цаасны хэмжээ 84X108 1/32.
Хэв. хуудас 17
Хэв нэгж хуудас 28,56

Хэвлэсэн тоо 10 000

Хэв. газ. № 210/68.
Зах. №433

Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн комбинат.
Улаанбаатар, Сүхбаатарын талбай 2

Заметки

[←1]

К о р д е л ь е р ү ү д — «Хүн болон иргэний эрхийн нийгэмлэг» гэдэг улс төрийн клубийн гишүүд

[←2]

Варенны дараа — 1791 онд францын хувьсгалыг дарах зорилгоор XVI Людовик ван гадаадад зугтах гээд чадалгүй Варенн хотноо баригджээ. Энд тэрхүү үйл явдлын дараа гэсэн утгаар хэрэглэгдсэн байна

[←3]

Эпикуреизм — Эртний Грекийн гүн ухаанч материалист эпикурьен сургаал

[←4]

Пагавота — Францын хуучны бүжиг

[←5]

Апокалипс — Библийн судрын нэг юм. Үүнд «Галав юүлэх» тухай өгүүлсэн байдаг. Энд энэ сударт гардаг аймшигт араатан шиг гэсэн утгаар хэрэглэгджээ

[←6]

Хоёр Брут — Брут Люций Юний - Ромын Бүгд Найрамдах улсыг үндэслэгч. Түлхэгдэн унасан хаант засгийг сэргээх гэж хүүхдүүдийнхээ оролдож буйг мэдмэгцээ тэднийг цаазаар авах ял заажээ. Брут Мрак Юний Юлий Цезарийн эсрэг хуйвалдаан хийгчдийн нэг, Цезарь нь түүний өргөж авсан эцэг нь байжээ.

[←7]

Нигүүлсэнгүй гэсэн үг. Эртний Грект өшөөний охин тэнгэр Эринийг тэгж нэрлэдэг байсан аж